

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

УЛААНБААТАР ХОТ 2022 ОН

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2022 оны жилийн эцсийн байдлаар/**

2022 оны 12 дугаар сарын 29

Улаанбаатар хот

№	Агуулга	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь						ХУВЬ
				100	90	70	50	30	0	
1	“КОВИД-19” ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО	6	15	13	2					98.67
2	ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	24	42	27	12	1		2		93.10
3	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	24	40	28	7	2	1	2		92.0
4	ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	18	65	40	21	2	2			94.30
5	НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	6	8	3	5					93.75
6	НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	6	6	4	1			1		86.67
Дүн		84	176	115	48	5	3	5		93.58

№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2022 онд хүрэх түвшин, үр дүн	2022 онд санхүүжигдэх төсөв /сая.төг/	Хариуцах байгууллага	Үнэлгээний хувь	
НЭГ. "КОВИД-19" ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО						
1.1. "Ковид-19" халдварт цар тахлын халдвар болон мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, дүүргийн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, иргэдийн эрүүл аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.	1	1.1.1. Дүүргийн хэмжээнд халдваргүйжүүлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагууд, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийн судалгааг гаргаж, бэлэн байдлыг хангуулах. Халдваргүйжүүлэлтийн үр дүнг үнэлэх, халдваргүйжүүлэлтийн бодис, ажлын уусмалын чанар, аюулгүй байдалд шинжилгээтэй хяналт хийх, зөвлөн тусална.	100% Хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн байна. Халдваргүйжүүлэлтийн бодис, ажлын уусмалын үр дүнг үнэлсэн байна.	0.5	МХХ, ЭМТ	100
<p>БИЕЛЭЛТ: "Ковид-19" халдварын эсрэг дархлаажуулалтын цэгүүдэд халдвараас сэргийлэх, дахин хэрэглэдэг багаж тоног төхөөрөмж, ариутгалын тасгуудыг стандартын дагуу ариутгаж, эмнэлгийн орчны цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг заавар журмын дагуу хийж гүйцэтгэсэн. Ажин-Үжин ХХК-иар Нэгдсэн эмнэлэг, гэмтэл мэс заслын тасгуудын орны хөнжил, гудас, матрасыг дезкамер /озон/-аар халдваргүйжүүлэлт хийлгэсэн. Коронавируст халдвараас сэргийлэх зорилгоор салбар амбулаториудад мэргэжлийн ариутгагч 7 хоногт 2 удаа, Нэгдсэн эмнэлгийн ногоон бүсэд 7 хоногт 3 удаа агаарт мананцар үүсгэж, агаарын халдваргүйтгэлийг /хлорсепт-17, жавелион/-оор тогтмол хийж байна. Эрүүл мэндийн төвд шаардлагатай халдваргүйтгэлийн бодисын нөөцийг шинэчлэн гарган Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон холбогдох дээд шатлалын байгууллагад танилцуулсан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/59, А/105 тоот тушаал, Монгол Улсын Засгийн Газрын хуралдаанаас гаргасан тэмдэглэлийн дагуу дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсээс хяналт шалгалт хийгдээгүй байна.</p>						
	2	1.1.2. Тархвар зүйн зураглалын дагуу болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	100% Халдваргүйжүүлэлтийн үр дүнг үнэлнэ. Бэлэн байдал хангагдана.	7.0	МХХ, ЭМТ	100

		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс салбар амбулатори, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн 16 төвүүдэд Зооноз Өвчин судлалын үндэсний төв, Цасны чихэр ХХК тархвар зүйн зураглалын дагуу голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг өдөр тутам болон хуваарийн дагуу 7 хоногт 2 удаа хийж гүйцэтгэсэн. Улсын Онцгой Комиссын даргын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 10964 тоот албан бичиг, ЭМЯ-ны сайдын 2021 оны А/747, А/562 тоот тушаал, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас гаргасан тэмдэглэлийн дагуу Мэргэжлийн хяналтын хэлтсээс хяналт шалгалт хийгдээгүй.</p>			
3	<p>1.1.3. Тусгаарлах байруудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, голомтын болон байнгын халдваргүйжүүлэлтийн үр дүнг үнэлэх, халдваргүйжүүлэлтийн бодис, ажлын уусмалын чанар, аюулгүй байдалд шинжилгээтэй хяналт хийх, зөвлөн тусална.</p>	<p>100% Тусгаарлах байруудын үйл ажиллагаа сайжирч зөрчлийн хувь буурсан байна.</p>	2.0	МХХ, ЭМТ	100
	<p>БИЕЛЭЛТ: Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын 01/52 тоот “Тусгаарлан ажиглах байрны эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийн байдалд шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, бага тойруу Анкарагийн гудамж 19-2 тоотод байрлах “Цэлмүүн трейд” ХХК-ийн Дрийм, дүүргийн 8 дугаар хороо, Хувьсгалчдын гудамж 13 тоотод байрлах “Мон бурда” ХХК-ийн Кентавр зочид буудлын тусгаарлан ажиглах байранд 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 01 дүгээр сарын 04-ний өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 11 удаа хийсэн. Шалгалтаар тусгаарлах байрны үйл ажиллагаанд зөрчил илрээгүй бөгөөд хоолны хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын сайжруулан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/176, А/177 дугаар захирамж, Монгол Улсын Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бууруулж шар түвшинд шилжүүлсэнтэй холбогдуулан тусгаарлан ажиглах байр татан буугдсан.</p>				
4	<p>1.1.4. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт заагдсан байршилд шинжилгээ авах цэгүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, шинжилгээ авах байруудыг бэлдүүлж, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллах.</p>	<p>Цэгүүдэд ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт 100% хийлгүүлж, гадна орчинд хүн хоорондын зай бариулан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлсэн байна.</p>	4.0	МХХ, ЭМТ	100

	<p>БИЕЛЭЛТ: Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны дугаар А/199 тоот тушаалаар “Ковид-19” халдварын шууд болон дам хавьтал сайн дураараа халдвар илрүүлэх шинжилгээ өгөх төвийг байгуулж, ажиллах багийн эмч, сувилагч, үйлчлэгч, асрагч нарт халдвар хамгааллын дэглэмийн заавар зөвлөмжийг өгч ажилласан.</p> <p>Эрүүл Мэндийн Яамны сайдын 2021 оны дугаар А/59, А/105 тоот тушаал, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас гаргасан тэмдэглэлийн дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалт хийгдээгүй.</p>				
5	<p>1.1.5 Хүнсний үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, хадгалалт, түгээлт, ундны ус түгээх байруудын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хангаж ажиллаж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт хийж, халдвараас урьдчилан сэргийлэх сурталчилгаа зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.</p>	Хүнсний аюулгүй үйлдвэрлэх, нөхцөл шаардлага хангагдана.	5.0	МХХ, ХХҮХ	
<p>БИЕЛЭЛТ: 1. Цагаан сар, Эх үрс, Үндэсний их баяр наадмыг угтсан урьдчилан сэргийлэх шалгалтаар 74 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс 17 дээж авч Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн Төв лаборатори, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын лабораторид шинжилгээнд хамруулахад лабораторийн шинжилгээний дүнгээр стандарт, аюулгүй байдлын шаардлага хангаж, шалгалтын явцад нийт 55 зөрчил илрүүлж, 28 зөрчлийг арилгуулан ажиллалаа.</p> <p>Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 02-03/2119 дугаартай зөвлөмж, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын 02-20/18 дугаартай мэдэгдлийг 328 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэн, 111 иргэнийг хамруулан 2 удаагийн сургалт зохион байгуулж, 54 аж ахуйн нэгж байгууллага, 299 иргэнд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 1 сэрэмжлүүлэг, 5 зөвлөмж боловсруулан олон нийтийн сүлжээнд байршуулсан.</p> <p>2. Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын тэргүүн дэд даргын 01/17 дугаартай “Ундны усны чанар аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийх тухай” удирдамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй УСУГ-ын харъяа Зөөврийн ус түгээх албаны гэр хорооллын ус түгээх цэг 3, төвлөрсөн усан хангамжийн 19 хэрэглэгчийн цэгээс 238, шинээр баригдсан барилгын төвлөрсөн шугамын ус 2, иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшлийн гүний өрмийн худгийн ус 4, УСУГ-ын харъяа зөөврийн ус хангамжийн ус түгээх байр 11, шугамын ус хангамжийн ус түгээх байр 26, булаг шанд, голын ус 2 нийт 45 цэгээс 90 дээж авч Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Нэгдсэн төв лабораторид шинжилгээнд хамруулахад 96,5 хувь нь стандартын шаардлага хангасан талаар улсын байцаагчийн 3 дүгнэлт гарган ажиллав. Нян судлалын шинжилгээгээр гол, булаг шанд, гүний худгийн усанд 1 мл-т бичил биетний ерөнхий тоо 3.5%-р их гарсан нь стандартын шаардлага хангаагүй</p>					100

		тул цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийлгэн, давтан шинжилгээнд хамруулав.				
1.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.	6	1.2.1. Коронавируст халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, эмнэлгүүдэд ажиллаж буй коронавируст халдвар /КОВИД-19/-ын түргэвчилсэн оношилгооны цэгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Бэлэн байдлын зэрэг 100% хангагдана.	2.0	МХХ, ЭМТ	100
	БИЕЛЭЛТ: Коронавируст /Ковид-19/ халдварын шинжилгээний сорьц авах нэгжийг дүүргийн Нэгдсэн эмнэлгийн дэргэд зөөврийн байранд байгуулан ажиллаж байна. Сорьц авах цэгийн үйл ажиллагаанд дүүргийн нэгдсэн эмнэлгийн зүгээс тогтмол хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 6560 хүнд түргэвчилсэн шинжилгээ хийхэд эерэг 1215, сөрөг тохиолдол 5345 байна. Эрүүл Мэндийн Яамны сайдын 2021 оны А/59, А/105 тоот тушаал, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас гаргасан тэмдэглэлийн дагуу дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсээс хяналт шалгалт хийгдээгүй.					
	7	1.2.2. Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн харилцаа болон хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулна.	Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, ажилтнуудын хууль тогтоомжийн мэдлэг мэдээлэл нэмэгдэж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйд хандах хандлага сайжирч эрсдэл буурна.	2.0	МХХ, ХХҮХ, ХөХҮХ	100
	БИЕЛЭЛТ: 1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сар 2022” аяны хүрээнд холбогдох хууль тогтоомжийг хангуулах, болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, тэдгээрээс үүсэж болох хор хохирлыг багасгахад чиглэгдсэн төрийн байгууллага салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ба хөдөлмөрийн эрүүл ахуйн зохистой дадал”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж зөрчсөний улмаас хүний биед гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх” сургалтыг “Сэнтүри” ХХК-ийн 35, “Тохижилт үйлчилгээ” ХХК-ийн 52 ажилтныг хамруулан зохион байгуулав. Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн харилцаа болон хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар нийт 18 сургалтад 1077 хүн, 246 байгууллагыг хамруулж, 12000 иргэдэд мэдээлэл, сурталчилгаа хийсэн.					
1.3. Халдварт цар тахлын эрсдэл нэмэгдэхээс урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээний нөөцийн	8	1.3.1. Засаг даргын нөөц сангийн бэлэн байдлыг хангах, бусад нөөцийн судалгааг цагийн байдалд тохируулан хурдан шуурхай хийж гүйцэтгэнэ.	500,0	-	ТЗУХ, СТСХ, ОБХ	100

<p>бэлэн байдлыг хангах, түүнд зарцуулах төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.</p>		<p>БИЕЛЭЛТ: Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу урьдчилан төлөвлөж, төсөвт тусгах боломжгүй жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээнд зориулан 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Засаг даргын захирамжаар 500.000.000 (таван зуун сая) төгрөгөөр баталсан бөгөөд нөөц сангаас 174,927,600 (нэг зуун далан дөрвөн сая есөн зуун хорин долоон мянга зургаан зуу) төгрөгийг шийдвэрлүүлэн зарцуулан ажилласан. Дүүргийн Онцгой комисс нийт 6 удаа хуралдаж, нийт 27 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд дүүргийн Засаг даргын захирамж 27, Онцгой комиссын даргын албан даалгавар 4, Онцгой комиссын даргын тушаал 2, Онцгой комиссын хурлын тэмдэглэлийг 6 удаа гаргаж хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Дүүргийн Засаг даргын батлагдсан нөөц хөрөнгийн зарцуулалт 34.9 хувьтай байна.</p>				
<p>1.4. Цар тахлын тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, туршигдсан вакцинаар хангах асуудлаар холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллана.</p>	9	<p>1.4.1. Дүүргийн зорилтот хүн ам болон нэн шаардлагатай албан хаагчдыг “Ковид-19”-ийн дархлаажуулалтад бүрэн хамруулна.</p> <p>БИЕЛЭЛТ: Аж ахуй нэгж байгууллагын ажилтан, сургуулийн сурагч, оюутны судалгааг гарган зах худалдааны төвүүд, дүүрэг байршил харгалзахгүй их дээд сургуулийн хичээлийн байр, дотуур байрыг түшиглэн дархлаажуулалтын цэг байгуулж, зорилтод бүлгийн 12 наснаас дээш 113755 хамрагдахаас дархлаажуулалтын 1-р тунд 109,892 хүн буюу 99 хувь, 2-р тунд 98,971 хүн буюу 89 хувьтай хамрагдсан. Дархлаажуулалтад 3-р тунд 49,384 хүн хамрагдаж 53 хувьтай, 4-р тунд 7,232 хүн хамрагдан 9%-тай байна. Дүүргийн 12-17 насны хүүхдийн 1-р тунд 7288 хүүхэд 60 хувь, 2-р тунд 6569 хүүхэд 90 хувьтай байна. Мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн халдварын эсрэг 1-р тунгийн хамрагдалт 29,5 хувь, 2-р тунгийн хамрагдалт 24,8 хувьтай байна. Дүүргийн хэмжээнд 5-11 насны хүүхдийн 1-р тунд 46, 2-р тунд-9 хүүхэд хамрагдсан байна. ЧД-ийн Цагдаагийн хэлтэс 1 тун 390, 2 тун 380, 3 тун 330, Онцгой байдлын хэлтэс 1 тун 38, 2 тун 38, 3 тун 26, мэргэжлийн хяналтын хэлтэс 1 тун 26, 2 тун 26, 3 тун 19, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага 1 тун 380, 2 тун 320, 3 тун 240 албан хаагч тус тус хамрагдсан байна. Мөн дархлаажуулалтын дараах урвалыг тандаж хариу арга хэмжээ авч мэдээлэн ажиллалаа. Дархлаажуулалтын байнгын 22 цэгээр 186399, түр 8 цэгээр 21897, явуулын 6 цэгээр /автобус/ 2285 иргэнийг тус тус хамруулан ажилласан.</p>	100%	-	НХХ, ЭМТ, ОБХ, ТЗУХ	90
	10	<p>1.4.2. Цар тахлын халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, нөөцийг хангах, тандалт, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.</p> <p>БИЕЛЭЛТ: Ковид-19 халдвартай иргэдийг хэвтүүлэн эмчлэх ор дэлгэсэн байсныг Эрүүл мэндийн сайдын тушаалаар 2 сард татан буулгаж, ЭМС-ын А/547 тоот тушаалаар шинж тэмдэгтэй иргэдээс шинжилгээг авахаар зохион байгуулсан ба 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар “Ковид-19” халдварт цар тахлын шинжилгээг дүүргийн Нэгдсэн эмнэлгийн дэргэд зөврийн байранд шинжилгээний сорьц авах нэгжийг байгуулан, шинжилгээний цэг өдөр бүр 09:00-12:00 цагийн хооронд, дархлаажуулалтын цэгүүд болон амралтын өдрүүдэд төлөвлөлтийн дагуу ажиллаж байна. ЭМС-ын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн амбулатори ажиллуулах тухай” 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд цар тахлын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах зорилгоор Хайлааст хүүхдийн салбар “Коронавирусын халдвар”-тай иргэдэд эмнэлгийн үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж, дотрын эмч, хүүхдийн эмч, дүрс оношилгооны эмч,</p>	100%	500.0	ДОК, НОК, ЭМТ	100

		бүртгэлийн ажилтан, үйлчлэгч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр амбулаторийн “УЛААН БҮС”-д ажиллаж 1133 насанд хүрэгчид, 275 хүүхдэд, 1408 хүнд тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Халдварын дэгдэлт буурсантай холбоотойгоор Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвд Ковидын амбулаторийг шилжүүлэн ажиллаж, цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан НЭМГ-аас Ковидын амбулаторийн үйл ажиллагааг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс татан буулгасан.				
	11	1.4.3. Цар тахлын тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, туршигдсан вакцинжуулалтын явцад вакцины хадгалалт, тээвэрлэлт, вакцинжуулалтын үеийн халдвар хамгааллын байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Вакцин тээвэрлэлт, вакцинжуулалтын үеийн бэлтгэл бэлэн байдал 100% хангагдана.	2.0	МХХ, ЭМТ	100
		БИЕЛЭЛТ: Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны А/642 “Коронавируст халдварын нэмэлт тунг эрчимжүүлэх тухай” тушаал, УОК, НОК, ДОК-ын үүрэг даалгаврын дагуу Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтыг ЧДЭМТ-ийн цэг, 7, 19, 11 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан вакцинжуулалтад хамруулж байна. Нийт 13 удаагийн татан авалтаар 2022 оны 11 сарын байдлаар 23050 хүн тун вакциныг ХӨСҮТ-ийн Төв агуулахаас захиалан аван дархлаажуулалтын цэгт хүргүүлсэн. ЭМЯ-ны сайдын 2021 оны А/59, А/105 тоот тушаал, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаас гаргасан тэмдэглэлийн дагуу хяналт шалгалт хийгдээгүй.				
1.5. Халдварын улмаас сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тогтоож, боловсролд зориулсан зардлыг урьдчилан тооцно.	12	1.5.1. Их дээд сургууль, Ерөнхий боловсролын сургуулийн оюутны дотуур байрны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	100%	1.0	МХХ, БХ	100
		БИЕЛЭЛТ: Дүүргийн Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн дотуур байранд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 240 оюутан, сурагчид амьдарч байна. Үүнээс: СУИС /Бадмаараг/ 37, “Бэтүб-112” шашны сургууль 39, Хөдөлмөрийн дээд сургууль 26, Улаанбаатар Эрдэм их сургууль 26, Барилгын коллежид 124 оюутан, сурагчид байна. Дотуур байрны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, цэвэрлэгээ, үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмолжуулах, дотоод хяналтын сайжруулах зөвлөмж, зааварчилгааг 3 удаа өгч ажилласан. Их дээд сургууль, МСҮТ, ЕБС, СӨББ-ын сургалтын үйл ажиллагааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн танхимын хэлбэрээр явуулах болсонтой холбогдуулан УОК-ын Шуурхай штаб, МХЕГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/49 дугаар захирамжаар ажлын хэсэг 5 их дээд сургууль, 1 МСҮТ, 27 ЕБС, 50 СӨББ, нийт 83 сургалтын байгууллагын халдваргүйжүүлэлт хийгдсэн эсэх, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн бодисын нөөц, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдал, цэцэрлэгийн хүүхдүүдийн эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдалт, анги танхим, сургалтын орчны эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангуулахаар мэргэжил арга зүйн				

		<p>зөвлөгөө, зааврыг өгч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын тушаалаар байгуулсан ажлын хэсэг 2022 оны 08 дугаар сард төрийн болон төрийн бус өмчийн 26 сургууль, 50 цэцэрлэгт “Орчны эрсдэл”-ын үнэлгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.</p> <p>Мөн БЕГ-аас зохион байгуулсан аймаг, дүүргийн дотуур байрны багш нарын сургалтад 2 багш, 2 менежер хамрагдсан.</p> <p>Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын “2022-2023 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгах тухай” 01/91 дүгээр удирдамжаар дүүргийн ЕБС-ийн 16, СӨБ-ын 14, хүнсний хангамжийн 1, сургалтын 16 нийт 47 байгууллагад шалгалт хийж, нийт 29 сургалтын байгууллагын ундны уснаас дээж авч, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Нэгдсэн төв лабораторид хүргүүлж, шинжилгээний дүнг үндэслэн улсын ахлах байцаагчийн 25 дүгнэлт, 1 цэцэрлэг, 3 ЕБС-д албан шаардлага хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажилласан.</p>			
	<p>13</p> <p>1.5.2. Халдварын улмаас сургууль завсардалтад өртөж болзошгүй сурагчдын судалгаа хийн нэгтгэж, холбогдох байгууллагад хүргүүлж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>1</p>	<p>-</p>	<p>БХ, НХХ, СТСХ</p>	<p>100</p>
<p>1.6. Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад иргэд, аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн дэмжлэг, тусалцааг нэмэгдүүлэх чиглэлээр олон төрлийн арга хэмжээг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.</p>	<p>14</p> <p>1.6.1. Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ.</p>	<p>60</p>	<p>-</p>	<p>ХХҮХ, НЗАА</p>	<p>90</p>
				<p>БИЕЛЭЛТ: Боловсролын мэдээллийн нэгдсэн системд 2022-2023 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн 28 сургуульд 35443 хүүхэд суралцаж байгаагаас 1 дүгээр ангид 2863 сурагч шинээр элсэн суралцаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын дагуу “Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” ажлын хүрээнд төрийн болон төрийн бус өмчийн 54 цэцэрлэгт 9117 хүүхдийг 100 хувь хамруулж бүртгэсэн. Мөн 2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд СӨББ-ын удирдлага багш, ажилтан, ЕБС-ийн бага ангийн багш, хоол үйлдвэрлэл эрхэлдэг нийт 512 ажилтныг эрүүл мэндийн үзлэгт, цэцэрлэгийн 9117 хүүхдийг цагаан хорхой, шээсний шинжилгээнд хамруулсан. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд төрийн өмчийн 37 цэцэрлэгийн 2-5 настай хүүхдүүд 78%, Ерөнхий боловсролын сургуулиудын 6-12 дугаар ангийн сурагчид 74% хамрагдсан.</p>	
				<p>БИЕЛЭЛТ: Хүнсний зах, худалдаа, үйлдвэрлэлийн нийт 50 аж ахуйн нэгжтэй хүнсний нөөц нийлүүлэхээр байгуулсан гэрээнд 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр тодотгол хийж баталгаажуулан хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нөөцийн судалгааг авч нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлж ажиллалаа.</p> <p>Дүүргийн Онцгой комиссын өгсөн үүрэг чиглэлийн дагуу Статистикийн хэлтэстэй хамтран дүүргийн 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүдийн 16 нэр төрлийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн, 8 нэр төрлийн өргөн хэрэглээний барааны татан авалт, нөөцийн судалгааг гарган дүн шинжилгээ хийсэн. Судалгааны дүнгээр дүүргийн 7-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүдийн гол нэрийн бүтээгдэхүүний 04 дүгээр сарын дундаж татан авалтыг 01 дүгээр сарынхтай харьцуулахад гоймон 0.3%, будаа 5.4%, ургамлын тос 6.8%, малын мах 5%, төмс 0.6%, байцай</p>	

		1.2%, давс 12.8%, элсэн чихэр 4.1%, сүү 0.4%-р буурсан, өргөн хэрэглээний бараа нь аяга угаагч шингэн 0.3%, ариун цэврийн цаас 2.1%, шүдний 00 0.5%, хүүхдийн живх 3.5%-р тус тус буурсан үзүүлэлттэй байна.				
	15	1.6.2. Худалдаа үйлчилгээний байгууллага, зах, томоохон худалдааны төвүүдийн эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг нийт ААНБ-д хяналт тавьж ажиллана	-	ХХҮХ, МХХ	100
<p>БИЕЛЭЛТ: Тайлант хугацаанд 413 аж ахуй нэгж иргэнд 14 удаагийн хяналт шалгалтаар 27 зөрчил илрүүлж зөвлөн тусалж ажиллалаа. Үүнд: Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/18 дугаартай "Нийслэлийн хүн амын махны хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах талаар авах зарим арга хэмжээний тухай" тушаал, дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын баталсан удирдамж, Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын тэргүүн дэд даргын 01/50 дугаартай "Хүнсний худалдааны газруудад хадгалагдаж буй "Киндер" нэрийн бүтээгдэхүүнд тандалт судалгаа хийх", Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын 02-03/293 дугаартай "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх" тухай удирдамж, Дэлхийн тамхины эсрэг өдрийн хяналтаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийг Тамхины эсрэг өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд тус тус хяналт шалгалтыг хийж, зөвлөмж бэлтгэн байгууллагын нүүр хуудсанд байршуулан ажиллав.</p>						
ХОЁР: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
2.1. ЭРҮҮЛ МЭНД						
2.1.1. Хүн амын халдварт болон халдварт бус өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх "Эрүүл Чингэлтэйчүүд-2024" арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	16	2.1.1.1. "Эрүүл Чингэлтэйчүүд-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.	50%	600.0	НХХ, ЭМТ	90
<p>БИЕЛЭЛТ: "Эрүүл Чингэлтэйчүүд-2024" арга хэмжээний хүрээнд 2022 онд 21 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан батлуулан хэрэгжилт, явц, үр дүнг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороонд тайлагнаж, "Хангалттай" дүгнэгдсэн. Арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн боловсрол, мэдлэг олгох чиглэлээр 2 аян, 10 өдөрлөг, 70 сургалт сурталчилгаа, нийт 82 арга хэмжээнд давхардсан тоогоор 45600 иргэд хамрагдсан. Дүүргийн 14 дүгээр хороонд Эрт илрүүлгийн оношилгооны төвийг зоорины давхартай 2 давхар барилгын план зураг боловсруулах ажил, тендер шалгаруулалт хийгдэж барилгын суурь болон 1 дүгээр давхрын цутгалтын ажил эхлээд байна. Дүүргийн Эрүүл мэндийн Төв болон 16 Өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг гарган НЭМГ-т хүргүүлсэн ба ходоод, улаан хоолойн дуран, рентген болон хэт авианы оношилгооны аппаратууд захиалагдсан ирсэн.</p>						
2.1.2. Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний	17	2.1.2.1. Дүүргийн хэмжээнд дурангийн мэс заслын үйлчилгээг нэвтрүүлж тусламжийн нэр төрлийг нэмэгдүүлнэ. /Дурангийн мэс	20	300.0	ЭМТ, НХХ	90

чанар хүртээмжийг сайжруулж, эмчилгээ, оношилгооны хүчин чадал, нэр төрлийг нэмэгдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг үе шаттайгаар сайжруулж, ажилтан, албан хаагчдын хариуцлага, урамшууллын тогтолцоог шинэчилнэ.		заслын иж бүрдэл Endoscopic Surgical System нэвтрүүлэх/				
		БИЕЛЭЛТ: Дүүргийн хэмжээнд дурангийн мэс заслын үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд шаардлагатай хүний нөөц бүрэн бэлтгэгдсэн ба Эрүүл мэндийн төвийн 210.0 сая төгрөгийн өртөг бүхий дурангийн мэс заслын тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Дурангийн мэс заслын иж бүрдэл, тоног төхөөрөмжийг 2022 оны 12 дугаар сард хүлээн авсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан бүрэн нийлүүлэгдээгүй байна.				
	18	2.1.2.2. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмчилгээ, оношилгоо яаралтай тусламж үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	50%	1000.0	ЭМТ, НХХ	100
	БИЕЛЭЛТ: Хандив тусламж болон Төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 1,149,322,627 төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийг хүлээн авч ашиглалтад оруулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвд "Nissan urban" NV350 маркийн түргэн тусламжийн авто машин болон эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд ашиглах "Ходоодны дуран" аппаратыг нийлүүлэн тусламж үйлчилгээнд ашиглаж эхэлсэн. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын санаачилгаар дүүргийн Эрүүл мэндийн төвд Нярайн шарлалтын эмчилгээний иж бүрэн тоног төхөөрөмжийг "Дэээрэт" Олон Улсын энэрлийн байгууллагын буцалтгүй тусламжаар 19 дүгээр хорооны ӨЭМТ-д байршуулсан. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газраас 128,6 сая төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн яаралтай тусламжийн иж бүрэн тоноглогдсон авто машиныг цар тахлын бэлэн байдлыг хангах зорилгоор хүлээлгэн өгсөн.					
2.1.3. Дүүргийн нэгдсэн эмнэлэг, Хайлааст салбар Амбулатори-2, Жишиг Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн барилгыг барих ажлыг дээд шатны байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.	19	2.1.3.1. Дүүргийн Нэгдсэн эмнэлэг барих талаар НЭМГ, АХБ-ны "ЭМСХХ-6" төслийн багтай хамтран зөвшилцөх уулзалт хийж гарсан саналыг боловсруулж НЭМГ-аар уламжлуулан Нийслэлийн газар зохион байгуулах албаны газар чөлөөлөх албанд Албан ёсоор хандаж эмнэлэг баригдах газрын асуудлыг тавих ЧДЗДТГ, ЧДИТХ-аар газрын асуудлыг НИТХ-аар хэлэлцүүлэн газрын асуудлыг шийдвэрлэнэ.	-	-	НХХ, ТГУХ	100
	20	2.1.3.2. Дүүргийн 13 дугаар хороонд	100%	750.0	ЭМТ, НХХ	70
БИЕЛЭЛТ: Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк, Эрүүл мэндийн яамнаас Монгол улсад хэрэгжүүлж буй "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-6" төслийн хүрээнд 30.0 сая ам долларын өртөг бүхий олон улсын жишигт нийцсэн нэгдсэн эмнэлгийн барилга барихад шаардлагатай 10 дугаар хороонд 2,8 га 55 нэгж талбар газрыг 6,8 орчим тэрбум төгрөгөөр дүүргийн Засаг даргын Тамгын газраас бүрэн чөлөөлж, оршин суугчидтай гэрээ байгуулах ажлыг хийж дуусгасан.						

		баригдаж буй салбар амбулаторийн барилгын гүйцэтгэлд зохих хяналтыг тавьж, хамтран ажиллах, Шинээр баригдаж буй Хайлааст салбарт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.				
		БИЕЛЭЛТ: Дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй салбар амбулаторийн барилгыг барихаар тендерт шалгарсан “Мандал голомт” ХХК 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдөр барилга барих шав тавьж барилгын ажлаа эхлүүлсэн бөгөөд 2019-2021 онд “Ковид-19” цар тахал болон хил хаасантай холбоотойгоор барааны тээвэрлэлт, барилгын материалын үнийн өсөлтөөс шалтгаалан барилгын ажил удааширсан. Салбар амбулаторийн барилгын ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх, ажлын явц болон гүйцэтгэгч компанийн асуудлаар удаа дараа албан хүсэлт болон саналыг Эрүүл Мэндийн Яам, Сангийн яам, Барилгын хөгжлийн төвд хүргүүлж ажилласан. Барилгын ажил 3 давхар хүртэл цутгалт, өрлөг хийгдэж өвлийн улиралд барилгын ажил түр зогссон.				
	21	2.1.3.3. Хороодод шинээр баригдах өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хэрэгцээг тодорхойлж, жишиг ӨЭМТ-ийн тоог нэмэгдүүлнэ.	1	1,200.0	ЭМТ, ЗДТГ	
		БИЕЛЭЛТ: Дүүргийн 1-3, 16 дугаар хорооны иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх орчин үеийн стандартад нийцсэн “ЖИШИГ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН” барилгын ажлыг “Баялаг говь” ХХК, “Бум констракшн” ХХК, тус тус гүйцэтгэж улсын комисс ашиглалтад хүлээн авч, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.				100
2.1.4. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, үйл ажиллагааны явцыг бүрэн цахимжуулж, эмчилгээ, үйлчилгээнд орчин үеийн технологийн дэвшлүүдийг ашиглах замаар цахим эрт илрүүлэг, эргэн дуудах болон эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлэхэд холбогдох дэмжлэг үзүүлнэ.		2.1.4.1. Эрүүл мэндийн цахим нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, серверүүдийг шинэчилнэ.	2	50.0	ЭМТ, НХХ, ӨЭМТ	
	22	БИЕЛЭЛТ: Эмнэлгийн программ хангамжийн гацалтыг бууруулах, серверийн аюулгүй байдлыг хангах, стандартад нийцсэн серверийг өрөөг тохижуулах зорилгоор 2022 онд нийт 99,593,000 мянган төгрөгийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж Data серверийн RAM төхөөрөмжийн хурдыг 16GB-аас 128GB болгон нэмэгдүүлсэн. Интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, сүлжээний доголдлыг бууруулах зорилгоор Нэгдсэн эмнэлэг, Төв салбар, Бага тойруу салбар, Хүүхдийн амбулатори салбарын Media convertor /Шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж/-ийг бүрэн шинэчилснээр интернэтийн урсгал 53%-аас 70,72% болж нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн төв нь DataBase server /Эмнэлгийн программ хангамжийн өгөгдөл хадгалалт/, APPLICATION, DICOM/PACS /Рентген, Хэвлийн эхо, Зүрхний эхо зэрэг зурган мэдээллийг хадгалах сервер/, IPPBX-2, Time /Ажилчдын цаг бүртгэл/, Web /веб сайтын мэдээлэл/, Share server /Ажилчдын мэдээлэл солилцооны мэдээллийн сан/ зэрэг 7 төрлийн тооцоолох тоног төхөөрөмжүүд бүхий зориулалтын серверийн өрөөг стандартын дагуу тохижуулан ажиллуулж байна. Ажилчдын мэдээлэл солилцооны мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор мэдээлэл солилцооны NAS серверийг шинээр нэвтрүүлж, эрүүл мэндийн төвийн нийт ажилчид дотоод сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцох боломж бүрдсэн. Одоогоор NAS серверт 26 тасаг, албадын нууц үгээр хамгаалагдсан мэдээллүүд байршиж байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн				100

		198 дугаар					
	23	2.1.4.2. Ehealth программ хангамжид тулгуурласан эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор бүртгэл мэдээллийг чанаржуулна.	70%	45.0	ЭМТ, НХХ, ӨЭМТ	100	
		БИЕЛЭЛТ: Батлагдсан төсвийн хүрээнд нийт салбар нэгж, нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын хуваарийг боловсруулан мөрдүүлж, хяналт тавьж ажилласан. Нэгдсэн эмнэлгийн тасаг нэгжүүд эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлээ E-health программ хангамжийг ашиглан бүрэн оруулж хэвшсэн ба 2022 оны байдлаар 4890 удаагийн гүйлгээ бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд эмийн сангийн 3 эм олгогч, 1 эм зүйчийн бүртгэлийн ажилд хуваарийн дагуу тогтмол хяналт тавьж ажилласан. Дотоод шүүрэл, хавдар, сэтгэц, мэдрэлийн эмчийн жорын дагуу 889 эмчлүүлэгчдэд үнэ төлбөргүй олгосон эмийн бүртгэлийг хянаж баталгаажуулан ажилласан.					
	24	2.1.4.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд орчин үеийн технологийн дэвшлүүдийг ашиглах замаар цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	70%	100.0	ЭМТ, НХХ, ӨЭМТ	100	
		БИЕЛЭЛТ: Эмнэлгийн мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээнд дүрс оношилгооны зурган мэдээллийг хадгалах PACS серверийг нэвтрүүлж, дүрс оношилгооны 5 төхөөрөмжийг холбосноор рентген 3, хэвлийн эхо 1, зүрхний эхоны 1 төхөөрөмж, нийт 5 төхөөрөмж PACS системд холбогдож, нийт 1237 үйлчлүүлэгчдийн дүрс оношилгооны зурган мэдээллийг дамжуулсан байна. -Эмнэлэгт хөтлөгддөг анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтуудыг ашиглах, солилцох үйл явцыг цахим системд нэвтрүүлэх ажлын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 13 маягт шинээр цахим системд нэвтэрсэн байна. Үйлчлүүлэгчдийн чирэгдэл, цахим бүртгэлийн ачааллыг бууруулах зорилгоор шинжилгээний хариу гармагц киоск машинаас шинжилгээний хариу авах 4 оронтой нууц дугаарыг үйлчлүүлэгчдийн бүртгэлтэй гар утасны дугаарт илгээж 2022 онд 24150 үйлчлүүлэгчийн шинжилгээний хариу авах кодыг мессежээр илгээсэн байна. Мөн тус Эрүүл мэндийн төвд хийгдсэн шинжилгээний хариуг E-Mongolia цахим системээс авах боломж бүрдсэн. ЭМТ-ийн цахим бүртгэлийн үйлчилгээнд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 23-ны байдлаар: - Амбулаторийн үзлэг- 232,297 - Хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч- 9,190 - Дүрс оношилгоо- 62,616 - Яаралтай тусламж /Том хүн/- 8,583 - Яаралтай тусламж /Хүүхэд/-19,913 - Лабораторийн- 151,678 хүн хамрагдсан байна					
2.1.5.	Эрүүл, идэвхтэй	25	2.1.5.1. Эрүүл мэндийн мобайл	1	60.0	ЭМТ, НХХ	90

амьдралын хэв маягийг төлөвшүүлэх хэмжээнүүдийг ажиллана.	арга дэмжин	технологийн иж бүрдэлтэй ӨЭМТ-үүдийн тоог нэмэгдүүлэх, эрт илрүүлгийг сайжруулна.				
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн 11, 12, 13, 17, 18, 19 дүгээр хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүд мобайл технологийн тоног төхөөрөмжийг ашиглаж байна. Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 2022 оны Мобайл технологийн төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажил хойшлогдсон.</p> <p>ДЭМБ-ын санхүүжилтээр 2022 оны 12 сард дүүргийн 9, 16 дугаар хорооны ӨЭМТ-ийг Мобайл технологийн иж бүрдлээр хангаж, АШУҮИС-аас ашиглалтын талаарх сургалтыг эмч, сувилагч нарт явуулж зааварчилгаа өгч ажилласан. Дүүргийн эмзэг бүлгийн 3000 орчим иргэдэд 5 төрлийн түргэвчилсэн оношлуураар халдвар илрүүлэх, 4 төрлийн явуулын тоног төхөөрөмжөөр халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлэх арга хэмжээг ДЭМБ-тай хамтран 2023 онд зохион байгуулахаар төлөвлөж байна.</p>				
		2.1.5.2. Эрүүл мэндийн сайн дурын идэвхтнүүдийг бэлтгэн ажиллуулах, тогтвортой ажиллагааг дэмжинэ.	80	25.0	ЭМТ, НХХ	
26	<p>БИЕЛЭЛТ: Тайлант хугацаанд шинээр 32 сайн дурын идэвхтэн шинээр бэлтгэн 152 хүнд Өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд хөтөч болон эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны ажилд дэмжин ажиллаж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хариу арга хэмжээг чадавхжуулах төслийн хүрээнд 72 сайн дурын идэвхтэн 3 удаагийн сургалтад хамруулж идэвхжүүлсэн. Ковидын дараах сэргээн засах тусламж үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд Ковидын халдвар аваад эдгэрсэн 30 сайн санааны туслагчийг сэргээх засах эмчилгээнд 10 хоног хамруулан үр дүнг тооцсон. Эрүүл мэндийн сайн санааны 54 туслагч нар Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “Хөтөч-Эрүүл мэндийн сайн санааны туслагч”-аар 2022 онд нийт 7,776 цаг сайн дурын ажил хийж өдөрт дунджаар 3 цаг ажилласан.</p>					100
27	2.1.5.3. “Эрүүл” иргэн, өрх, байгууллага хамт олныг шалгаруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулна.	10	25.0	ЭМТ, НХХ		
	<p>БИЕЛЭЛТ: Хороодын Өрхийн Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран “Эрүүл иргэн, өрх, байгууллага, хамт олон”-ыг шалгаруулах удирдамжийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж, 2022 оны 3 дугаар улиралд арга хэмжээг зохион байгуулж, “Эрүүл мэндийг дээдлэгч иргэн”-4, “Эрүүл мэндийг дээдлэгч өрх”-3, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-аар 3 байгууллагыг шалгаруулсан. Дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 3/2371 тоот албан бичгээр холбогдох материалыг НЭМГ-т хүргүүлсэн. “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-аар 31, 37, 43 дугаар цэцэрлэг, “Эрүүл мэндийг дээдлэгч өрх”-өөр 19 дүгээр хорооны өрх А.Раднаа, “Эрүүл мэндийг дээдлэгч иргэн”-ээр дүүргийн 6 дугаар хорооны иргэн С.Баянжаргал нар шалгарсан.</p>					100
28	2.1.5.4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах мэдээлэл сургалт сурталчилгааг өргөжүүлнэ.	80000	25.0	ЭМТ, НХХ		
	<p>БИЕЛЭЛТ: Тайлант хугацаанд эрүүл мэндийн боловсрол, мэдлэг олгох чиглэлээр 2 аян, 10 өдөрлөг, 70 сургалт сурталчилгаа нийт 82 арга хэмжээнд давхардсан тоогоор 45600 иргэд хамрагдсан. Жирэмсэн эмэгтэйчүүд болон гэр бүлийн гүшүүдэд зориулсан сургалтыг 14 хоногт нэг удаа тогтмол зохион байгуулж нийт 2330 иргэдийг хамруулсан.</p>					100

		Дүүргийн 1-24 дүгээр хороодын “Эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг” хийх эрүүлжүүлэх, сургалт зөвлөгөө өгч нийт 1240 эмэгтэйчүүд хамрагдсан. -“Аюулгүй бай-Эрүүл бай”, “Эртэч-Чингэлтэй”, “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлье” аяны өдөрлөг арга хэмжээний хүрээнд 2800 хүүхдэд сургалт хийж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн байна. Архи, тамхины хэрэглээ хорт зуршлаас сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулж нийт 3600 хүнд мэдээлэл хүргэсэн.				
2.2. БИЕИЙН ТАМИР, СПОРТ						
2.2.1. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилго бүхий “Чингэлтэй лиг” олон төрөлт уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулна.	29	2.2.1.1. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор хүүхэд залуучууд, ахмад настан, иргэд, төрийн албан хаагчдын спортын тэмцээн уралдааныг зохион байгуулна.	66	80.0	БТСХ, НХХ	100
	БИЕЛЭЛТ: Тайлант хугацаанд Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд нийт 66 тэмцээн уралдаан, 3 удаагийн арга хэмжээ зохион байгуулагдаж давхардсан тоогоор 488 байгууллагын 48,461 албан хаагчид болон иргэдийг хамрууллаа.					
	30	2.2.1.2. Улаанбаатар марафон олон улсын тэмцээнд дүүргийн төрийн албан хаагчид, иргэдийг оролцуулна.	3600	-	БТСХ, НХХ	100
	БИЕЛЭЛТ: Дүүргийн иргэдийг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” олон улсын гүйлтийн тэмцээн 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр амжилттай зохион байгуулагдан төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэд, сурагчдаас бүрдсэн нийт 2200 иргэд хамрагдсан.					
31	2.2.1.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг ББХЧТТ Сорил авна.	14950	-	БТСХ, НХХ	90	
БИЕЛЭЛТ: Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Бие бялдрын түвшин тогтоох сорилд төрийн болон төрийн бус аж ахуй нэгж байгууллагын 13,278 иргэн, төрийн албан хаагчийг хамруулснаас 58,2% нь А, В, С үнэлгээ авсан байна.						
2.2.2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж	32	2.2.2.1. Хайрхан хөгжлийн төв 3 спорт цогцолборын барилгыг ашиглалтад оруулна.	50	-	БТСХ, НХХ	30

<p>төрөх ёсны салшгүй хэсэг болгох зорилгоор дүүргийн иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийн ажлыг эрчимжүүлнэ.</p>		<p>БИЕЛЭЛТ: “Хайрхан хөгжлийн төв-3” спорт цогцолборын барилгын асуудлаар Чингэлтэй дүүргийн Прокурорын газраас 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай” тогтоол гарсан. Уг асуудлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул Иргэний хэргийн журмаар шүүхэд хандаж 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 11350 дугаартай захирамжаар иргэний хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.</p>				
<p>2.2.3. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулж, уралдаан тэмцээнд оролцох нөхцөл бололцоогоор ханган, дэмжиж ажиллана.</p>	33	<p>2.2.3.1. Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулж, уралдаан тэмцээнд оролцох нөхцөл бололцоогоор ханган, дэмжиж ажиллана.</p> <p>БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын 2022 оны А/39 дүгээр захирамжаар “Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөл” байгуулан Өсвөрийн шигшээ багийн төрлийг сонгох, багш дасгалжуулагч нарын сонгон шалгаруулалтыг явуулах асуудлаар 2 удаа хуралдан Өсвөрийн шигшээ багийг спортын 15 төрлөөр хичээллүүлэх шийдвэр гарч, багш дасгалжуулагчдыг сонгон шалгаруулж, Засаг даргын Тамгын газар болон Биеийн тамир, спортын хороо “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан. Өсвөрийн шигшээ багуудын бэлтгэл сургуулилтыг хуваарийн дагуу тогтмол зохион байгуулан 4470 цагийн бэлтгэлд давхардсан тоогоор 2500 тамирчин хамрагдсан. Өсвөрийн шигшээ багийн тамирчид Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд 2, Олон улсын тэмцээнд 6, Улсын аварга шалгаруулах тэмцээнд 10, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд 11, Нэрэмжит тэмцээнд 24 нийт 53 тэмцээнд амжилттай оролцож 261 медаль, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 медаль, Олон улсын тэмцээнээс 25 медаль, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 98 медаль, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнээс 44 медаль, Нэрэмжит тэмцээнээс 92 медаль хүртэж, нийт 40 удаагийн уралдаан тэмцээнд оролцож 250 медаль багц медаль хүртэж амжилт үзүүлсэн.</p>	68	14.194	БТСХ, НХХ	100
<p>2.3. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН</p>						
<p>2.3.1. Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын хичээлийн чанарыг ахиулах, сэтгэлгээний өндөр хурдтай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “Оюунлаг Чингэлтэйчүүд” төслийг хэрэгжүүлнэ.</p>	34	<p>2.3.1.1. “Оюунлаг Чингэлтэйчүүд” төслийн хүрээнд олон талт ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллана.</p> <p>БИЕЛЭЛТ: “Оюунлаг Чингэлтэйчүүд” төслийн хүрээнд 2022 онд нийт 14 үйл ажиллагаанд 11700 сурагч, 3000 багш хамрагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 2022 оны 08 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд “Багшийн хөгжлийн тасралтгүй хөгжил, зөвлөх багшийн манлайлал сургалт улсын зөвлөгөөн”-д 7 сургууль, 2 цэцэрлэгийн 22 зөвлөх багш хамрагдсан. ✓ ДЗОУБ-тай хамтран сургуулийн нийгмийн ажилтнуудыг чадваржуулах “Сэтгэл зүйн практик арга зүй” сургалт зохион байгуулагдсан. <p>БШУЯ-тай хамтран зохион явуулсан “Хүүхдийн хөгжлийн үнэлгээний арга зүй” сургалтад төрийн болон төрийн</p>	85%	25.0	БХ, НХХ	100

		бус өмчийн нийт 87 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч хамрагдсан.			
2.3.2. Шинээр сургууль, цэцэрлэг барих, өргөтгөх замаар цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургуулийн анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэх ажлыг хэрэгжүүлнэ.	35	2.3.2.1. Ерөнхий боловсролын 4 сургууль, 2 цэцэрлэг шинээр ашиглалтад оруулж, 5 сургууль, 4 цэцэрлэг өргөтгөн шинэчилнэ.	1 сургууль шинээр ашиглалтад оруулж, 2 цэцэрлэг өргөтгөн шинэчилнэ.	1,000.0	БХ, НХХ
		БИЕЛЭЛТ: Арга хэмжээний хүрээнд 39, 293, 298, 277 дугаар цэцэрлэг, 145 дугаар бага сургууль ашиглалтад орж хүүхэд хүлээн авч, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа эхэлсэн. Мөн Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн өргөтгөл 90%, дүүргийн 12 дугаар хорооны Бага сургууль, цэцэрлэгийн барилгын ажил 90%-тай, 19 дүгээр хорооны бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын ажил 85%-ын гүйцэтгэлтэй явж байна. Төрийн өмчийн 38 цэцэрлэгийн зөөлөн эдлэл, хивс, хивсэнцрийг бүрэн шинэчлэхэд 850.0 сая төгрөг зарцуулсан. Үүний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартын хэрэгжилт сайжирч, хүүхдийн эрүүл, аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.			100
2.3.3. Ерөнхий боловсролын цахим сургуулиудын тоог нэмэгдүүлэх, дэвшилтэт технологийг сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлж боловсролын салбарын тэгш, хүртээмжтэй байдлыг ханган чанарыг дээшлүүлнэ.	36	2.3.3.1. Цахим сургуулиудын тоог жил бүр нэмэгдүүлж, үр дүнг тооцно.	1	0.165	БХ, НХХ
		БИЕЛЭЛТ: Цахим сургуулийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 24 дүгээр сургууль анги танхим, нийтийн эзэмшлийн талбайг интернэт сүлжээнд холбосон. Цахим сүлжээнд ашиглах Оффис-365 программыг 19 сургуулиудад хүргэж, хандах эрхийг өгч, сургуулиуд дотооддоо ашиглаж байна. Сургууль цэцэрлэгийг цахимжуулах ажлын хүрээнд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5 нөүтбүүк, 29 суурин компьютер, 13 принтерийг нэн шаардлагатай 291, 292, 293, 298, 277, 276, 280 дугаар цэцэрлэгүүд, 17 дугаар сургуульд хуваарилав. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын инженер, техник, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор Микролион роботын сургалтад багш нарыг хамруулсан. Сургууль тус бүрд Микролион роботыг 3 ширхгийг хуваарилсан. Хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг харах боломжтой сургуулийн удирдлагуудад зориулсан eSchool, багш нарт зориулсан eTeacher, сурагчдад зориулсан eStudent, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан eParent хэмээх дөрвөн аппликейшнээс бүрдсэн технологийн цогц шийдэл бүхий eschool цахим системийг 6 сургууль нэвтрүүлсэн.			100
2.3.4. Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Чадварлаг багш-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг сайжруулж, индексийн урамшууллыг	37	2.3.4.1. “Чадварлаг багш-2024” арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж чадварлаг багш нарыг шалгаруулна.	60	30.0	БХ, НХХ
		БИЕЛЭЛТ: Тус арга хэмжээний хүрээнд багш нарыг чадавхжуулах 22 сургалт, арга хэмжээг зохион байгуулж нийт 8000 гаруй багш, ажилчдыг хамруулсан. Дүүргийн СӨББ-ын багш нарын тасралтгүй хөгжлийг хангах үүднээс 2022 оны 03, 04, 05 дугаар саруудад арга зүйч нарт өглөөний сонсголыг хийж, нэгж байгууллагын хэвшүүлсэн шинэ санал, санаачилгыг дэмжин ажилласан. БШУЯ, БЕГ-аас зохион байгуулсан хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 54 удирдах ажилтнууд хамрагдсан. Мөн хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд 2022 оны 08 дугаар сард бага боловсролын сургалтын менежер, багш, нийгмийн ажилтан нийт 42 хүн сургалтад хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын захирамжаар дүүргийн 49 дүгээр сургууль 9, 31 дүгээр цэцэрлэгийн 3			90

олгоно.		багш түрээслэн өмчлөх орон сууцны эрхийн бичиг авсан. Нийслэлийн индексийн урамшуулал олгох шалгаруулалтад Ерөнхий боловсролын 23, 24, 139 сургуулиуд 2022 оны нийслэлийн “Шилдэг менежменттэй сургууль”, 43, 83, 174, 220 дүгээр цэцэрлэгүүд “Шилдэг менежменттэй цэцэрлэг”-ээр шалгарсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлдэг Орон байрны дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 4, 222, 224 дүгээр цэцэрлэг, 17, 24, 50 дугаар сургуулийн нийт 6 багш, ажилчид тус бүр 10.0 сая төгрөгийн дэмжлэг авсан.				
2.3.5. Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэлийн ажлыг дэмжиж, үе шаттайгаар хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллана.	38	2.3.5.1. Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. БИЕЛЭЛТ: Арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын 50 дугаар сургууль Монгол дахь Гёте институтийн хөрөнгө оруулалтаар Герман хэлний номын сан, уншлагын булан байгуулж, 3795 еврогийн үнэ бүхий герман хэлний ном, сурах бичигтэй болсон. Дүүргийн Засаг даргын дэмжлэгээр 6 цэцэрлэгт Олон улсын “Монтессори” хөтөлбөр, 8 цэцэрлэгт “I’m brick” хөтөлбөр, 20 цэцэрлэгт “Steam” хэрэглэгдэхүүн хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.	1	20.0	БХ, НХХ	100
2.4. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ДААТГАЛ						
2.4.1. Иргэдийг ажлын байраар хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой “Бүтээлч Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээг уламжлал болгон хэрэгжүүлнэ.	39	2.4.1.1. “Бүтээлч Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана. БИЕЛЭЛТ: Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Бүтээлч Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан, өрхийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжин, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих зорилгоор “ДЭМ ДЭМЭНДЭЭ” өдөрлөгийг 5 удаа зохион байгуулж, 70 үйлдвэрлэгчийг хамруулж, нийт 5,700.000 мянган төгрөгийн борлуулалт хийсэн. “Чингэлтэйд үйлдвэрлэв-3” борлуулалтын төвийн 2 салбарт нийт 18,200.000 мянган төгрөгийн борлуулалт хийгдсэн. Мөн мэргэжил сонголтын өдөрлөгийг зохион байгуулж 261 хүүхдэд мэдээлэл зөвлөгөө өгч, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Оролцоо төсөлд 31 иргэнийг хамруулж, 10 иргэнийг ажлын байранд зуучилж, 21 иргэнийг дадлагажуулах хөтөлбөрт хамруулж байна. Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн “Хөдөлгөөнт бирж” арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 350 сул чөлөөтэй ажлын байрыг танилцуулан 150 иргэнийг ажил хайгчаар бүртгэж байнгын болон цагийн ажлын байранд 60 иргэн зуучлагдсан. “Хамтын ажиллагаа, түншлэлийг сайжруулах нь” ажил олгогч эздийн зөвлөгөөн зохион байгуулж, 230 аж ахуйн нэгж байгууллагын удирдах ажилтнууд оролцсон. Мөн “Өөрчлөлтийг өрхөөс” сэдэвт бичил бизнес эрхлэгчдийн уулзалт, өдөрлөгийг 2022 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн дүүргийн Засаг даргын 2022 оны А/349 дугаарын захирамжаар Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.	50%	-	НХХ, БИТ	90
2.4.2. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх “Цахим	40	2.4.2.1. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд LMIS программын шинэчлэлд	4000	-	ХөҮҮХ, НХХ	100

Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох бодлогыг дэмжин ажиллана.		санал оруулж иргэдийн мэдээллийг бүртгэн мэдээллийг хүргэнэ.				
		<p>БИЕЛЭЛТ: “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд “LMIS” программын шинэчлэлд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг сайжруулах талаарх саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн ба тус программ E-Job программ болон шинэчлэгдсэн. Тус платформын сургалтад холбогдох байгууллагын мэргэжилтнүүд 2 удаа хамрагдаж төрийн мэдээллийн бусад системтэй холбогдсон, 11 модуль дэд системээс бүрдсэн платформ дээр хэрхэн ажиллах, ажил хайгч, ажил олгогчдыг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан ажилд зуучлах талаар суралцсан. Тайлант хугацаанд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээний хүрээнд 2000 иргэнд хөдөлмөр эрхлэлт, мэргэжил сонголтын талаар сургалт, зөвлөгөө мэдээллийг өгч, сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалга 1000, ажил идэвхтэй хайж байгаа 995 иргэнийг бүртгэн, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 756 иргэнийг тохирох ажлын байранд зуучилсан. Шинээр бий болсон 500 ажлын байр, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан 1100, нийт 6351 иргэний мэдээллийг LMIS программд шивж оруулсан.</p>				
	41	2.4.2.2. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд E.Halamj программын шинэчлэл хийгдэж иргэдийн мэдээллийг бүртгэн халамжийн үйлчилгээг цахим болгоно.	6	-	ХөҮҮХ, НХХ	100
		<p>БИЕЛЭЛТ: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор зарим төрлийн үйлчилгээг иргэний нэрийн дансанд шилжүүлэх ажлыг арилжааны банкуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулж, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээнд хамрагдах эрх үүссэн 19547 иргэдийн өргөдөл, хүсэлтийг www.ehalamj.mn цахим системээр хүлээн авч хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэрлэн ажилласан. Тайлант хугацаанд www.ehalamj.mn цахим системд нэг цэс 15 үйлчилгээг нэвтрүүлсэн байна.</p>				
2.4.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч дэд бүтэц, тохижилт, барилга байгууламж, зам талбайн стандартыг хангуулна.	42	2.4.3.1. ОНОТХҮ-ний нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх хамт олны бүлэг бүрдүүлэх орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх амьдрах ухаанд сургана.	8	4.0	ХөҮҮХ, НХХ	100
		<p>БИЕЛЭЛТ: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, төсөл хэрэгжүүлэх амьдрах ухаанд сургах бүлгийн төслийг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд зарлаж, шалгарсан 32 бүлгийн төсөлд 52.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Сэргээн засах, өдрийн үйлчилгээ, түр байрлуулан асрамжлах үйлчилгээ, түр хоноглох бичиг баримтжуулах үйлчилгээний тендерийг 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зарлан шаардлага хангасан 11 байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн Сэргээн засах үйлчилгээг “Озон сервис” ХХК 47 иргэн 11,750,000 мянган төгрөг, “Батануган СТ” ХХК 54 иргэн 11,796,000 мянган төгрөг, “Ливмед” ХХК 42 иргэн 11,550,000 мянган төгрөг “Акуа мед” ХХК 40 иргэн 10,862,500 төгрөг, өдрийн үйлчилгээг “Есүн-Удам” ХХК 43 иргэн 3,870,000 мянган төгрөг, Зөвлөгөө өгөх үйлчилгээ: “Ахмадын мишээл” ТББ 122 иргэнд 4,880,000 мянган</p>				

		төгрөг зарцуулсан. Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвтэй хамтран бүлэг болж төсөлд хэрхэн хамрагдах, төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдлэг, ойлголт өгөх, танилцуулах зорилгоор "Төслийн аргачлал" сургалтад 50 иргэдийг, хороодын 190 хэсгийн ахлагч, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан хороодын мэргэжилтнүүдэд 2 удаа тус тус сургалт зохион байгуулж, арга зүйгээр ханган ажилласан. Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Чингэлтэй Хайлааст орон нутаг төсөл хөтөлбөрт оролцож төгсөлтийн аргачлал хөтөлбөрт 200 өрх, хүүхэд хамгаалал хөтөлбөрт 150 хүүхэд, Холт БНСУ-ын хөрөнгө оруулалттай өдөр өнжүүлэх төвд 62 хүүхдийг тус тус хамруулсан. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээнд дүүргийн зорилтот өрхийн 500 хүүхдийг хамруулсан.				
	43	2.4.3.2. Дүүргийн хэмжээнд хөтөчтэй явган замын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	900м ²	40.5	ТНААХ	100
		БИЕЛЭЛТ: Уг арга хэмжээний хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр 12 байршилд бетонон зам, байгалийн чулуун зам, хашаа шинэчлэх, зогсоол хийх тендерт Трайзинг ХХК шалгаран жилийн эцсийн байдлаар 12 дугаар хороонд бичил цэцэрлэг, 16 дугаар хороонд 2110м ² явган зам, 19 дүгээр хороонд 405м ² эко хавтанг бүрэн хийж дуусгасан. Дүүргийн хэмжээнд 2022 онд дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн болон урсгал зардлын хөрөнгөөр 5, 7, 8, 10, 12, 15, 19 дугаар хороодод 2780м ² хөтөчтэй явган зам хийгдээд байна. Улсын болон дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 хорооны 19 байршилд 5,295 м ² хөтөчтэй явган зам хийгдэж дууссан.				
	44	2.4.3.3. Дүүргийн хэмжээнд барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шатыг нэмэгдүүлнэ.	Барилга байгууламжийн орчимд 10% нэмэгдүүлнэ	-	НХХ, ТНААХ	90
		БИЕЛЭЛТ: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 1, 2, 3 дугаар хороо, 16 дугаар хорооны 26079 хүн амд эмнэлгийн анхан шатны үйлчилгээг үзүүлэх орчин үеийн стандартын шаардлагад нийцсэн ЖИШИГ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ-ийн барилгыг барьж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад хүлээн авч, хэвийн үйл ажиллагааг явуулж байна.				
2.4.4. Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн дотоод гадаад	45	2.4.4.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	500	-	ХөХҮХ, НХХ	100

<p>төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллана.</p>	<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн “Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл”-ийн 2022 оны анхдугаар хуралдааныг 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, салбар зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нийт 7 хөтөлбөр, 28 арга хэмжээг танилцуулсан. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 404 төслийг хүлээн авч ажлын хэсгийн сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын байрыг дэмжих хөтөлбөр - 500.0 сая төгрөг /70 иргэн/ - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр - 232.0 сая төгрөг /40 иргэн/ - Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих /зөвлөх үйлчилгээ/ -14.400.000 мянган төгрөг /13 иргэн/ - Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр /төсөл/ - 218.0 сая /47 иргэн/ төгрөгийг зарцуулсан байна. <p>Дэлхийн банкны санхүүжилтээр Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөр, Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний хүрээнд 56 иргэнийг зээлийн өмнөх сургалтад хамруулж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Зээлд хамрагдаж төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа 24 иргэнд харилцан туршлага солилцох уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</p>				
<p>46</p>	<p>2.4.4.2. Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>	<p>530</p>	<p>-</p>	<p>ХөХҮХ, НХХ</p>	<p>100</p>
<p>БИЕЛЭЛТ: Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 16 дугаар тогтоолоор “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр” батлагдаж 2021 онд хэрэгжиж дуусгавар болсон. Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн албан бичгийн дагуу тус дүүргийн ХХҮХ нь өрхийн амьжиргааны түвшин 409,679 онооноос доогуур оноотой сонгогдсон 370 өрхийн судалгааг гаргаж, шаардлагатай нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Дүүргийн ХХҮХ, Цагдаагийн газар, Улаан загалмайн хороо хамтран орон, гэргүй, тэнэмэл амьдралтай, согтуурах мансуурах донтох өвчтэй иргэн, хорих ангиас суллагдсан нийт 23 иргэнд “Эзэн хичээвэл заяа хичээнэ” сургалт, өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, хөдөлмөрт зуучлах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, сургалт, мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээг үзүүлж, ахуйн хэрэглээний багц /маск, оо, сойз, санитол/ олгож, 4 иргэнийг ажилд зуучилсан. - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтран “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөр” техник туслалцааны төслийг 2022 оны 06 дугаар сараас 2023 оны 12 дугаар сарын хооронд хэрэгжүүлж эхэлсэн. Уг төслийг Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нийт 1520 өрхөд хэрэгжүүлэхээр дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын төслийг дүүргийн 12, 16, 17, 18, 19 дүгээр хороодын нийт 295 өрхөд хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд архивын амьжиргааны чанарыг үнэлэх судалгааг 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 08 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд хийж нийт 749 өрхөөр айлчилж 665 өрх хамрагдсан. Үүнээс: хаягтаа амьдардаггүй, утас нь холбогдохгүй, хөдөө явсан, эмнэлэгт хэвтсэн, хүнсний эрхийн бичгээс хасагдсан, гэр нь 					

		эзгүй гэх шалтгаанаар 88 өрх хамрагдаагүй. Мөн 2022 оны 09 дүгээр сарын 12, 13, 14-ний өдрүүдэд дээрх 5 хорооны нийт 295 өрх сонгох ажлыг зохион байгуулж, нэрсийг хороодын Засаг дарга нараар баталгаажуулж ажилласан. Дүүргийн 10 дугаар хорооны 58 өрх, 13 дугаар хорооны 128 өрх нэмэлтээр сонгогдож, 169 өрхөөс судалгаа авсан.				
2.4.5. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	47	2.4.5.1. Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, заавал даатгуулагч болон ажил олгогчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын тайланг тоон гарын үсгээр илгээх ажлыг сурталчлан зохион байгуулах, тоог нэмэгдүүлэх, цахим хяналт /http://10.9.0.5/monitoring/-ыг сайжруулах	100%	-	НДХ, НХХ	100
	БИЕЛЭЛТ: Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар 11 удаагийн сургалт, үйл ажиллагаагаар нийт иргэдэд мэдээлэл хүргэж, тоон гарын үсгээр нийт 1260 байгууллагын тайланг хүлээн авч ажиллаж байна. Нийт 2000 байгууллагын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнууд хамрагдсан ба тайлан илгээхэд анхаарах асуудал, цахим тэтгэмжийн үйлчилгээ, тэтгэмжийн хүсэлтийн цахимаар илгээх заавар, тоон гарын үсгийн танилцуулга 4 төрлийн 5484 ш гарын авлага брошюр тарааж ажилласан. Дүүргийн хэмжээнд 2022 оны байдлаар нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр шинээр 552 аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр бүртгэж, 3461 албан журмын даатгуулагчийг хамруулж, нийгмийн даатгалын шимтгэл 3,846,2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Мөн тайлант хугацаанд нийт 14172 сайн дурын даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдсан байна. Үүнээс шинээр 2800 даатгуулагч, 1410 эхчүүдтэй сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажилласнаар нийгмийн даатгалын санд 5,3187,6 сая төгрөг төвлөрүүлсэн. НДЕГ-аас 2022 оныг “Эрхзүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил” болгон зарласантай холбогдуулан тоон гарын үсэг ашиглан тайлан гаргадаг ажил олгогч байгууллагуудын тоог нэмэгдүүлэхээр байцаагч тус бүр өөрийн хариуцсан ажил олгогч байгууллагуудад тайлан өгөх талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 2022 байдлаар нийт 1260 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр хүлээн авч ажиллаж байна.					
	48	2.4.5.2. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний аппликейшныг даатгуулагчийн гар утсанд суулгах, сайн дурын даатгалын гэрээг аппликейшн ашиглан цахимаар байгуулах, сунгах талаар зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж, аппликейшны хэрэглээг нэмэгдүүлэх, шимтгэл төлөлтийн талаарх архивын лавлагааг 4500 гаруй иргэд даатгуулагчдад цахимаар /QR кодтой/ олгож хэвшинэ.	100%	-	НДХ, НХХ	100

		<p>БИЕЛЭЛТ: Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний аппликейшныг даатгуулагчийн гар утсанд суулгах, сайн дурын даатгалын гэрээг аппликейшн ашиглан цахимаар байгуулах, сунгах талаар зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж, аппликейшны хэрэглээг нэмэгдүүлэн ажиллаж байна. CALL CENTER үйлчилгээг 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс шинээр нэвтрүүлж, шууд холбогдох утсыг ажиллуулж, 11950 иргэд, даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл өгч байна. Тус ажлын хүрээнд нийт 9 арга хэмжээ, 6 сургалт, 3 төрлийн зурагт хуудас танилцуулга материал бэлтгэн, 598 даатгуулагчийн гар утсанд аппликейшн суулган баталгаажуулж, нийт 14172 сайн дурын даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдсан байна. Үүнээс: Шинээр 2800 даатгуулагч, 1410 эхчүүдтэй сайн дурын даатгалын гэрээ байгуулсан. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх архивын лавлагааг 5364 иргэд даатгуулагчдад цахимаар /QR кодтой/ болгон ажиллаж байна. "Дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем"-ийг нэвтрүүлэн, киоск машиныг ашиглан нийт 12982 иргэн дугаар авч үйлчлүүлснээс 13588 үйлчилгээг үзүүлж ажилгүйдлийн тэтгэмжийн зөвлөгөө 1035 даатгуулагч иргэн, нийгмийн даатгалын тайлан хүлээн авах баталгаажуулах 5072, тэтгэврийн мэдээлэл зөвлөгөө авсан 2485, өргөдөл 1074, бусад зөвлөгөө мэдээлэл 3922 үйлчилгээ үзүүлж, үйлчилгээ үзүүлсэн төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлсэн дундаж оноо 4,8% байна. Иргэдийн сэтгэл ханамжийн түвшин тодорхойлсноор Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг дүгнэх, байцаагч ажилтнуудын ажлын ачааллыг хэмжих, ажлын үр дүнг бодитой үнэлэхэд ач холбогдолтой юм. Иргэд даатгуулагчдыг сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний байцаагч нарын товч мэдээлэл бүхий QR кодыг хийж, байцаагч бүрийн өмнө байршуулан иргэд даатгуулагчдад сурталчлан, мэдээлэл өгч ажиллаж байна. Уг төхөөрөмжийг ашиглан нийгмийн даатгалын шимтгэл төлөх дансны дугаарыг харах, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хэвлэж авах бүрэн боломжтой болсон.</p>				
<p>2.5 ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛ</p>						
<p>2.5.1. Гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Гэр бүл-2024" арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>49</p>	<p>2.5.1.1. "Гэр бүл-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.</p>	<p>50%</p>	<p>-</p>	<p>ГБХЗХХ, НХХ</p>	<p>90</p>
<p>2.5.2. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх төвийг байгуулна.</p>	<p>50</p>	<p>2.5.2.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд Гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвд байрлуулан үйлчилгээ үзүүлнэ.</p>	<p>160 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<p>ГБХЗХХ, НХХ</p>	<p>100</p>

		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэдэх Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 185 хүүхэд, насанд хүрсэн 12 иргэн, нийт 197 хүн хамгааллын үйлчилгээ авсан байна.</p>				
	51	2.5.2.2. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэнд сэтгэлзүйн болон хөгжлийн үйлчилгээний шаардлага хэрэгцээг судлах сэтгэлзүйн баг байгуулна.	Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдийн 100%-д хүрч ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	ГБХЗХХ, НХХ	90
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон иргэдэд сэтгэлзүйн анхан шатны үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд сэтгэл зүйн зөвлөгөө мэдээллийг өсвөр үе, залуучууд 123, хүүхэд 246, зорилтот бүлгийн иргэд 203 нийт 576 иргэдэд үзүүлсэн байна. Дүүргийн ГБХЗХХ-ийн байранд НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй зорилтот бүлгийн иргэд, үйлчлүүлэгч нарт сэтгэл зүйн зөвлөгөөг ганцаарчилсан, бүлгийн, цахим хэлбэрээр зохион байгуулахаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна.</p>				
2.5.3. Асрамжийн газарт өсөж, 18 нас хүрсэн залуучуудыг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх төсөлд хамруулна.	52	2.5.3.1. Чингэлтэй дүүргийн харьяатай 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлж МСҮТ болон холбогдох сургалтын төвүүдэд холбон зуучилж, түр болон байнгын ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.	Чингэлтэй дүүргийн харьяатай 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст 100% хүрч ажилласан байна.	Батлагдсан төсвийн хүрээнд	ГБХЗХХ, НХХ	90
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын захирамжаар асрамж, халамжийн газарт асрамжлуулж байгаа нийт 86 хүүхэд байгаагаас 18 нас хүрсэн 10 хүүхэд, 21 нас хүрсэн 1 хүүхэд байгаа бөгөөд ар гэртээ эргэн нэгтгэгдэх 15 хүүхэд, ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан гэр бүлдээ эргэн нэгтгэх боломжгүй 7 хүүхэд байна. Монголын хүүхдийн сан, Өнөр бүл, Сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын 4 асрамж халамжийн төвд амьдарч байгаа хүүхдүүдэд Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран 2022 онд 3 удаагийн эргэн хяналт тавьж ажилласан. “Эрдэнэ” асрамж халамжийн төвөөс 18 нас хүрч гарсан 1 хүүхдийг “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл 2022”-д хамруулан ажиллаж байгаа ба амьдрах ухааны чадвар олгох 9 модуль сургалтад хамруулсан. Тэнсэн харгалзах ял, хүмүүжлийн чанартай албадан сургалтад хамрагдах арга хэмжээ авсан 18 хүртэлх насны 6 хүүхдэд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж, 35 удаагийн сургалт, нөлөөллийн ажилд хамруулж, ганцаарчилсан уулзалтыг 15 удаа, ярилцлага болон бүлгийн уулзалтыг 9 удаа хийж шаардлагатай зөвлөгөө мэдээллийг өгсөн. Хүүхдүүдийг өөрсдийнх нь сонирхлын дагуу хөгжмийн болон мэргэжлийн сургалтын төвд холбон зуучилсан байна.</p>				
2.6. ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ						
2.6.1. Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч	53	2.6.1.1. “Соёлтой иргэн-2024” арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын	50%	-	НХХ, БХ	

<p>сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн агуулгыг баяжуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилготой “Соёлтой иргэн-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>		<p>Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.</p>				90
		<p>БИЕЛЭЛТ: Арга хэмжээний хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх 4 зорилт 12 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлуулан, арга хэмжээний хэрэгжилтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж “Хангалттай” үнэлэгдсэн. Арга хэмжээний хүрээнд дүүргийн төрийн албан хаагчдын ёс зүйн тухай ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Амар оюуны хөрөнгө оруулалт” ХХК-тай хамтран “Харилцааны соёл, ур чадварыг хөгжүүлэх” сэдэвт сургалтад дүүргийн 7 хорооны 86, “Угийн бичиг хөтлөх арга зүй” сэдэвт сургалтад дүүргийн 9 хорооны 103 нийт 16 удаагийн сургалтад 189 ажилтан, албан хаагчдыг хамруулан ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Япон улсын Яйзү хот хоорондын гадаад хамтын ажиллагааны хүрээнд Япон улсын Яйзү хотын уран бүтээлчид “Үггүй жүжиг” тоглолтыг дүүргийн “Хүүхдийн номын өргөө”, “Соёлын төв”, “Биеийн тамир, спортын хороо”-нд тоглож, нийт 150 иргэд, хүүхэд багачууд хамрагдсан. ✓ Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого явуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1138 дугаар захирамж, Нийслэлийн Соёл Урлагийн Газрын даргын 2022 оны А/50 дугаар тушаалын хүрээнд Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022 оны 09 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах түүх соёлын үл хөдлөх 29 дурсгалыг тоолж, www.rich.mongoluv.mn онлайн программд бүртгэсэн. ✓ Чингэлтэй дүүргийн түүхт 30 жилийн ойг угтан дүүргийн иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн цэнгээнт бүжгийг сурталчлан таниулах зорилгоор “Нийтийн цэнгээнт бүжгийн үдэшлэг”-ийг 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс 07 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. ✓ Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, өсвөр үеийнхэнд урлаг, уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг” шалгаруулах уралдаант наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, уралдаанд дүүргийн Ерөнхий боловсролын 9 сургуулийн, 500 сурагчид оролцсоноос Тэргүүн байранд Нийслэлийн Ерөнхий боловсролын 17 дугаар сургууль 2 дугаар байранд Нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль, 3 дугаар байранд Нийслэлийн Ерөнхий боловсролын 37 дугаар сургууль тус тус шалгарсан. ✓ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны А/759 дүгээр тушаалын хүрээнд Соёлын биет бус өвийн Улсын үзлэгийн тооллого 2022 оны 11 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд зохион байгуулж, дүүргийн 20 иргэнийг хамруулж ажилласан. ✓ Дүүргийн иргэдийн дунд “Нийтийн цэнгээнт бүжгийн шилдэг хос” шалгаруулах тэмцээнийг 2 насны ангилалд 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан ба нийт 19 багийн 38 иргэд хамрагдсан ба шилдэг баг тамирчдыг шагнаж урамшуулсан. 	70%	-	НХХ, СТ	30
<p>2.6.2. Үндэсний бахархал өв соёлыг иргэдэд түгээн дэлгэрүүлж, соёл урлагийн үйлчилгээгээр дамжуулан сурталчлан таниулах, иргэд</p>	54	<p>2.6.2.1. Үндэсний бахархал өв соёлыг иргэдэд түгээн дэлгэрүүлж, соёл урлагийн үйлчилгээгээр дамжуулан сурталчлан таниулах, иргэд олон нийтэд хүргэх, тэдэнд үйлчлэх Соёлын ордон барина.</p>	70%	-	НХХ, СТ	30

олон нийтэд хүргэх, тэдэнд үйлчлэх тав тухтай орчныг бий болгож, “Соёлын ордон барих” ажлыг эхлүүлнэ.		БИЕЛЭЛТ: Үндэсний бахархал өв соёлыг иргэдэд түгээн дэлгэрүүлж, соёл урлагийн үйлчилгээгээр дамжуулан сурталчлан таниулах, иргэд олон нийтэд хүргэх, тэдэнд үйлчлэх Соёлын ордон барих барилгын зураг төсвийн 105.0 сая төгрөг дүүргийн төсөвт тусгагдсан. Дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдах Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр болон Соёлын ордон барих газрыг чөлөөлөх ажил 75%-тай явагдаж байна.				
2.6.3. Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.	55	2.6.3.1. "Эрдмийн задгай театр"-т соёлын үйлчилгээг иргэдэд хүргэнэ.	500	4.0	НХХ, СТ	100
<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд дүүргийн хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох, иргэн, гэр бүл, байгууллага, хамт олныг эрүүл амьдрах хэв маягт төлөвшүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог дэмжих зорилгоор “Эртэч Чингэлтэйчүүд” аяныг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, 7 хоног бүрийн бямба гарагт явган алхалт хийж, соёл урлагийн үйл ажиллагаагаар нийт 6 удаа үйлчилсэн ба Нийслэлийн Улаанбаатар театрын циркийн тоглолтыг бүрэн эхээр нь толилуулж, аяны хүрээнд нийт 150 байгууллагын 6000 иргэд, ажилтан, албан хаагчид хамрагдсан.</p> <p>“Дээлтэй Монгол-2022” наадам энэ жил 16 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд Монгол орны үндэстэн ястан бүрийн онцлог, түүх соёлыг агуулсан үндэсний хувцастай иргэдийн баярын жагсаалд дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-24 дүгээр хороодын 1000 төлөөлөл оролцож, улсын хэмжээнд 2 дугаар байрт шалгарсан ба мөн дүүргийн 18 дугаар хорооны Засаг дарга Л.Бат-Оргил “Шилдэг урлаач” төрөлд тэргүүн байр эзэлсэн.</p> <p>“Хотын соёл-Хариуцлагатай иргэн” аяныг 15-19 дүгээр хороодод хуваарийн дагуу зохион байгуулж, дүүргийн 19 дүгээр хорооны “Эрдмийн задгай” театрт 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдөр дүүргийн Соёлын төвийн гэрээт уран бүтээлчид, дугуйлангийн сурагчид болон Соёлын төвийн дэргэдэх “Дөрвөн цаг хамтлаг” урлагийн тоглолтоо толилуулж, 100 иргэд хамрагдсан бөгөөд нийт 9 удаагийн нэгдсэн арга хэмжээ, 2 удаагийн аяныг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 17,000 иргэдэд соёл урлагийн үйлчилгээг хүргэж ажилласан.</p>						
	56	2.6.3.2. Соёлын биет бус өв тээгчид болох ахмад уран бүтээлчдийн авьяас, ур чадварыг өвлүүлэн дамжуулах, таниулан сурталчилна.	800	1.5	НХХ, СТ	90
<p>БИЕЛЭЛТ: Нүүдэлчин иргэдийн амьдралын өвөрмөц төрх, зан үйл, хөгжил дэвшлийн нэгэн илэрхийлэл болсон соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, үр хойчдоо өвлүүлэн үлдээх зорилго бүхий “Нүүдэлчин Монгол-2022” наадмыг 2022 оны 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулсан ба дүүргийн шилдэг 17 өвлөн уламжлагчдыг хамруулан 7 төрөл бүхий зан үйлийн үзүүлбэр, язгуур урлагийн тоглолт, гар урлалын үзэсгэлэн, соёлын биет бус өвийг таниулан сурталчлах арга хэмжээ, уралдаан, тэмцээн, соёлын бүтээлч үйлдвэрлэл, үзэсгэлэн худалдаа, соёлын биет бус өвийг иргэд, жуулчдад таниулан сурталчилж ажилласан. “</p> <p>Дүүргийн 15-19 дүгээр хороодод Хотын соёл-Хариуцлагатай иргэн” аяныг хуваарийн дагуу зохион байгуулж 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд дүүргийн Соёлын төвийн дэргэдэх “Ахмадын дөрвөн цаг” хамтлагийн тоглолтыг 600 иргэдэд хүргэж ажилласан.</p>						

57	<p>2.6.3.3. Соёлын төвийн дугуйлангийн сурагчдын тайлан тоглолт зохион байгуулна.</p> <p>БИЕЛЭЛТ: Соёлын төвийн дэргэд хүүхэд хөгжүүлэх морин хуур, дуу, төгөлдөр хуур, бүжгийн дугуйланд нийт 75 хүүхэд тогтмол хичээллэж байгаа бөгөөд Нийслэлийн Ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 50 жилийн ойг тохиолдуулан 2-6 дугаар ангийн 30 сурагчтай бүжгийн хамтлаг байгуулж, Сонгодог, Монгол бүжгийн анхан шатны дасгалууд, “Сурын дуулал”, “Журай” зэрэг олон төрөлт бүжгийг зааж сурган ажиллаж байна.</p> <p>Соёлын төв нь дүүргийн хүүхэд багачуудын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, урлагийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор дуу, төгөлдөр хуур, морин хуур, бүжгийн дугуйланг тогтмол хичээллүүлж, дугуйлангийн сурагчдын тайлан тоглолтыг “Хайрхан хөгжлийн төв-2”-д зохион байгуулж, 26 сурагч оролцлоо.</p>	25	1.00	НХХ, СТ	100	
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						
3.1. САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ						
3.1.1. Монгол улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.	58	<p>3.1.1.1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн биеэ даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил тод, нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.</p> <p>БИЕЛЭЛТ: Улсын төсөвт: 43,2 тэрбум төгрөг төвлөрөхөөс 50,2 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 116,2% хувь;</p> <p>Дүүргийн төсөвт: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 155,578,928.6 (нэг зуун тавин таван тэрбум таван зуун далан найман сая есөн зуун хорин найман мянга зургаан зуун) төгрөг төвлөрүүлэхээс өссөн дүнгээр 156,316,641.0 (нэг зуун тавин зургаан тэрбум гурван зуун арван зургаан сая зургаан зуун дөчин нэгэн мянган) төгрөг төвлөрүүлж, 100%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт 101,019,706.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 101,019,706.5 мянган төгрөг төвлөрүүлж 100%-ийн гүйцэтгэлтэй байна.</p>	Төлөвлөгөөг 100 ба түүнээс дээш хувиар биелүүлсэн байх, зардлыг үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх.	-	СТСХ, ТХ	100
	59	3.1.1.2. Дүүргийн төсвийн орлого, зарлагын төслийг боловсруулах, санал авах, тодотгох, судалгаа, тооцоо хийж, төсвийн төслийг хуулийн дагуу өргөн барьж, хэлэлцүүлэх, батлуулах, хэрэгжүүлнэ.	Төсвийн орлого, зардлыг үндэслэлтэй бодитой төсөвлөсөн байх.	-	СТСХ, ТХ	100

		<p>БИЕЛЭЛТ: Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад дагалдах хуулиудын нэмэлт өөрчлөлт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар Нийслэлийн 2022 оны төсвийг хэлэлцэн баталж, 6 дугаар сарын 30-ны өдрийн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит тавдугаар хуралдаанаар дүүргийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн баталсан.</p>				
3.1.2. Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийн, төсвийн сахилга хариуцлага, дүүргийн төсвийн байгууллагуудын орлого, зарлага хөрөнгө оруулалтын ажил болон хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.	60	3.1.2.1. Монгол улсын төсөв, санхүүгийн талаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хяналт тавих ажлыг тогтмолжуулан, төсвийн сахилга хариуцлага, үр ашиг, тайлагнал, ил тод нээлттэй байдлыг хангана.	Зардлыг бодитой төлөвлөх, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тодорхойлж, төсвийг үр ашигтай зарцуулсан байх	Батлагдсан төсвийн хүрээнд	СТСХ, НТАГазар төсөвт байгууллагууд	100
		<p>БИЕЛЭЛТ: Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2022 оны “Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах” тухай А/45 дугаар захирамжийг 2022 оны 4/246 тоот албан бичгээр Татварын хэлтэс болон харьяа 67 байгууллагын төсвийн шууд захирагч нарт хүргүүлж, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 4/1707 тоот албан бичгээр нийт 67 байгууллагын төсвийн шууд захирагч нарт төсвийн зохистой удирдлага, үр өгөөж сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлийг хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 1/1745 албан бичгээр “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоол, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын биелэлтийг хангаж, төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгон, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан. Тайлант хугацаанд 4/2908 тоот албан бичгээр нийт 69 байгууллагаас 2022 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгааг авч нэгтгэсэн.</p>				
3.1.3. Монгол Улсын татварын тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх талаар дэмжиж ажиллана.	61	3.1.3.1. Монгол Улсын татварын тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх талаар дэмжиж ажиллана.	100%	40.0	ТХ	100
		<p>БИЕЛЭЛТ: Татвар төлөгчдөд үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээнд цахимаар ирүүлсэн 20871 тайланг хүлээн авч, хэлтсийн 11-312728 тоот утсаар 7985, биечлэн 15657 татвар төлөгчдөд зөвлөгөө өгч, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэн ажилласан.</p> <p>Сургалт сурталчилгаа: Татварын хувь хэмжээ, хялбаршуулсан горимын тухай татвар төлөгчдөд татвар төлөх,</p>				

		<p>тайлагнах сэтгэлгээг бий болгох, анхан шатны мэдлэг олгох зорилгоор сургалтын материал бэлтгэж, 2022 оны 1-11 дүгээр сард зайн болон танхим хэлбэрээр 34 удаагийн сургалт хийгдсэн ба сургалтад нийт 435 шинэ татвар төлөгчийг хамруулсан. Жижиг, бичил татвар төлөгчдөд зориулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд зааснаар аж ахуй нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээ, хугацаандаа татвараа төлсөн бол 90%-ийг буцаан авах талаар татвар төлөгчдөд хялбараар тайлбарласан богино хэмжээний видео сурталчилгаа бэлтгэж “Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс”-ийн цахим сайтад байршуулан татвар төлөгчдөд түгээн ажиллалаа. Татвар төлөгчдөд зориулсан мэдээ мэдээлэл 118, видео контент 65, сургалт 34 зохион байгууллаа. Татварын албаны мэдээ мэдээлэл хүргэх 1800-1288 утсаар нийт 2510 татвар төлөгчдөд зөвлөгөө мэдээлэл өгч, цахим тайлангийн систем буюу нэвтрэлтийн нэгдсэн системд www.etax.mta.mn/ иргэнээр бүртгүүлэх заавар бүхий богино хэмжээний видео контентыг тогтмол хийн “Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс”-ийн нүүр номын хуудсанд байршуулсан.</p> <p>Тайлангаа хугацаандаа ирүүлдэггүй, 2-оос дээш жил тайлангаа хоцроосон татвар төлөгчдөд 2022 оны 3 дугаар улирлын тайлан ирүүлээгүй 9657 татвар төлөгчийн 11-312728 утасны дугаарт Татварын удирдлагын нэгдсэн системийн программаар тайлан ирүүлэх тухай мессеж хүргүүлсэн. Татвар төлөгчийн ирүүлсэн тайланг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан хянан холбогдох мэдээллүүдтэй тулган боловсруулалт хийн баталгаажуулж, тайланг хүлээн авч ажилласан. Зөрүүтэй илгээсэн тайланг татвар төлөгчдөд comment бичин буцааж, засварлуулан тайланг хүлээн авч ажилласан.</p>				
3.1.4. Дүүргийн өмч хөрөнгийн ашиглалтын менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.	62	3.1.4.1. Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг эзэнжүүлж, бүртгэлд бүрэн хамруулан, өмч хөрөнгийн ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг дээшлүүлж ажиллана.	Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, бүртгэлгүй өмч хөрөнгийг эзэнжүүлэн орон нутгийн өмч хөрөнгийн мэдээллийн сан баяжуулан ажиллах	1	СТСХ	100
		<p>БИЕЛЭЛТ: Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны жилийн эцсийн байдлаар хийгдэж дууссан хөрөнгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.4 дэх заалтын дагуу нийт 4,449.0 сая төгрөгийн өртөг бүхий 51 нэр төрлийн хөрөнгийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэн авч эзэнжүүлж, ашиглалт, хамгаалалт хийж ажилласан.</p>				
	63	3.1.4.2. Дүүргийн өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж үнэлэлт, дүгнэлт өгч эрсдэлийн удирдлагаар ханган, зөвлөмж өгч	100%	Батлагдсан төсвийн хүрээнд	ДАА	100

		ажиллана.				
		<p>БИЕЛЭЛТ: Төлөвлөгөөт хяналт шалгалтад 23 байгууллага хамрагдахаас 21 байгууллагын 2021, 2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгч ажилласан. Дүүргийн 72 байгууллага /сургууль, цэцэрлэг, ӨЭМТ/-ын 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, 33 сургууль, цэцэрлэг, ӨЭМТ-д зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар дүүргийн Засаг даргын удирдамжийн дагуу 9 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгах зөвлөмж өгч, тайлан мэдээг дүүргийн Засаг даргад танилцуулсан.</p> <p>Монгол Улсын Сангийн сайдын 2022 оны СХШХ/06 дугаар удирдамж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, уур усны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоог шалгаж, тайлан мэдээг Сангийн яамд хүргүүлж ажиллалаа. Ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн дагуу 3 байгууллагад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар акт, албан шаардлага өгч биелэлтийг хангуулан ажилласан.</p> <p>Дүүргийн Засаг даргын захирамжаар 5 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж тайлан мэдээг хүргүүлж, илэрсэн зөрчлийн талаар тухайн байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>				
3.1.5. Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд, хэмнэлттэй, хариуцлагатай, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай зарчмуудыг баримтлан 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүн, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй мэдээлнэ.	64	3.1.5.1. Тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ээр дамжуулан зохион байгуулж, үр дүн, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлнэ.	Худалдан авах ажиллагаа 100 % хийгдсэн байна.	-	ХААА	100
		<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/140 дугаар захирамжаар эрх шилжиж ирсэн 3 төсөл арга хэмжээ, 2022 оны А/1231 дугаар захирамжаар эрх шилжиж ирсэн 4 төсөл арга хэмжээ, Нийслэлийн Чингэлтэй Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 26 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан төсвийн хөрөнгөөр хэрэгжих 33, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 20, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжих 4, нийт 64 төсөл арга хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр баталсан. Уг тогтоолын дагуу төлөвлөгөөгөөр 6 төсөл арга хэмжээ шинээр төлөвлөж, 11 төсөл арга хэмжээ хасагдсан.</p> <p>Жилийн эцсийн байдлаар 57 төсөл арга хэмжээний тендерийг цахимаар зохион байгуулан ажиллаж, тендер шалгаруулалтыг цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан 100 хувь зохион байгуулж, үр дүн, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж ажилласан.</p>				
3.1.6 Статистикийн тоон мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг сайжруулж, үнэн зөв байдлыг ханган, мэдээ судалгааны хамрах хүрээг	65	3.1.6.1. Дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр “Статистикийн эмхэтгэл-2021”, “Дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулга” “Өрх, хүн амын танилцуулга”, “Иргэдийн	“Статистикийн эмхэтгэл- 2021”-ийг 30 ширхэг, “Дүүргийн нийгэм, эдийн засгийн	Нийслэлийн төсөв		100

өргөжүүлнэ.		эрүүл мэндийн судалгаа”, “Боловсролын судалгаа”, “Оршин суугчдын аюулгүй байдлын судалгаа”, “Орон сууцны нөхцөл байдлын судалгаа” зэргийг эмхэтгэн гаргаж, нээлттэй тархаана.	байдлын сарын танилцуулга” сар бүр 30 ширхэг/нийт 360/, бусад 11 төрлийн судалгаа танилцуулгыг нийт 360 ширхгийг хэвлэж тархаана.		СХ	
	<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албадын нийт 17 нэгжээс захиргааны мэдээллийг хүлээн авч, Дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын 2021 оны 12 дугаар сар, 2022 оны 1-11 дүгээр сарын мэдээллийг нэгтгэж, www.ubstat.mn, сайтад Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтсийн пэйж хуудсанд байршуулан иргэд олон нийтэд мэдээллийг түгээн ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар нийт 750 ширхгийг бэлтгэснээс 300 ширхгийг цаасан болон цахимаар ИТХ-ын дарга, Засаг дарга, хэлтэс албадын дарга нарт, 450 ширхгийг хэвлэж нээлттэй хаалганы өдөрлөг, Авто машингүй өдрийн арга хэмжээний үеэр тарааж, тухайн жилд 360 ширхгийг бэлтгэж, тараахаар төлөвлөснөөс нийт 750 ширхгийг тарааж, төлөвлөгөөг 2.1 дахин давуулан биелүүлж ажилласан. “Чингэлтэй дүүргийн өрх, хүн ам”, “Дүүргийн аюулгүй байдал, гэмт хэргийн танилцуулга”, “Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга”, “Барилгын салбарын танилцуулга”, “Хөрөнгө оруулалт”, “Аж үйлдвэрийн салбарын танилцуулга”, “Боловсролын салбарын танилцуулга”, “Бизнес регистр”, “Эрүүл мэндийн салбарын танилцуулга”, “Тээврийн танилцуулга”-ыг боловсруулан нэгтгэн гаргаж, нийт 290 ширхгийг хэвлэн Дүүргийн Засаг дарга, хэлтэс албадын дарга, удирдлагуудад хүргүүлэн ажилласан.</p>					
	66	3.1.6.2. Хүн ам, өрхийн мэдээллийн санг баяжуулж, мэдээллийн чанарыг сайжруулна.	97	Нийслэлийн төсөв	СХ	100
<p>БИЕЛЭЛТ: Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтын явцын мэдээг өдөр бүр гаргаж, хороодын Засаг дарга, зохион байгуулагч нарт танилцуулан баяжилтыг тогтмол хийх, алдааг засварлуулах үүрэг өгч, зөвлөн тусалж ажилласан. Шинэ төрсөн хүүхэд, нас барсан иргэний мэдээллийг бүртгэж, өрх, хүн амын алдааны үзүүлэлт буюу нийт алдааны 92.4 хувийг засварласан.</p>						
3.2. ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ						
3.2.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	67	3.2.1.1. “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.	50%	66.2	ХХҮХ, БИТ	90
<p>БИЕЛЭЛТ: 1.“Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” хөтөлбөрийн хүрээнд 9 удаагийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 139 үйлдвэр эрхлэгчдийг хамруулж бараа бүтээгдэхүүнийг иргэдэд сурталчилж 69,639,000 мянган төгрөгийн борлуулалт хийсэн.</p> <p>2. “Чингэлтэйд үйлдвэрлэв” салбар цэгүүдийн тогтвортой үйл ажиллагааг ханган төсөл, хөтөлбөрийг тогтмол</p>						

		<p>сурталчилж европ хувцас, бэлэг дурсгал, сүлжмэл, модон эдлэл, арьсан эдлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 үйлдвэрлэгчдийн 2144 бараа бүтээгдэхүүн худалдаалагдаж 113,329,700 төгрөгийн борлуулалт хийгдсэн.</p> <p>3. Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвөөс 64 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1395 үйлдвэр эрхлэгч, иргэдийг хамруулж, мэдээ мэдээллийг тогтмол хүргэж тэдгээрийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэснээр үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо өмнөх оныхоос 70 үйлдвэрлэл эрхлэгчдээр нэмэгдэж үр дүнтэй ажилласан байна.</p> <p>4. Үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 411 үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүн, 50 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулан видео контент бэлтгэж “Үндэсний худалдаа үйлдвэрлэл ЧДБИТ”, “Чингэлтэйд үйлдвэрлэв” цахим сүлжээ хаягуудыг ашиглан олон нийтэд сурталчлан ажилласнаар нийт давхардсан тоогоор 120,612 хандалт авсан.</p> <p>5. Бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зээл, төсөл хөтөлбөрт 78 үйлдвэрлэл эрхлэгчдийг 3,057,000.000 тэрбум төгрөгийн зээл, төсөл хөтөлбөрт хамруулж ажилласан.</p> <p>6. “Зөөврийн ажлын байранд үйлдвэрлэгч сонгон шалгаруулах, хамтран ажиллах журам”-ын хүрээнд дүүргийн хэмжээнд нийт 123 зөөврийн ажлын байрны ашиглалт, хамгаалалтад хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүний шалгалтаар үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 110, зориулалтын дагуу ашиглаагүй 7 иргэнд мэдэгдэл хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>7. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвтэй хамтран “Чингэлтэйд үйлдвэрлэв-2022” чуулга уулзалтыг “Төрөөс жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлж байгаа бодлогын дэмжлэг ба өнөөгийн байдал”, “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал ба гарц шийдэл” сэдвийн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд дүүргийн 36 үйлдвэр эрхлэгчийн 200 бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа гаргаж, сурталчлан ажилласан.</p>					
<p>3.2.2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийг дэмжинэ.</p>	68	<p>3.2.2.1. Зочид буудал, аялал жуулчлал, худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.</p>	<p>Зочид буудал, аялал жуулчлал, худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын 750 аж ахуйн нэгж байгууллага, ажилтан.</p>	5.5	ХХҮХ, НАЖГ	100	
		<p>БИЕЛЭЛТ: 1. Швейцарын хөгжлийн агентлаг (SDC) болон “Ай Хотел” ХХК-ийн хамтран хэрэгжүүлж буй “My Hotel-Аялал жуулчлал, Байрших үйлчилгээний салбар дахь цахим шилжилт” төсөл нь тухайн салбарын цахим экосистемийн хөгжлийг дэмжих замаар цахим сургалтын платформ бий болгох, аж ахуйн нэгжүүдийн орлогыг өсгөх болон уг салбарын талаарх олон нийтийн мэдлэгийг сайжруулах зорилготойгоор “My hotel-аялал жуулчлал, байрших үйлчилгээний салбарын цахим шилжилт төсөл” цахим сургалтыг нийслэлийн Аялал жуулчлалын газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Швейцарын хөгжлийн агентлаг (SDC) болон “Ай Хотел” ХХК-тай хамтран зохион байгууллаа. Тус сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг амралтын газар 3, зочид буудал 10, дэн буудал 7 нийт 25 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагууд оролцлоо.</p>					

		2. Худалдаа, хоол үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, авто үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг давхардсан тоогоор 1956 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад “Цахим үндэстэн” хөтөлбөрийн хүрээнд бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх, хууль тогтоомж, стандартыг хэрэглэх мэдлэг мэдээлэл олгох зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамж, www.ulaanbaatar.mn сайтын “Онлайн бизнес төв”-ийн үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд бүртгүүлэх талаар 14 удаагийн сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж, цогц мэдээллийг өгч ажилласан. Онлайн бизнес төв /erp.ulaanbaatar.mn/ системд, хоол үйлдвэрлэл, худалдаа, ахуйн үйлчилгээ, авто үйлчилгээний чиглэлээр иргэн, аж ахуйн нэгжээс 925 хүсэлт ирүүлсэн. Шийдвэрлэлтийн явц 80%-тай байна.				
	69	3.2.2.2. Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008, Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд ерөнхий шаардлага MNS 6043:2009 стандартыг хяналтын хуудасны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй зочид буудлуудад хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулж, бүртгэл судалгааг сайжруулж, стандартын түвшинд ойртуулна.	80%	0.5	ХХҮХ, НАЖГ, МХХ, ЦГ	
		БИЕЛЭЛТ: Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/176, А/177 дугаар захирамж болон Засгийн газрын өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бууруулж шар түвшинд шилжүүлсэн, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төрийн хяналт шалгалтыг 3 жилийн хугацаатайгаар түр зогсоох шийдвэрийн дагуу төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан хяналт шалгалтыг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс хойш явуулаагүй бөгөөд дүүргийн 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг зочид буудалд 13, дэн буудал 10, амралтын газар 5, нийт 28 аж ахуйн нэгж, байгууллагад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 удаагийн зөвлөн туслах хяналт шалгалтыг зохион байгуулж, бүртгэл судалгааг шинэчлэн гаргаж, 202214017 дугаартай шаардлагыг хүргүүлсэн. Зочид буудал, Дэн буудлыг шалгах явцад гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд-1, оргодол этгээд 1-ийг олж тогтоон холбогдох газар хэлтэст хүлээлгэн өгсөн. Мөн архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулагдаж буй “Намайг алгас” аяны хүрээнд нийт 24 зочид буудалд №05 дугаартай зөвлөмж хүргүүлэв. БНСУ-ын Сэжун Их сургууль, НАЖГ-тай хамтран зохион байгуулсан жуулчны баазын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, стандартыг мөрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, хөгжүүлэх, ажилтнуудад мэдлэг, мэдээлэл олгох, хамтран хөгжих, туршлага солилцох сургалтад 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг Сутай тур ХХК, Ойн дурсамж ХХК, Ойн булаг ХХК-ийн нийт 3 амралтын газруудыг хамруулан ажилласан.				90
3.2.3. Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний	70	3.2.3.1. Шинэ ургацын төмс, хүнсний ногоо, худалдан борлуулах, мод үр үрслэгээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж,	5	2.5	ХХҮХ	100

ногоогоор хангах нөхцөлийг бүрдүүлэн, газар тариалангийн бүс нутгийн аймаг, сум, тариалалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжинэ.		тариаланч иргэдийг дэмжин ажиллана.			
		<p>БИЕЛЭЛТ: 1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/496 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 01/447 дугаар албан бичиг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/102 дугаар тушаал, 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/238 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулахаар дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачдын талбайд 4 болон 10 дугаар саруудад “Мод, бут сөөг, үр үрслэгээний үзэсгэлэн худалдаа-2022” арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үзэсгэлэн худалдаанд 30 иргэн, 18 аж ахуйн нэгж оролцож, шилмүүст болон навчит, гоёлын бут сөөг, үрсэлгээ, тасалгааны болон мандлын цэцгийн үрсэлгээ, ногооны үр зэрэг 100 нэр төрлийн 6000 ширхэг мод бут, сөөг худалдаалагдаж, 130.0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.</p> <p>2. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдааг зохион байгуулах тухай” А/138 дугаар тушаалаар “Алтан намар” арга хэмжээний хүрээнд төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах байршил, мөрдөх түр заавар батлагдсан. Тушаалын дагуу дүүргийн 2 дугаар хороо, Эрдэнэбулган ХХК-ийн Содон бөмбөгөр худалдааны төвийн гадна талбайд 10, Алтжин бөмбөгөр төвийн гадна талбайд 3 асар, 5 дугаар хороо, Тусгаар тогтнолын талбайд 45 асар, 20 дугаар хороо, Зунжин бүсэд 2 асар нийт 60 иргэн, аж ахуйн нэгж 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд эх орны хөрсөнд ургасан 23 нэр төрлийн төмс, хүнсний ногоог худалдаалж Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангасан байна. Тус үзэсгэлэн худалдаагаар 910.0 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон байна.</p> <p>3. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/158 дугаар тушаалаар “Намрын ногоон өдрүүд-2022” арга хэмжээний хүрээнд дүүргийн худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн 5 аж ахуйн нэгжийг хамруулан ажиллалаа.</p>			
71	3.2.3.2. Ногоо тариалах хүсэлтэй иргэдийг бүлэг үүсгэх замаар төмс, хүнсний ногоо тариалуулж, худаг усжуулалт болон ногоо хадгалах бололцоогоор хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн ажлын байр бий болгоно.	Эмзэг бүлгийн айл өрхүүдийг ногоо тариалах бүлэг үүсгэн тариалах газар, усалгаа, үр тариагаар хангаж 10 бүлэгтэй 150 иргэний өрхийн амьжиргааг дээшлүүлж өрхийн орлого нэмэгдүүлнэ.	15.0	ХХҮХ, ХөХҮХ	90
	<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 133 тоот албан бичгийн дагуу иргэдийг хүнсний ногоо тариалах арга барилд сурган ажлын байр бий болгох замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэн, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Улаанбаатар Агро парк”-д хүнсний ногоо тариалах арга хэмжээнд зорилтот бүлгийн 50 иргэнийг хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 6 бүлгийн 95 иргэнийг төмс хүнсний ногоо тарих арга хэмжээнд хамруулснаар 46 га газарт хүнсний ногоо</p>				

	тариалж, 23 нэр төрлийн 217 тн ургац хураасан. Уг арга хэмжээний хүрээнд 40 тн багтаамжтай 3 ширхэг чингэлгийг дүүргийн 10, 17, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлуулан хүнсний ногоо худалдаалах хүсэлт ирүүлсэн 3 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна.				
72	3.2.3.3. Өвлийн хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлж, иргэдийг амин дэмээр баялаг жимс, хүнсний ногоогоор тогтмол хангах боломжийг бүрдүүлнэ.	Хаврын тариалалт хийх хүсэлтэй иргэдийн дунд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 1-2 удаагийн сургалт зохион байгуулж, 10 өрхөд өвлийн хүлэмжийг өгч хүнсний ногооны тариалах нөхцөлийг бүрдүүлж өгнө.	15.0	ХХҮХ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв	90
<p>БИЕЛЭЛТ: Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны судалгаа хөгжлийн төвөөс зохион байгуулсан газар тариалан эрхлэгчдэд хүлэмжийн аж ахуйн технологи, ил талбайд үрслэг шилжүүлэх арга технологийг зааж сургах, нэгдсэн систем, өрхийн жижиг аж ахуйгаас бизнесээ эхлэх боломжийг хөгжүүлэхэд SHEP аргын талаар танилцуулах сургалтад дүүргийн хүлэмжийн аж ахуй эрхлэгч 3 иргэнийг хамруулан ажилласан. Улсын хэмжээнд 2022 онд хүнсний ногооны 80 хувийг дотооддоо хангах зорилтын хүрээнд Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвөөс хүлэмжийн аж ахуй эрхлэх хүсэлтэй дүүргийн 16 иргэнийг бүртгэлд хамруулан, сургалт зохион байгуулж, аж ахуй эрхлэгч 2 өрхөд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд өвлийн хүлэмж олгохоор ажиллаж байна.</p>					
73	3.2.3.4. Хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНБ-ыг сургалтад хамруулж, зөвлөмж үзүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажиллана.	Хаврын тариалалт хийх хүсэлтэй иргэдийн дунд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 1-2 удаагийн сургалт зохион байгуулж, 270 гаруй өрхөд хүнсний ногооны үр тараах ажлыг зохион байгуулна.	12.0	ХХҮХ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв	100
<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 03/112 дугаартай албан бичгийн дагуу хаврын</p>					

		<p>тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд хороодын төмс, хүнсний ногоо тариалдаг 253 өрхөд 10 төрлийн 11,7 кг хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүйгээр олгох ажлыг зохион байгуулан ажиллалаа. Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газраас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон 50 кг 99,800 төгрөгийн төл сонгинын үрийг дүүргийн 12 хорооны 12 өрхөд тарааж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажилласан.</p> <p>Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, түүний харьяа сургалт судалгааны төв, Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс хамтран 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 35 иргэн, аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулсан. Сургалтаар газар тариалангийн салбарын мэдээ мэдээллийн нэгдсэн цахим системд /plant.mofa.gov.mn/ бүртгэх, тариаланч, ногоочдод мэдээллээ хэрхэн оруулах, тайлагнах талаар мэдээллийг хүргэж тус системд бүртгэн, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн болон мөнгөн бус урамшуулал олгох журам, ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам, QR код ашиглан төлбөрийн баримт үүсгэх талаар мэдээ мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p>						
3.2.4. Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд хэрэглэгчдийн хүнсний талаарх боловсролын түвшнийг дээшлүүлэх талаар анхаарч ажиллана.	74	3.2.4.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын чанар хүртээмжийг сайжруулах, зорилгоор худалдаа үйлчилгээний чиглэлээр шинээр гарсан болон дагаж мөрдөгдөж буй хууль, дүрэм журмуудын талаар хэрэглэгчдэд зориулсан гарын авлага, материал бэлтгэж иргэд, ААНБ-дад олгоно.	Хэрэглэгчдэд зориулсан гарын авлага, тараах материал 400 ширхгийг бэлтгэж тараана	6.0	ХХҮХ, МХХ	100		
<p>БИЕЛЭЛТ: 1.“Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ын шинэчилсэн төслийн цахим хэлэлцүүлгийг дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нийт 110 иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг оролцуулан зохион байгуулж, журмын төсөлд тусгуулах 15 саналыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажиллалаа.</p> <p>2. “Хүүхэд-Эрхэм хэрэглэгч” аяны хүрээнд “Электрон тамхины хор уршиг эрүүл мэндэд, үзүүлэх сөрөг нөлөөлөл” зөвлөмж, гарын авлага бэлтгэн дүүргийн нутаг дэвсгэрт тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 200 аж ахуйн нэгжид, “Сургалт зохион байгуулах тухай” А/73 дугаар тушаалын дагуу “Хуванцар саван дээрх тэмдэг, тэмдэглэгээ, код тайлбар, утга учир” гарын авлагыг бэлтгэн 500 ширхгийг, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 02-01/105, дэд даргын 02-03/145 дугаартай “Эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” зөвлөмж, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын 02-20/18 дугаартай захирамжийн дагуу хүнсний худалдаа эрхлэгч 572, хоол 55 иргэн, аж ахуйн нэгж үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>								
3.2.5. Гэр хороололд нийтийн ахуйн үйлчилгээний төвлөрсөн бичил төвүүдийг байгуулж, хөрөнгө оруулалтын төсөл, иргэдийн санал санаачилгыг дэмжин	75	3.2.5.1. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дүүргийн өмчлөлд байгаа халуун усны газруудын үйл ажиллагаа, ашиглалтыг сайжруулах замаар хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх, ахуйн үйлчилгээний төвийн	1	7.0	ХХҮХ, Улаанбаатар хөгжлийн корпорац	90		

ажиллана.		тоог нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын ажил хэрэгжүүлнэ.				
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн 7-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийтийн халуун усны үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшлийн 22 иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, үйлчилгээний стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, ариутгал халдваргүйтгэлийн дэглэм сахиулах, үйлчилгээний чанар, соёлыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Захирагчийн ажлын албаны Хүнс, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтсийн дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн хяналт шалгалтыг зохион байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Дүүргийн өмчийн 5 халуун усны газруудад шалгалт хийн ашиглалт, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ашиглагдахгүй байгаа халуун усны барилгуудыг дахин үнэлгээ хийлгүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>				
	76	3.2.5.2. Гэр хорооллын нийтийн ахуйн үйлчилгээний төвлөрсөн бичил төвүүдэд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Стандартыг сурталчлах сургалтыг 2 удаа зохион байгуулж холбогдох дүрэм, журмын талаар тараах материалаар хангана.	1.5	ХХҮХ, Улаанбаатар хөгжлийн корпорац	100
	<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо"-ноос санаачлан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлж, төв хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 80 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллийг оролцуулан "Онлайн бизнес төв" үйлчилгээ эрхлэх бүртгэлийн цахим системд бүртгүүлэх, "Цахим шилжилтэд хамтдаа" систем танилцуулах, холбогдох дүрэм, журмын талаар сургалтыг зохион байгуулан гарын авлага, тараах материалаар ханган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 05/964 тоот албан бичгийн дагуу Монголын Мэргэжлийн хумс урлал, гоо сайхны нэгдсэн холбооноос "Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 6843:2020" стандартыг танилцуулах сургалтыг зохион байгуулан, хумс заслын үйл ажиллагаа эрхлэгч 38 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан ажилласан.</p>					
3.2.6. Авто үйлчилгээний салбарт тавих стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэж, хяналт шалгалтыг сайжруулах замаар тохирлын үнэлгээнд бүрэн хамруулж, байгаль орчинд ээлтэй технологийг	77	3.2.6.1. Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуй нэгжид холбогдох дүрэм, журам мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт, шалгалт зохион байгуулж сургалтад хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.	Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 160 аж ахуйн нэгж байгууллага болон иргэдэд хяналт	1.25	ХХҮХ, ЦГ, МХХ	100

<p>нэвтрүүлэх, хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулах ажлыг зохион байгуулна.</p>		<p>шалгалт хийж, 175 аж ахуй нэгж байгууллага болон иргэдэд сургалт зохион байгуулна.</p>		
<p>БИЕЛЭЛТ: 1. Дүүргийн 12, 14, 15, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах авто үйлчилгээ, дугуй засвар, сэлбэг худалдаа, барилгын материал худалдаалах 75 байгууллага аж, ахуй нэгжийн үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, хороодын ажлын алба, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багийн бүрэлдэхүүнтэй 2022 оны 04 дүгээр сарын 20, 26-ны өдрүүд, 05 дугаар сарын 28, 30-ны өдрүүдэд зөвлөн туслах хяналт шалгалтыг хийсэн бөгөөд шалгалтад хамрагдсан 20 авто үйлчилгээ, дугуй засвар, сэлбэг худалдаа, барилгын материал худалдаалах цэг зөвшөөрөлгүйгээр нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний орц, гарц замыг хааж үйл ажиллагаа явуулсан зөрчлийг газар дээр нь арилгуулж, 14 дүгээр хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багийн гишүүд зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд батлагдсан хуваарийн дагуу хяналт тавьж тайлан мэдээг авч ажилласан.</p> <p>2. Дүүргийн Прокурорын газар, Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын хамтран баталсан “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй авто угаалгын газруудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ахуйн нөхцөлийг шалган, танилцах тухай” удирдамжийн хүрээнд дүүргийн нийт 8 хорооны 32 газрын үйл ажиллагаанд “Авто машины угаалгын үйлчилгээ. Ангилал, ерөнхий шаардлага” MNS 5347:2003 стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, 25 зөрчил илэрснийг газар дээр нь арилгуулж, 23 зөвлөмж гарын авлага тараан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>3. Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 192.1.1, 192.3.2, 192.3.3, 192.3.6-д заасны дагуу авто үйлчилгээний ангиллын хугацаа дууссан болон ангилал тогтоолгоогүй авто үйлчилгээ эрхлэгч 48 иргэн, аж ахуй нэгж байгууллагад А1, В1, С1 тохирлын үнэлгээ хийлгэх, сунгуулах талаар зөвлөмж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>4. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 тушаалын хүрээнд авто тээврийн салбарт мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, стандартуудыг хэрэглэх, мэдлэг мэдээлэл олгох, галын аюулгүй ажиллагаа, хяналтын тогтолцоог чанаржуулах, хариуцлага, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр танхимаар сургалт зохион байгуулан ажиллалаа. Сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 30 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож, “Онлайн бизнес төв”, “Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зориулсан хууль, эрх зүйн эмхэтгэл” гарын авлага тараасан. Дүүргийн 10-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох дүрэм журам мөрдөгдөж байгаа эсэх, насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулж байгаа эсэх, хөдөө орон нутаг болон бусад газраас байрлан ажиллаж байгаа иргэдийг бүртгэлжүүлэх, Цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг олж тогтоох зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд “Авто засвар” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр нийт 50 аж ахуйн нэгжийг шалгаж, 67 иргэнийг бүртгэл судалгаанд авч, эрэн сурвалжлагдаж байсан 10 этгээдийг олж тогтоосон бөгөөд дүүргийн 10 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг “Шинэчлэл” авто угаалга, 12 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг “Нийслэл” “Жаран нэг” “Наян дөрөв” зэрэг авто угаалгын газарт хэсгийн байцаагч нар хэсэгчилсэн хяналт шалгалт зохион байгуулж, гэмт</p>				

		хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.				
3.2.7. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүнс, худалдаа үйлчилгээ, барилга, эрүүл мэнд, боловсролын салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэнэ.	78	3.2.7.1. Худалдаа, нийтийн хоолны салбарт тавигдах стандартын хэрэгжилтийг хангуулж, хяналт шалгалт, мэргэжил арга зүйн удирдлагаар байгууллагуудыг хангаж ажиллана.	Худалдаа, хоолны газруудын үйл ажиллагаанд тавих хяналт сайжирна.	2.0	MXX, XXYX	100
	<p>БИЕЛЭЛТ: 1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу дүүргийн 1-24 дүгээр хорооны согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгуулах 39, шинээр авах 8 нийт 47 аж ахуй нэгжийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах саналыг хүргүүлэн үйл ажиллагааг дэмжин ажилласан.</p> <p>2. Дүүргийн нутаг дэвсгэрт тамхи худалдах тусгай зөвшөөрлийг шинээр авах 7, сунгуулах хүсэлтээ ирүүлсэн 25 нийт 32 иргэн, аж ахуйн нэгжийн холбогдох бичиг баримтын бүрдэлтийг хангуулан ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин тусгай зөвшөөрлийг олгон ажилласан.</p> <p>3. Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дэд даргын 2021 оны 01/16 дугаартай “Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан шалгалт хийж дүгнэлт гаргах тухай” удирдамжийн хүрээнд шинээр хүсэлт гаргасан 7 ААНБ, иргэний хүсэлт ирүүлснээс эрсдэл бага үнэлэгдсэн 5 иргэн, аж ахуйн нэгжид үйл ажиллагааны дүгнэлт гаргасан.</p> <p>4. Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан “Дулааны аргаар мах боловсруулсан болон адууны мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай”, “Мал төхөөрөх газар, цех, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 21 иргэн, аж ахуйн нэгжид шалгалт хийж, 4 аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлд хэрэглэж байгаа ус, 7 цехийн түүхий эд, бүтээгдэхүүнээс дээж авч Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Нэгдсэн төв лаборатори, Улсын Мал эмнэлгийн ариун цэврийн Төв лабораторид шинжилгээнд хамруулсан. Шалгалтын явцад илэрсэн зөрлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 45 заалттай 8 албан шаардлага хүргүүлж, 41 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад улсын ахлах байцаагчийн зөвлөмж, хүргүүлэн ажиллаж байна.</p>					
	79	3.2.7.2. Хүнсний худалдаа, үйлдвэр үйлчилгээний газруудад Хүнсний аюулгүй байдал, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний сонголт, эрүүл ахуйн зохистой дадлыг хэрэгжүүлэх нь” салбарын сургалт зохион байгуулна.	Үйлдвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд тавих хяналт сайжирна.	3.0	MXX, XXYX	100
<p>БИЕЛЭЛТ: Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/73, А/79 дүгээр тушаалын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг худалдааны 85, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 75 нийт 160 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад эрүүл ахуйн зохистой дадлын мэдлэг олгох, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад хэрэглэгдэж байгаа хүнсний зориулалтын бус хуванцар савны хор холбогдлын талаар мэдээлэл өгөх сургалтыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн Эрүүл мэндийн Үндэсний төв, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс,</p>						

		дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс хамтран 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр танхимаар зохион байгуулсан.				
3.3. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ						
3.3.1. “Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд “Сэлбэ дэд төв”-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлж, “Дэнжийн мянга” дэд төвийн төслийг эхлүүлэх ажлыг зохион байгуулна.	80	3.3.1.1 “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.	Тухай бүрд үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилласан байна.	-	ТГУХ, ГЗБА	100
	<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 198 дугаар “Ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөг батлах тухай” тогтоолоор Чингэлтэй дүүргийн 14, 15, 18, 19 дүгээр хороо, Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын хойд бүсийн Сэлбэ дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 156,0 га талбайд баталсан. Дэд төвийн хэмжээнд газар чөлөөлөлтийн явц 100% хувьтай хийгдэж иргэдэд нөхөн олговор бүрэн олгогдсон.</p> <p>Авто зам, шугам сүлжээний нөлөөлөлд 354 нэгж талбар Цэцэрлэг, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нөлөөлөлд 19 нэгж талбар Под станцын нөлөөлөлд 14 нэгж талбар Дулааны станцын нөлөөлөлд 27 нэгж талбар Ариутгах татуургын нөлөөлөлд 3 нэгж талбар тус тус өртсөн байна. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь тухай бүр үйл ажиллагааны тайлангаа ирүүлэн ажиллаж байна.</p>					
	81	3.3.1.2. “Дэнжийн мянга дэд төв”-ийн төслийг эхлүүлэхэд шаардлагатай мэдээллээр ханган ажиллах	Барилга угсралтын ажил хийгдэж дууссан байна. Тухай бүрд судалгаа мэдээллээр ханган ажилласан байна.	-	ТГУХ, ГЗБА	30
БИЕЛЭЛТ: Төсөл хэрэгжүүлэх нэгжээс дүүргийн нутаг дэвсгэрт авто зам, инженерийн шугам сүлжээ, нийгмийн барилга байгууламжийн ажил хийгдэхээр судалгаа хийгдэж байна. Үүний дагуу хийгдэх ажлын тайланг тухай бүр Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар хүргүүлэн ажилладаг.						
3.3.2. Дүүргийн төр захиргааны байрыг Улаанбаатар хотын төвлөрлөөс гаргаж гэр хороолол дунд шинээр барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	82	3.3.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, батлуулна.	-	-	ТГУХ, ГЗБА	70
		<p>БИЕЛЭЛТ: Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар 400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны зураг төсөл” төсөл, арга хэмжээ батлагдсан бөгөөд Барилга, хот байгуулалтын яамнаас тендер зарлан “Эм Эм инженеринг” ХХК шалгаран зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэж байна.</p> <p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар газар чөлөөлөлтийн ажил хийгдэх 112 нэгж талбараас 69 нэгж талбарын газрыг чөлөөлж иргэдэд нөхөн олговрыг бүрэн олгосон. Үлдсэн 43 нэгж талбарт нөхөх олговрын зориулалттай үнэлгээний хэмжилт хийгдэж байгаа бөгөөд он дамжин хэрэгжинэ.</p>				

	83	3.3.2.2. Дүүргийн Тамгын газрын байрын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	Газар чөлөөлөлт хийгдэж, зураг төсвийн ажил хийгдсэн байна. Барилга угсралтын ажил эхэлсэн байна.	-	ТГУХ, ГЗБА	50
		<p>БИЕЛЭЛТ: Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар 400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны зураг төсөл” төсөл, арга хэмжээ батлагдсан бөгөөд Барилга, хот байгуулалтын яамнаас тендер зарлан “Эм Эм инженеринг” ХХК шалгаран зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэж байна.</p> <p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар газар чөлөөлөлтийн ажил хийгдэх 112 нэгж талбараас 69 нэгж талбарын газрыг чөлөөлж иргэдэд нөхөн олговрыг бүрэн олгосон. Үлдсэн 43 нэгж талбарт нөхөх олговрын зориулалттай үнэлгээний хэмжилт хийгдэж байгаа бөгөөд он дамжин хэрэгжинэ.</p> <p>Нийслэлийн засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/247 дугаар захирамжаар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 4796 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн.</p>				
3.3.3. Гэр хорооллын дунд “Дэд бүтцийн төв” (“Сервис центр”) нэмж байгуулна.	84	3.3.3.1. "Дэд бүтцийн төв" нэмж байгуулахад тухай бүрд шаардлагатай мэдээллээр хангаж, хяналт тавин ажиллана.	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Дэд бүтцийн төвийг нэмж байгуулах саналыг хүргүүлэх.	-	ТГУХ, ГЗБА	30
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн 10, 11, 12, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт авто зам, шугам сүлжээ, нийгмийн барилга байгууламжийн болон ус дулаан дамжуулах төв, цахилгааны дэд станц, насос станцын зориулалттай 12.8 га газарт чөлөөлөлтийн ажил хийгдэхээр төлөвлөгдсөн.</p>				
3.3.4. Улс, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж ажиллана.	85	3.3.4.1. Улс, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 сарын 16-ны өдрийн 12 тоот тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	2022 оны “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллана.	-	ГЗБА, ХЭЗХ	100
		<p>БИЕЛЭЛТ: 1. Дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлуулж, 4 бүлгийн 15 дэд бүлэгт хамаарах 101 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>-Газрын менежментийг хэрэгжүүлэх талаар 27 ажил: 88%</p> <p>-Газар зохион байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ 40 ажил: 83 %</p> <p>-Хот байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ 6 ажил: 100%</p>				

		<p>-Нөхөх олговор олгох, газрын байршил, хэмжээ 28 ажил: 85 хувьтай хэрэгжсэн.</p> <p>1. Газрын кадастрын системд иргэдээс газар эзэмших эрхээ баталгаажуулах, нэр шилжүүлэх, талбайн хэмжээ өөрчлөх, хугацаа сунгах асуудлаар нийт 3213 хүсэлтийг бүртгэснээс дүүргийн Засаг даргын 21 удаагийн захирамжаар 2670 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 543 иргэдийн хүсэлт дүүргийн Засаг даргын захирамжийн төсөлд хянагдаж байна.</p> <p>2. Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/388 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 12 байршлын 168 гараашны газрыг албадан чөлөөлөхөөр төлөвлөгдсөн боловч 2 байршлын нийт 34 гарааш шүүхийн маргаантай байгаа тул чөлөөлөлтийн ажил түр зогссон. Өнөөдрийн байдлаар 10 байршлын 134 объектыг 87,100.000 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй газар чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Чөлөөлсөн байршлуудад иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл, боломжийг хангасан ажлууд шат дараатай хийгдэж байна.</p> <p>3. Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, талаар авах зарим арга хэмжээний тухай" А/585 дугаар захирамжийн хүрээнд нийт 105 байршлын 4088 м2 газрыг чөлөөлөхөөс 98 байршлын 3721 м2 газрыг чөлөөлсөн. Үлдсэн 7 байршил нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 24/17 дугаар тогтоолын хавсралт буюу нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах журмыг хангасан тул чөлөөлөх боломжгүй байна.</p>				
3.3.5. Сууц өмчлөгчдийн холбоод, нийтийн аж ахуйн чиглэлийн үйл ажиллагааны чанар болон тогтолцоог боловсронгуй болгож, олон жилийн насжилттай орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулна.	86	3.3.5.1. Сууц өмчлөгчдийн холбоод, нийтийн аж ахуйн чиглэлийн үйл ажиллагааны чанар болон тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор түвшин тогтоох шалгалт зохион байгуулж үнэлгээ өгч ажиллана.	60	0.125	ТНААХ, ХОРООД	90
		<p>БИЕЛЭЛТ: Арга хэмжээний хүрээнд Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлтэй хамтран Чингэлтэй дүүргийн Сууц Өмчлөгчдийн Холбоодын үйл ажиллагааг шалгах "Түвшин тогтоох" үзлэг шалгалтыг зохион байгуулж Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлд гишүүнчлэлтэй 40 СӨХ түвшинт тогтоох үзлэг шалгалтад хамрагдахаас 36 сууц өмчлөгчдийн холбоо үзлэг шалгалтад хамрагдаж 4 СӨХ-ийн гүйцэтгэх захирал нар өвчтэй, чөлөөтэй шалтгаанаар үзлэг шалгалтад хамрагдаагүй байна.</p> <p>Түвшин тогтоох үзлэг шалгалтын дүнгээр 2 дугаар байр Тэргүүний СӨХ-өөр "Батхолбоо 40" 3 дугаар байр Тэргүүний СӨХ "Ялалт", "Ирээдүй 3", хошой аваргаар "Чандмань", "Дөчийн анхдагч" СӨХ-д тус тус шалгарч 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн удирдлагууд шагналыг гардуулан өгсөн.</p>				
	87	3.3.5.2. Олон жилийн насжилттай орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулна.	Дээвэр-3 Фасад-3	900,0	ТНААХ, ХОРООД	100
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар орон сууцны барилын 8 дээвэр, 5 фасад засварын ажлыг бүрэн хүлээж авсан. Мөн Нийслэл болон Дүүргийн хөрөнгө оруулалтаар орон сууцны барилгын 10 дээвэр, 14 фасад засварын ажлыг он дамжин гүйцэтгэхээр гэрээг байгуулан ажиллаж байна. Үүнд:</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Дэлгэр мөрөн групп" ХХК 2021-2022 онд 9 байрны дээвэр засвар, 7 байрны фасад засвар хийхээс 2021 онд 8 байрны дээвэр засвар, 3 байрны фасад засварыг хийж гүйцэтгэсэн</p>				

		бөгөөд 2022 онд 1 байрны дээвэр засвар, 4 байрны фасад засварын ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэй хийсэн. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 9 байрны фасад засвар, 7 байрны дээвэр засвар хийгдэхээс 2022 онд 7 байрны дээвэр засвар, 1 байрны фасад засвар хийгдэж 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр комисс ашиглалтад авч, 2023 онд 8 байрны фасад засварын ажил хийж гүйцэтгэнэ. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд орон сууцны 10 байрны дээвэр, 3 байрны фасад засвар хийгдэхээр худалдан авах ажиллагаа зарлагдаж “Зост өргөө” ХХК тендерт шалгарсан байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 3, 4, 5 дугаар хорооны 3 байрны фасад засварын ажлыг хийж гүйцэтгэхээр Ирмүүн бар ХХК, Шинэ өлгийн зам ХХК, Эс Эй Би Эй ХХК тендерт шалгарч 2023 онд засварыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулаад байна.				
3.3.6. Орон сууцны барилгуудын ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж хэвийн найдвартай ажиллагааг хангана.	88	3.3.6.1. Орон сууцны барилгуудын ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.	Сантехник-1 Цахилгаан-1	50,0	ТНААХ, ХОРООД	100
		БИЕЛЭЛТ: Дүүргийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 6 дугаар хороо, 62 дугаар байрны дулааны шугам ф89-90м, хэрэглээний халуун усны өгөх ф50-45 у/м, буцах ф40-45 м шугам буюу нийт 180м сүлжээг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөр ОСНААУГ-тай хамтран хэсэгчлэн шинэчилж ажилласан.				
3.3.7. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж нэгдсэн удирдлага-хяналтын системд холбож, “Жишиг гудамж”-уудын тоог гэр хороололд нэмэгдүүлнэ.	89	3.3.7.1. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.	110	176.0	ТНААХ	100
		БИЕЛЭЛТ: Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улс болон Дүүргийн хөрөнгө оруулалтаар 325 гэрэлтүүлгийг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 10, 16, 19 дүгээр хороонд 222 гэрэлтүүлгийг “Хустайн шил” ХХК хийж гүйцэтгэж 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр улсын комисс ашиглалтад хүлээн авсан. Дүүргийн хөрөнгө оруулалтаар “Хайрхан хөгжил төв” спорт цогцолборт гэрлэн чимэглэлтэй 43 гэрэлтүүлгийн ажлыг “Өндрийн уудам” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Мөн дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр дүүргийн 1-6, 8, 11, 15 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд 60 гэрэлтүүлгийг “Соёндрийм” ХХК шинээр хийж гүйцэтгэсэн байна.				
	90	3.3.7.2. “Жишиг гудамж”-уудын тоог гэр хороололд нэмэгдүүлнэ.	2	85.0	ТНААХ	100
		БИЕЛЭЛТ: Улсын төсвийн хөрөнгөөр 12 байршилд бетонон зам, байгалийн чулуун зам, хашаа шинэчлэх, зогсоол хийх зэрэг ажлууд төлөвлөгдөн ажлын даалгавар гаргуулж тендер зарлан Трайзинг ХХК шалгаран 12 дугаар хороонд бичил цэцэрлэг, 16 дугаар хороонд 1621эко хавтан, 19 дүгээр хороонд 405м2 эко хавтан, 172м2 явган зам хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 14 дүгээр хороонд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин “Чингисийн отог” ХХК 300м байгалийн чулуун зам, явган зам 700м2, хашаа шинэчлэх ажил 500у/м хийж жишиг гудамж бий болгосон. Мөн 13, 16, 19 дүгээр хороодод 5 байршилд бичил цэцэрлэг, тохижилтын ажлыг Люкс даймонд ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 144 гарааш буулгаж 7 байршилд тохижилтын ажил хийж гүйцэтгэсэн. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 8 дугаар хороонд 240 м явган замыг “Монгол туургатны зам” ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 13 дугаар хороо 17 дугаар сургуулийн гадна 3*3 сагсан бөмбөгийн				

		талбайг шинэчлэх засварын ажил хийгдэж байна. Улс, нийслэл дүүргийн төсвийн хөрөнгөөр дүүргийн хэмжээнд 15 бичил цэцэрлэг, 5 жишиг гудамж байгуулаад байна.				
3.3.8. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах төсөл хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	91	3.3.8.1. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдын орон сууцыг барьж, ашиглалтад оруулна.	70%	Батлагдсан төсвийн хүрээнд	ТЗУХ, ТГУХ	90
		БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын эрхлэх асуудлын шууд удирдлагад хамаарах төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд Дэнжийн-1000 орчим албан хаагчдын орон сууц барьж ашиглалтад оруулах талаар холбогдох судалгаа, зохион байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.				
3.3.9. Үерийн далан суваг, борооны ус болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, сэргээн засварлах, гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган зам, шат, гүүр барьж иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	92	3.3.9.1. Үерийн далан суваг, борооны ус болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, сэргээн засварлана.	Хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.	300.0	ТНААХ, ТҮК	100
		БИЕЛЭЛТ: Тайлант хугацаанд үерийн борооны ус зайлуулах хоолой 1098м, хөрсний ус зайлуулах, шүүрүүлийн байгууламж 457м тус тус хийгдсэн.Үүнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Хайлаастын авто замын ус зайлуулах хоолой” төсөл, арга хэмжээг “Эм даблью ти” ХХК хэрэгжүүлсэн. Уг төсөл арга хэмжээний хүрээнд 1088м ус зайлуулах хоолойг тавьж комисс ажиллуулах хүсэлтээ хүргүүлсэн байна. Дүүргийн 15 дугаар хорооны “Хорооллын доторх авто зам” төсөл арга хэмжээний хүрээнд авто замын борооны ус зайлуулах, шүүрүүлэх 10м байгууламж хийгдсэн. Геодези, Усны барилга байгууламжийн газартай хамтран дүүргийн 12 дугаар хороо, 61 дүгээр сургууль орчимд 198м хөрсний ус зайлуулах шугам, ус хүлээн авах шүүрт худаг бш, үзлэгийн худаг 8ш тус тус хийгдсэн. Мөн 19 дүгээр хороо, Доод салхитад 259м хөрсний ус зайлуулах шугам угсралт болон шугам угсралтын дараах нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажил” төсөл, арга хэмжээг “Вектор ус дриллинг” ХХК хэрэгжүүлж байна.				
	93	3.3.9.2. Гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган зам, шат, гүүр барьж иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	1 шат	-	ТНААХ, ТҮК	100
		БИЕЛЭЛТ: Тайлант хугацаанд гуу жалга бүхий 1 байршилд 8 м шат шинээр хийж, 3 гүүрэн байгууламжийн эвдрэлийг засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. Үүнд: Төлөвлөгөөнд тусгагдсанаар дүүргийн төсвийн урсгал зардлаар 15 дугаар хорооны нутаг дэвсгэрийн гуу жалга бүхий газарт 8 м шат хийх ажлыг Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК хийж гүйцэтгэн 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад оруулсан. Мөн дүүргийн 19 дүгээр хороо, 117 дугаар Ерөнхий боловсролын сургуулийн орчин Сэлбэ гол дээр байрлах явган хүний гүүрэн байгууламж, 17 дугаар хороо, Сурагчийн 50 дугаар гудамжны явган хүний гүүрэн байгууламж, 20 дугаар хороо, Хувьсгалчдын Г-11 дүгээр гудамжны гүүрэн байгууламжийн эвдрэлийг				

		"Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ" ХХК засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан.				
	94	3.3.9.3. Төмөр бетон гүүрний байгууламжийг шинээр барьж, өргөтгөж, шинэчилнэ.	-	-	ТНААХ, НХБХГ, НГЗБА	100
		БИЕЛЭЛТ: Дүүргийн төсвийн урсгал зардлаар 9 дүгээр хороо, Дэнж 2 дугаар гудамжны орчинд 11 у/м төмөр бетон гүүрийг өргөтгөн шинэчлэх ажлыг Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК-иар гүйцэтгүүлж ашиглалтад оруулсан.				
3.3.10. Хөрсний ус зайлуулах шугам сүлжээг хотын ерөнхий төлөвлөлттэй уялдуулан шинээр барих болон өргөтгөн шинэчлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	95	3.3.10.1. 7, 10, 12, 16, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт жалганд үерийн далангийн зураг төсөв хийлгэнэ.	-	-	ТНААХ, ХБХГ	100
		БИЕЛЭЛТ: Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "7, 10, 12, 16, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрийн жалганд үерийн далан хийх зураг төсөв" төсөл, арга хэмжээг "Гидродизайн инноваци" ХХК хэрэгжүүлэн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр 100 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өгсөн.				
	96	3.3.10.2. Одоо байгаа Дэнжийн 1000-I, II, III Баруун уул, төв цэвэрлэх орчмын үерийн далан сувгийг шинэчлэн засварлахад хамтран ажиллана.	1.5 км үерийн далан сувагт засвар шинэчлэлт хийсэн байна.	1.781.8	УБЗАА, ГУББГ, ТНААХ	90
		БИЕЛЭЛТ: Тайлант хугацаанд нийт 105 м далан сувгийг шинэчлэн засварласан. Үүнд: Геодези, Усны барилга байгууламжийн газарт дүүргийн нутаг дэвсгэр дэх бороо, үерийн усанд эвдэрсэн үерийн хамгаалалтын барилга байгууламжийг засварлуулахаар 3/2459, 3/1658 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5 у/м, 15 дугаар хорооны Хайлаастын далан дах 100 у/м үерийн хамгаалалтын далан суваг, бороо, үеийн усанд эвдэрснийг шинэчлэн засварлуулсан. Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Гүн нуурын арын жалга, Хайлаастын гудамжинд далан барих" төсөл, арга хэмжээг "Вектор ус дриллинг" ХХК хэрэгжүүлэн газар шорооны ажил, хоолой тавих ажил хийгдсэн, үерийн хамгаалалтын далангийн хавтан суурилуулах ажлыг хийж, ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна.				
3.3.12. Голын болон үерийн хамгаалалтын барилга байгууламжийн бүсийг нарийвчлан тогтоож тус бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг нүүлгэн шилжүүлж, хамгаалалтын бүсийн газрыг албажуулах ажлыг эхлүүлнэ.	97	3.3.12.1. Голын болон үерийн хамгаалалтын бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах.	30% /Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нүүлгэх/	Батлагдсан төсвийн хүрээнд	ТЗУХ, ГЗБА	70
		БИЕЛЭЛТ: Тус дүүргийн нутаг дэвсгэрт шар усны болон үерийн аюултай бүс, халиа дошин үүсэж болзошгүй газрын судалгааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 15/111 тоот албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Үерийн эрсдэлтэй бүсэд суурьшсан 46 айл өрхөд дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран мэдэгдэл хүргүүлсэн. Тухайн айл өрхүүдийг үер, усны аюулаас урьдчилан сэргийлж нүүлгэн шилжүүлэх байршлыг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт тогтоон ажилласан.				
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО						
4.1. МЭРГЭШСЭН, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА						

<p>4.1.1. Төрийн албаны үйл ажиллагаа, бүтээмж, чанарын удирдлагын нэгдсэн систем, хяналт хариуцлагын тогтолцоог шинэ шатанд гаргаж, төрийн албан хаагчийн ажиллах орчин нийгмийн баталгааг хангах зорилготой “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	98	<p>4.1.1.1. Төрийн албаны үйл ажиллагаа, бүтээмж, чанарын удирдлагын нэгдсэн систем, хяналт хариуцлагын тогтолцоог шинэ шатанд гаргаж, төрийн албан хаагчийн ажиллах орчин нийгмийн баталгааг хангах зорилготой “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.</p>	25%	-	ТЗУХ	90	
		<p>БИЕЛЭЛТ: “Хүний нөөц нийгмийн баталгаа-2024” арга хэмжээний хүрээнд 4 зорилт 11 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнан ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2023 онд өндөр настны тэтгэвэр тогтоолгох 3 албан хаагчийн судалгааг авч, ирэх оны төсөвт суулгахаар ажилласан ба төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа албан хаагчийн оронд Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийг үндэслэн 65 албан хаагчийг томилж, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийг үндэслэн 20 төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 34 удаагийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж давхардсан тоогоор нийт 1013 албан хаагч хамрагдсан.</p>					
<p>4.1.2. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, дүүргийн хөгжлийн талаарх үр ашигтай санал, санаачилгыг дэмжиж ажиллана.</p>	99	<p>4.1.2.1. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг цахим системд бүртгэн авч холбогдох хэлтэс, тасаг, албадад шилжүүлэн шийдвэрлүүлж хариуг хугацаанд нь бүрэн гүйцэд өгч зөрчил дутагдалгүй ажиллана.</p>	100%	-	ТЗУХ	90	
		<p>БИЕЛЭЛТ: Иргэдээс нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт хандаж цаасаар гаргасан өргөдөл, санал хүсэлт, гомдлыг UB ERP системд бүртгэн авч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нэгдсэн үйлчилгээний төвөөс UB ERP системээр ирж байгаа өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг дүүргийн удирдлага болон холбогдох хэлтэс, албадын дарга нарт шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Иргэдээс нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад 2022 онд нийт 4007 өргөдөл, гомдол ирснээс 94.0 хувь буюу 3776 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 1 хувь буюу 45 өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 4 хувь буюу 186 өргөдөл, гомдол одоогоор судлагдаж байна. Шийдвэрлэж хариу өгсөн 3821 өргөдөл, гомдлын 75.24 хувь буюу 2875 гомдлыг бүрэн барагдуулж, 16.14 хувь буюу 617 гомдолд боломжгүй тухай хариу өгч, 8.61 хувь буюу 329 гомдлыг бүрэн барагдуулж шийдвэрлээгүй, зөвхөн холбогдох тайлбар, мэдээллийг өгч хаасан байна.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 7 цаг 6 минут, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад нийт 38.4 хувь буюу 1542 зөрчил бүртгэгдсэн байна.</p>					

4.1.3. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллана.	100	4.1.3.1. Авлигатай тэмцэх газартай хамтран дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	20	-	ТЗУХ	100
	БИЕЛЭЛТ: “Эс Ай Си Эй” ХХК-ийн сургалтын байгууллагаас зохион байгуулсан Төрийн албаны шударга байдлын үнэлгээ”-ний судалгаанд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, тухайн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд, хамтран ажиллагч олон улсын болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн нийт 160 төлөөллийг хамруулсан. Дүүргийн Засаг даргын дэргэдэх алба, хэлтэс, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга, хороодын Засаг дарга, зохион байгуулагч нийт 196 албан хаагчийг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамруулж, мэдээлэл олгосон. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг “Авлигын эсрэг хамтдаа” сургалтад 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон 1-24 дүгээр хороодын албан хаагчдыг хамруулж ажилласан.					
4.1.4. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлого хэрэгжүүлнэ.	101	4.1.4.1. Холбогдох дээд шатны байгууллагаас баталсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан бүтцийг баталж мөрдөж ажиллана.	-	-	ТЗУХ	100
	БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Дүүргийн удирдлага, Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/1058 дугаар захирамжид нийцүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/02 дугаар захирамжийг гаргаж “Архив, бичиг хэргийн тасаг”-ийг “Архивын тасаг” гэж, “Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс”-ийг “Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс” гэж өөрчилж, Тамгын газрын бүтцэд “Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс”-ийг, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн бүтцэд “Аж ахуйн тасаг”-ийг тус тус нэмж, ТҮ-1, ТҮ-2, ТҮ-3 зэрэглэлийн албан тушаалуудыг Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-т шилжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуульд дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогч даргатай байна гэж заасны дагуу хууль тогтоомж, дээд байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах хүрээнд Засаг даргын Б/72 дугаар захирамжийн дагуу Инновац, хөгжлийн асуудал хариуцсан орлогч, Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч, Ногоон байгууламж, бохирдлын асуудал хариуцсан орлогчийг ажил, албан тушаалаас нь чөлөөлж, дүүргийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Б/81 дүгээр захирамжаар Дэд бүтэц, төлөвлөлтийн асуудал хариуцсан орлогчийн чиг үүргийг Засаг даргын орлогч гэж шинэчлэн тогтоосон. Мөн дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/226 дугаар захирамжаар Аж ахуйн тасгийн ТҮ 10-аас 18 болж, мөн үйлчлэгчийн орон тоо 5, харуулын орон тоо 3-аар нэмэгдсэн.					
	102	4.1.4.2. Байгууллагын үндсэн зорилго, зорилт, хууль тогтоомжид тусгагдсан чиг үүргүүд нь нэгжийн чиг үүргүүдэд, нэгжийн чиг үүрэг нь тухайн нэгжид харьяалагдах албан тушаалтнуудад албан ёсоор бүрэн	-	-	ТЗУХ	100

		хуваарилагдсан, орхигдсон эсвэл давхардсан эсэхийг тодорхойлж, чиг үүргийн хуваарилалтын уялдааг хянан, давхардал хийдлийг арилгах мэргэшлийн зөвлөгч нарын бүрэлдэхүүнтэй мэргэжлийн багаар ажлын байрны дүн шинжилгээг хийлгэж, чиг үүргийн хуваарилалтыг оновчтой болгох ажлыг зохион байгуулна.				
		БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/72 дугаар тушаалыг үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтний ажлын байранд иж бүрэн дүн шинжилгээ хийж, холбогдох материалыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж нийт 7 албан тушаалын тодорхойлолтыг шинээр батлуулж, 4 албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөн батлуулсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/655 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын орлогч-4 гэснийг 1 болгож, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.				
	103	4.1.4.3. Ажлын байрны дүн шинжилгээнд үндэслэн тухайн нэгжийн чиг үүрэг, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж ажлын давхардал, хийдлийг арилгана.	-	-	ТЗУХ	
		БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 13 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, холбогдох материалыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 3/872 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал болон цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/168 дугаар захирамжаар батлуулсан. Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл олгосны дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А/188 дугаар тушаалаар нийт 7 албан тушаалын тодорхойлолтыг шинээр баталж, 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн Б/229 дүгээр тушаалаар нийт 5 албан тушаалын тодорхойлолтыг жишгээр батлан ажилласан.				100
4.1.5. Засаг захиргааны анхан шатны нэгж хороог бэхжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	104	4.1.5.1. Төрийн бодлого шийдвэрийг Засаг захиргааны анхан шатны нэгж хороонд хүргэж иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж ажиллана.	100%	-	ТЗУХ	100

	БИЕЛЭЛТ: Тайлангийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас хороодын үйл ажиллагаа, хүнд сурталтай холбоотой асуудлаар 14 гомдол, хороодын Засаг дарга нарын үйл ажиллагааг дэмжиж талархсан талархал 2, албан хаагчийн ажилд дэвшин ажиллах хүсэлт 2 ирүүлснийг судлан, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажилласан. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд сурталчлах чиглэлээр нийт 11 төрлийн сургалтад 1210 иргэнийг хамруулсан байна.				
105	4.1.5.2. Хууль, тогтоомжийг дүүргийн иргэдэд сурталчлах, иргэдийн оролцоог дэмжих олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулна.	100%	-	ТЗУХ	100
	БИЕЛЭЛТ: Дүүргийн 1-20, 24 дүгээр хороодын хууль, эрх зүй, эрүүл мэнд, байгаль орчин, экологи, хувь хүний хөгжлийг дэмжих чиглэлээр 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 35 удаагийн сургалтад Засаг дарга 21, зохион байгуулагч 21, хэсгийн ахлагч 197, давхардсан тоогоор 1440 иргэнийг хамруулж иргэдэд хууль тогтоомжийг сурталчлан, иргэдийн оролцоог ханган ажилласан.				
106	4.1.5.3. Хороодын "Нэг цэгийн үйлчилгээ"-ний үйл ажиллагааг тогтмолжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй үзүүлэхэд анхаарч ажиллана.	100%	-	ТЗУХ	100
	БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар "Хороодын ажил сайжруулах, хяналт шалгалт хийх" ажлын хэсэг байгуулагдан дүүргийн 1-20, 24 дүгээр хороодын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, нэг цэгийн үйлчилгээний зохион байгуулалт, үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдаас төрийн үйлчилгээг үзүүлэхдээ түргэн шуурхай, тэгш, шударга байдалд анхаарч, хүндрэл чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх талаар зөвлөмжийг хүргүүлсэн. Хороодын нэг цэгийн үйлчилгээгээр нийт 48,156 иргэн үйлчлүүлсэн. Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ая тухтай үзүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын 1 давхар болон 2, 5, 6, 8, 11, 13, 19 дүгээр хороодын "Нэг цонхны үйлчилгээ"-ний засварын ажил бүрэн дуусаж, үйл ажиллагааг хэвийн явуулж байна.				
107	4.1.5.4. Хороодын Иргэдийн Нийтийн хурлыг зохион байгуулах, Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	100%	-	ТЗУХ	50
	БИЕЛЭЛТ: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан 23 хороодын иргэдийн Зөвлөл байгуулан ажиллаж байна.				
108	4.1.5.5. Хороодын албан ёсны цахим хаягийн үйл ажиллагааг идэвхжүүлж иргэдийг мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлнэ.	100%	-	ТЗУХ	90
	БИЕЛЭЛТ: Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээлэл, өдөр тутмын мэдээ зөвлөмжийг Чингэлтэй дүүрэг /Chingeltei District фэйсбүүк пэйж хуудас, "дүүргийн онцгой комисс"-ын пэйж, Chingeltei.gov.mn вэб сайтад үнэн бодит мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд "Чингэлтэй дүүрэг, Chingeltei District фэйсбүүк, пэйж цахим хуудсан дахь				

		мэдээллийг тухай бүр шинэчлэн 1144 удаагийн цагаан мэдээ оруулснаас 1.184.773 хандалт авсан байна. Үүнээс: ХМОНХТ- 895 мэдээг бэлтгэж, нийслэлийн мэдээ- 175 хуваалцаж, бусад- 49 мэдээ иргэдэд хүрчээ. Нийт мэдээлэлд 4847 эерэг сэтгэгдэл, 67 сөрөг сэтгэгдэл, 36814 удаа таалагдаж, мэдээг 15469 хуваалцсан байна.			
4.1.6. Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангаж, цахим засаглалыг хөгжүүлнэ.	109	4.1.6.1. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дүүргийн цахим хуудсанд тухай бүр байршуулан тогтмол шинэчилнэ.	60%	-	ТЗУХ
		БИЕЛЭЛТ: Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэд сул орон тооны зарыг 3 удаа, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээ, байгууллагын 2022 онд зохион байгуулагдах сургалтын нэгдсэн төлөвлөгөө, тангараг өргөсөн албан хаагчдын нэрсийн жагсаалт, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгосон албан хаагчдын нэрсийн жагсаалт, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам, Засаг даргын Тамгын газар, хороодын албан хаагчдын ажлын үнэлсэн байдал зэрэг нийт 12 мэдээг байршуулж ажилласан.			100
	110	4.1.6.2. Сул орон тооны зарыг дүүргийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд нээлттэй хүргэж тухай бүр шинэчилнэ.	60%.	-	ТЗУХ
		БИЕЛЭЛТ: Дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэд сул орон тооны зарыг 3 удаа байршуулж , иргэдэд нээлттэй хүргэж ажиллалаа.			100
	111	4.1.6.3. Тоон гарын үсэг ашиглаж цахим албан хэрэг хөтлөлтийг хэрэглээнд нэвтрүүлж хэвшүүлнэ.	60%	-	ТЗУХ
		БИЕЛЭЛТ: Дүүргийн хэмжээнд нэгдсэн системийн ашиглалт тоон гарын үсэг нэвтрүүлэх, ашиглах ажлын хүрээнд: - Засаг даргын Тамгын газар, 19 хороодын тоон гарын үсэг ашиглах шинээр томилогдсон 12 албан хаагчийн холбогдох материалыг бүрдүүлэн “Үндэсний дата төв”-д хүргүүлж, мэдээллийг esign.gov.mn нэгдсэн мэдээллийн санд бүртгэн баталгаажуулж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Дүүргийн хэмжээнд нэгдсэн систем ашигладаг 109 байгууллагын эрх бүхий 147 албан тушаалтан тоон гарын үсэг авч, Edoc нэгдсэн системд тоон гарын үсгээр баталгаажсан баримт бичиг солилцож хэвшээд байна. Нэгдсэн систем дэх баримт боловсруулалт, тоон гарын үсгийн хэрэглээ, цахим албан хэрэг хөтлөлтийн талаар 93 байгууллагын 175 албан хаагчдад 23 удаагийн сургалт заавар зөвлөгөөг танхимаар болон онлайнаар өгч ажиллав.			100
	112	4.1.6.4. Интернэт болон өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулан алсын зайн болон нээлттэй онлайн	60%	-	ТЗУХ

		сургалтыг албан хаагчдын дунд тогтмол зохион байгуулна.				
		БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 4 давхрын хурлын заал, ёслол хүндэтгэлийн танхим, 5 давхрын мэдээллийн төвд нийт 172 хурлыг зохион байгуулан ажилласан. Дүүргийн 344 864 1938, 824 331 1473, 554 340 2708 тоот дугаартай zoom цахим хаягаар 67 удаагийн сургалтыг зохион байгуулсан.				
4.1.7. Төрийн албанд хүний эрх, жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог нэвтрүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах бодлогыг эхлүүлнэ.	113	4.1.7.1. Жендерийн салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, ажилтан албан хаагчдыг жендерийн боловсрол олгох сургалтад хамруулна.	26%	-	НХХ	100
		БИЕЛЭЛТ: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан “Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ” сэдэвт онлайн цахим сургалтад 1668 албан хаагч хамрагдаж, сертификат олгож, тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. Жендерийн үндэсний хорооноос Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээний “Харилцан хүндэтгэе” аяныг 2022 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд 1 сарын хугацаатай зохион байгуулах удирдамж, чиглэлийн хүрээнд “Харилцан хүндэтгэе”, “Хайраа хайрлая, хандлагаа өөрчилъе, хамтдаа үлгэрлэе” урианы дор зохион байгуулж жендерийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтаас ангид байх нийгмийн сэтгэлгээг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулж ажиллахыг хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадад үүрэг чиглэл болгон албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүжилттэй жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх “Олон нийтэд суурилсан зан үйлийг өөрчлөх харилцааны цогц загвар” төслийн хүрээнд сургууль, хамт олон, медиад суурилсан аргачлалын туршилтын үр дүнд боловсруулсан “Нийгэм зан үйлийг өөрчлөх цогц загвар” арга зүйг танилцуулах цахим сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын 1 албан хаагчийг хамруулсан. Жил бүр зохион уламжлал болгон зохион байгуулдаг “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-г 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.				
	114	4.1.7.2. Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журамд тусгуулна.	60%	-	ТЗУХ	100
		БИЕЛЭЛТ: Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/96 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Хөдөлмөрийн дотоод журмын төсөлд тусгуулах саналыг албан хаагчдаас авч, нэгтгэн боловсруулж, хэлэлцүүлэн батлуулсан ба 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр бэлтгэл ажлыг бүрэн ханган ажилласан. Журмын 5.1.15-д ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн				

		үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно хэмээн тусгасан.				
	115	4.1.7.3. Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх зарчмыг баримтална.	26%	-	ТЗУХ	100
		БИЕЛЭЛТ: Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын хүйсийн харьцаа эмэгтэй 9, эрэгтэй 9 буюу 50/50 хувьтай байна.				
4.1.8. Улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг бүх шатанд жигд хүртээмжтэй хүргэх ажлыг дэмжинэ.	116	4.1.8.1. Ухаалаг засаглалын хүрээнд иргэдэд цахим бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	50%	-	УБХ, НУБХ, ЗДТГ, ХОРООД	100
		БИЕЛЭЛТ: Улсын бүртгэлийн нийт 71 төрлийн цахим үйлчилгээг үйлчилгээг www.e-mongolia.mn сайтаар үзүүлж байна. Үүнд: Иргэний бүртгэлийн 41, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 18, хуулийн этгээдийн бүртгэлийн 12 төрлийн үйлчилгээ байна. Ухаалаг засаглалын хүрээнд тоон гарын үсгийг 76 байгууллагын 19.181 иргэнд олгож, иргэний улсын бүртгэлийн 26.249, эд хөрөнгө өмчлөх эрхийн 250 лавлагааг олгосон байна.				
	117	4.1.8.2. Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах Чингэлтэй дүүрэгт үйлчилгээний нэгдсэн төв байгуулна.	50%	-	НЗДТГ, ДЗДТГ, УБХ	100
		БИЕЛЭЛТ: Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах дүүргийн Биеийн тамир, спорт хорооны байранд 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн Улсын бүртгэлийн үйлчилгээний нэгдсэн төв нээж иргэний улсын 3 бүртгэгч, эд хөрөнгийн эрхийн 1 улсын бүртгэгч ажиллаж иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. Дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах дүүргийн Газар зохион байгуулалтын албаны байранд Улсын бүртгэлийн үйлчилгээний нэгдсэн төвийг нээхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.				
	118	4.1.8.3. Засаг, захиргааны анхан шатны нэгж хороодоос үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ.	-	-	УБХ, ЗДТГ, ХОРООД	100
		БИЕЛЭЛТ: Засаг захиргааны анхан шатны нэгж хороодоос үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр шинээр 5 төрлийн үйлчилгээг дүүргийн 1-9, 19, 20, 24 дүгээр хороонд улсын бүртгэлд шилжүүлсэн. Үүнд: Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл, гэрлэлтийн бүртгэл, нас барсны бүртгэл, гэрлэлт дуусгавар болсон (шүүхийн шийдвэр), иргэний үнэмлэхийн баталгаажуулалтыг хийж байна.				
	119	4.1.8.4. Бичиг баримтгүй иргэдийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран бичиг баримтжуулна.	70	3	УБХ, МУЗН, ХХҮХ, ХГБЗХХ	100

		БИЕЛЭЛТ: Иргэний улсын бүртгэлийн дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран 157 бичиг баримтгүй иргэн, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 370 бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулж нийтдээ 527 иргэнийг бичиг баримтжуулсан.				
	120	4.1.8.5. Захиалгат бууу ёслолтой бүртгэлийг тогтмол тодорхой хугацаанд хийнэ.	70	1.4	УБХ, ЗДТГ	100
		БИЕЛЭЛТ: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 27 иргэнд ёслолтой бүртгэлийг зохион байгуулсан. Үүнд: Дүүргийн хороодтой хамтран гэрлэлтээ батлуулсан 6 хосыг, гэрлэх ёслолын ордонтой хамтран 10 хосыг, шинээр төрсөн 9 хүүхдэд ёслолтой бүртгэлийг зохион байгуулсан. Мөн дүүргийн 30 жилийн ойг тохиолдуулан иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ авсан 30 дахь иргэний бүртгэлийн 41 иргэн, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн 30000, 30030 дахь бүртгэл болон газар өмчлөх эрхийн гэрчилгээ авсан 2 нийт 70 иргэнд ёслолтой бүртгэлүүдийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.				
	121	4.1.8.6. Андгай өргөх ёслолыг 2-оос доошгүй удаа зохион байгуулна.	100	1.5	УБХ, ЗДТГ, ИТХ	100
		БИЕЛЭЛТ: Шинээр иргэний цахим үнэмлэх авч байгаа 16 насанд хүрсэн 108 хүүхдэд 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр, 200 хүүхдэд 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монголын Залуучуудын Холбоотой хамтран иргэний цахим үнэмлэхийг гардуулан өгч ажиллалаа.				
4.2. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ						
4.2.1. “Гамшиг эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	122	4.2.1.1. “Гамшиг эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх-2024” арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.	50%	30.0	ОБХ, ХЭЗХ	90
		БИЕЛЭЛТ: Дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны 12 дугаар сарын байдлаар 360 удаагийн гал түймрийн дуудлагаар ажиллаж 597 иргэний амь нас, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 51 тэрбум 20.0 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан. Хөтөлбөрийн хүрээнд Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг, сургалт дадлагыг нийт 32 удаа 33.102 өрх, 29.714 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Үүнд: Ахуйн гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх “Гал ганц хоромд-Мартаж болохгүй” нөлөөллийн аян, “Гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх” өдөрлөг, Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах нэгдсэн арга хэмжээ”, “Аюулгүй галлагаа” сарын аян, “Алдвал Галдана-2” нөлөөллийн аян, “Анхаарахад л болно” аян, Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын нэрэмжит “Өсвөрийн аврагч” зэрэг өдөрлөг нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан 77 удаа сэрэмжлүүлэх шторк, цахим сайтад 288 удаа мэдээлэл оруулж, фэйсбүүк пэйжид 411 удаа, сонин хэвлэлд 78 удаа, орон нутгийн телевизэд 26 удаа ярилцлага өгч, 23,728 ширхэг санамж сэрэмжлүүлэг тараах материалыг 29,714 хүнд 33.102 айл өрх иргэнд сэрэмжлүүлэг сурталчилгааг хүргэн ажиллалаа. Дүүргийн хэмжээнд 4 аж ахуйн нэгж, 2 мэргэжлийн анги, 10 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гамшгийн				

		<p>эрсдэлийн ерөнхий үнэлгээг зохион байгуулан Эрүүл мэндийн төвийн 150 ажилтан алба хаагч, аж ахуйн нэгж, байгууллагын 92 ажилтан алба хаагчдад 20 цагийн хичээлийг зохион байгуулж эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын 10 удаагийн захирамжаар 108,062,500 төгрөг батлагдсанаас дүүргийн шуурхай штабын зардалд 8,002,200 төгрөг, дүүргийн гамшгаас хамгаалах албадын урамшуулалд 35,600,0000 мянган төгрөг, Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх зардалд 64,460,300 төгрөгийг зарцуулан ажилласан байна. Үүнд: Чингэлтэй дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны 16 дугаар тогтоолоор 31,800,000 мянган төгрөгийн өртөг бүхий дроныг шийдвэрлүүлж Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энгэрийн камер 4 ширхэг, проектор, проекторын дэлгэц 1 ширхэг нийт 4,288,000 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй өгсөн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 120,0 сая төгрөгийн өртөгтэй шуурхай албаны зориулалттай “Nissan Urvan” загварын 13 хүний суудалтай автомашиныг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр тус хэлтэст хүлээн авсан.</p>				
4.2.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.	123	4.2.2.1. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, радио, телевизийн нэвтрүүлэг бэлтгэнэ.	12	6.0	ХЭЗХ, ЦГ, ЗЦХ	100
		БИЕЛЭЛТ: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийт 400 удаагийн сургалт, мэдээлэл, уулзалт хэлэлцүүлэг, өдөрлөг, уралдаан тэмцээн зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын 1546 ажилтан, албан хаагч, 41 удаагийн сургалт мэдээлэл, 12 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт 2535 ажилтан, алба хаагч, 9 удаагийн өдөрлөг, уралдаан тэмцээнд 589 ажилтан, алба хаагч, сурагчид хамрагдсан. Зохион байгуулсан 24 удаагийн аян, арга хэмжээг МН-25, МНС телевиз, С-1, ТВ-4, Сүлд, Амрыг эрье нэвтрүүлэг, ФМ 88.3, Авто радио 96.3, ФМ 104, updown.mn, hardnews, mongol medee сайтуудад аян арга хэмжээг сурталчлан ажилласан.				
	124	4.2.2.2. Иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар авах мэдээ, мэдээллийн талаар сургалт, сурталчилгаа явуулсан тоо, авсан мэдээлэл, батлагдсан байдал өснө.	80%	5.0	ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	100
	БИЕЛЭЛТ: Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнд “Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авах” журмыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой санхүүжилтийг тусгах саналыг хүргүүлсэн бөгөөд иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар иргэдээс төлбөртэй мэдээ, мэдээлэл авах талаарх жишиг, зурагт хуудас бүхий зар сурталчилгааг байгууллагын олон нийтийн цахим хуудсанд байршуулан иргэдэд мэдээлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж, Соёл урлагийн их сургууль, Хөдөлмөрийн дээд сургууль, Улаанбаатар эрдэм дээд сургуулийн 200 оюутнуудад төлбөртэй мэдээ мэдээлэл авах талаар 3 удаа сургалт зохион байгуулж, 150 зурагт хуудас тараан ажилласан.					
	125	4.2.2.3. “Хөршийн хяналт”-ын хөтөлбөрийг дахин хэрэгжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан	80%	5.0	ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	100

	оролцуулна.				
	<p>БИЕЛЭЛТ: Ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, оршин суугчдаас ирүүлэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг нэмэгдүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх 14 заалттай зөвлөмжийг хүргүүлж, шинэчилсэн судалгаа гаргасан. Судалгаагаар 124 бүлгийн 3488 гишүүн бүртгэгдсэн бөгөөд гэмт хэрэг, зөрчил хамгийн ихээр үйлдэгддэг 7 эмзэг цэгт эргүүл хяналт шалгалт хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хамтран хэрэгжүүлэх тухай 2 төрлийн зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн хүрээнд хөршийн хяналтын бүлэгтэй хамтран нэгдсэн 2, хэсэгчилсэн 4, нийт 6 арга хэмжээнд хамтран ажиллаж, Залилах, Хулгайлах, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Зөвийг зөвлөө” арга хэмжээний 3000, “Тат түлх” зөвлөмж бүхий 1000 ширхэг зурагт хуудсыг тараах ажилд оролцуулсан.</p>				
126	4.2.2.4. “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.	80%	5.0	ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	100
	<p>БИЕЛЭЛТ: Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, тэдний эрхийг хамгаалах, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн хүмүүжлийн эерэг аргыг сурталчлах, “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” Олон Улсын өдрийг тохиолдуулан 2022 оны 04 дүгээр сарын 30-ны “Шийтгэл бол шийдэл биш” арга хэмжээг зохион байгуулан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор 7,893,600 төгрөгийн төсөв хөрөнгийг шийдвэрлүүлж, 1 шторк, 10 постер, 1 контентыг бэлтгэн цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ мэдээлэл хүргүүлсэн.</p> <p>Мөн “Хүүхдийн дуу хоолой-2022” чуулганыг Ерөнхий боловсролын 16 сургуулийн 25,652 сурагчдын дунд зохион байгуулах, хэлэлцүүлсэн асуудлын нэгтгэлийг дүүргийн удирдлагад хүргүүлсэн.</p> <p>Хариуцсан дүүргийн Нийгмийн ажилтан, Ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан нартай хамтран “Кэйс хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулж, аяны хаалтын үйл ажиллагааг Тусгаар тогтнолын талбай дээр урлаг, соёлын тоглолтыг зохион байгуулан 200 хүүхдэд гарын бэлэг гардуулж ажилласан. Арга хэмжээг угтан “Өртөөчилсэн” сургалтыг 3 өдөр зохион байгуулан Ерөнхий боловсролын 19 сургуулийн 6-8 дугаар ангийн 67 бүлгийн 1918 сурагчдад “Үе тэнгийн дээрлэхэлт”, “Гэмт хэрэг, зөрчлөөс” урьдчилан сэргийлэх чиглэлээр ГБХЗХХ-ийн 3 мэргэжилтэн, Цагдаагийн газрын 3 алба хаагч, Замын цагдаагийн хэлтсийн 3 алба хаагч, дүүргийн 14 сургуулийн Нийгмийн ажилтнуудтай хамтран 14 удаагийн сургалт зохион байгуулан 1522 сурагч хамрагдлаа.</p>				
127	4.2.2.5. Хулгайн болон залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Төрийн болон ТББ, Банк, санхүүгийн байгууллагатай хамтарч ажиллана.	80%	5.0	ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	100

	<p>БИЕЛЭЛТ: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог хангах зорилгоор “Тэвч тэгвэл”, “Шинэ жил 2022”, “Сар шинэ 2022”, “Зөвийг зөвлөө”, “Хариуцлагаар үлгэрлэе”, “Гэрлэн дохио, камер”, “Гэрлээр анхааруулъя” зэрэг нэгдсэн арга хэмжээ 6, “Манаач-2022”, “Зах”, “Эрэн сурвалжлалт”, “Авто угаалга”, “Судалгаа хяналт”, “Траншейн”, “Нийтийн байр”, “Халаас”, “Тэнэмэл”, “Согтуу”, “Цохилт”, “Хуурамч мөнгө”, “Хүүхэд хамгаалал”, “Илрүүлэлт 2022”, “Хүүхдийн эрх”, “Сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн хүүхдүүдэд хяналт тавих, эргэн шалгах, урьдчилан сэргийлэх”, “Аюулгүй орчин”, “Цахим тоглоом”, “Шийтгэл бол шийдэл биш” аян, “Асрамжийн газар”, “Дотуур байр”, “Анзаар”, “Сэрэмжлүүлье, Анхааруулъя”, “Шингэрүүлсэн шатдаг хий”, “Хүүхэд таныг хамгаалъя” “Хорт зуршилгүй залуу”, “Байгалаа хамгаалъя”, “Байгалаа бүтээе” нийт 31 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцон ажилласан байна. Уг арга хэмжээг давхардсан тоогоор төрийн 56 байгууллага, төрийн бус болон аж ахуйн нэгжийн 24 байгууллагын 75230 иргэд олон нийтийг хамруулсан байна.</p>				
128	<p>4.2.2.6. Байнга архидан согтуурч, бусдын амгалан тайван байдал алдагдуулдаг архины хамаарал бүхий иргэдийг нийгэмшүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна.</p>	80%	5.0	ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	90
	<p>БИЕЛЭЛТ: “Тэнэмэл 1,2” нэгдсэн арга хэмжээнд нэгдэж, 2 удаа 16 иргэнийг СХД-ийн “Амьдрах ухаан” төвд, Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороонд байрлах “Тэрэм Уул” төрийн бус байгууллагад 12 иргэнийг хүлээлгэн өгсөн.</p> <p>Архины албадан эмчилгээнд нийт 42 иргэнийг хамруулан сайн дураар эмчилгээ хийлгэх 6 иргэнийг төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучилсан. Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс болон “Зөв дадал” төрийн бус байгууллагатай хамтран архины хамааралтай 25 хүнд “Архины хор хөнөөл”, “Хувь хүн архинаас гарах” сэдвээр сургалт, Нийслэлийн эрүүлжүүлэх саатуулах байранд хүргэгдэн ирсэн 75 иргэнд “Архины хор уршиг” сэдэвт сэтгэл зүйн сургалт нийт 100 иргэнд, орчиндоо түгшүүр түрүүлдэг 30 иргэнд дүүргийн 1 дүгээр хороо иргэний танхимд “Архины хор уршиг”, “Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх” сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан.</p> <p>Хууль зүй дотоод хэргийн сайдын санаачилгаар Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэмжлэгтэйгээр Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Аддиктологийн төв, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран хэрэгжүүлж байгаа “Итгэл” төсөлд сайн дурын үндсэнд хамрагдах 45 хүртэл насны 26 иргэнийг судалж, эмчийн үзлэгээр тэнцсэн 13 иргэнийг 28 хоногийн “Хорт зуршлаас татгалзах тусгай хөтөлбөрт эмчилгээ” төсөлд хамруулж мэргэжил олгох сургалтад зориулж 3.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.</p>				
129	<p>4.2.2.7. Хүүхэд өртсөн зам тээврийн осол, хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нартай хамтран ажиллах гэрээ байгуулж, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох сургалт зохион байгуулна.</p>	100%	5.0	ХЭЗХ, ЦГ, ЗЦХ	100

	<p>БИЕЛЭЛТ: 2021-2022 оны хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан 2021 онд зам тээврийн осолд хүүхэд өртөж, гэмтсэн, ослын улмаас хүүхдийн амь нас хохирсон тоон үзүүлэлтийг алба хаагчдад танилцуулж, бага насны хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх эцэг эх асран хамгаалагчдын зүгээс үр хүүхдэдээ тавих хараа хяналтыг сайжруулах чиглэлээр Ерөнхий боловсролын 24 сургууль, 33 цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт “Хүүхэд өртсөн зам тээврийн осол, хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх” зорилгоор гэрээ байгуулан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулсан.</p> <p>Ерөнхий боловсролын 50, 24, 23, 5, 149 дүгээр сургуулийн өсвөрийн сэргийлэгч 35 сурагчдад болон 7 дугаар ангийн сурагчдыг унадаг дугуй, дугуйт хавтан болон түүнтэй ижил төстэй, биеийн тамир, спорт, тоглоомын зориулалттай хэрэгслээр хөдөлгөөнд оролцох зэргээс гарч буй зам тээврийн ослыг бууруулах зорилгоор “Замын хөдөлгөөнд оролцох зөв дадлыг хэвшүүлэх, аливаа эрсдэлээс хүүхэд өөрийгөө хамгаалах”, сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд зохион байгуулагддаг “Замын хөдөлгөөний Цагаан толгой 2022”, Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээнийг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр дүүргийн 19 хороо “Хайрхан хөгжлийн” спорт зааланд зохион байгуулсан.</p> <p>ЕБС-ийн 29 сургууль, 54 цэцэрлэгийн ойр орчим Замын цагдаагийн хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, Мэдээлэл технологийн төвийн алба хаагчидтай хамтарч 9 чиглэлд 32 алба хаагч хичээл эхлэх, болон тарах цагуудад /07:30-09:30, 12:00-14:00, 16:00-18:00/ сургуулийн ойр орчимд сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирох, болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Улаан загалмайн нийгэмлэг, Хороодын нийтийн эргүүл, Хүүхэд хамгаалагч нартай хамтарч эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласан.</p> <p>Хичээлийн шинэ жилийн арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын 19 сургуулийн 1-5 дугаар ангийн 185 бүлгийн 19833 сурагчдад “Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд зөв боловсон оролцох” сэдэвт сургалт, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” аян, “Хамгаалах малгай” “Явган зорчигч” “Унадаг дугуй” хэсэгчилсэн арга хэмжээ, “Шар дарцаг” аян арга хэмжээнүүдийн хүрээнд 54 цэцэрлэг, 19 сургуулийн 1-5 дугаар ангийн давхардсан 26535 хүүхэд багачуудад замын хөдөлгөөнд гарцаар гарч оролцох тухай сэдэвт сургалт мэдээллийг тасралтгүй зохион байгуулан ажилласан.</p>				
130	<p>4.2.2.8. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудыг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдаж буй ажил арга хэмжээнд татан оролцуулах хамтран ажиллана.</p>	100%	5.0	ХЭЗХ, ЦГ, ЗЦХ	90
		<p>БИЕЛЭЛТ: Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулсан “Гэрлэн дохио, камер”, “Гэрлээр анхааруулъя”, “Зөвийг зөвлөө”, Зөвийг хэвшүүлье”, “Аажуу явбал аяндаа хүрнэ” нэгдсэн арга хэмжээнд нэгдэж, Чингэлтэй дүүргийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 1.500,000 мянган төгрөгийг шийдвэрлүүлэн, “Гэрлээр анхааруулъя” тараах материал 1500 ширхэг, зурагт хуудас стикер 10 ширхгийг хэвлүүлж автобусны буудал, явган хүний гарц гэх мэт газруудад байрлуулж зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлж ажилласан.</p> <p>Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 40 алба хаагчид 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдөр, “Богд банк”-ын 10 жолоочид 2022 оны 05 дугаар сарын 31-ны өдөр, тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагаа</p>			

		<p>явуулдаг ТС-15, ТС-2 ачилтын компанийн нийт 15 жолоочид 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдөр “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухайн хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын талаар “Замын хөдөлгөөний тухай хууль”, “Замын хөдөлгөөний дүрэм” сэдвээр 1-2 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын А/1291 дүгээр захирамжийн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 10-наас 11 дүгээр сарын 17-ны өдрүүдэд хүүхдийн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилготой “Шар дарцаг” аяныг Ерөнхий боловсролын 29 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 54 цэцэрлэгийн хүүхдүүдэд сургалт зохион байгуулан. Сургалтаар “Шар дарцаг” хэрхэн хэрэглэх заавар зөвлөмж, замын хөдөлгөөнд хэрхэн ашиглах талаар мэдээлэл өгсөн.</p> <p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран Замын хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй байдлыг хангах, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх хохирогч болох эрсдэлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг сурталчлах, зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор “Анхааралтай байвал-Аюул үгүй” уриан дор “Шар дарцаг” видео шторк хийхэд шаардлагатай төсвийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/284 дугаартай тушаалаар 4.0 сая төгрөг шийдүүлэн 3 минутын видео шторкийг иргэд олон нийтэд түгээн ажилласан.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 43 дугаар зарлигийн хүрээнд Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж байгаа “Намайг алгас” аяны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагад 21-27 дугаартай албан мэдэгдэл хүргүүлэн хамтран ажиллаж байна.</p>				
4.2.3. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн дүүргийн нутаг дэвсгэрт хурд хэтрүүлснээс болж гарах зам тээврийн хэрэг, ослыг бууруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	131	4.2.3.1. Зам тээврийн осол аваар их гардаг газар хурд хэмжигч, зөрчил илрүүлэх камер байршуулж зам тээврийн хэрэг осол аваар бууруулна.	1000	50.0	ЗЦХ, ХЭЗХ	90
		БИЕЛЭЛТ: Тээврийн хэрэгслийн хурдыг хэтрүүлснээс зам тээврийн осол аваар ихээр гардаг дүүргийн 19 дүгээр хороо Зуслангийн замд 7 хоног бүр явуулын хурд хэмжүүрийг байрлуулж, 24 цагт 3 ээлжээр тасралтгүй хяналт тавьж, тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн хурдыг 10-50 хувиар хэтрүүлсэн 66321 иргэнийг 3.316.050.000 мянган төгрөгөөр бэлэн бусаар торгож ажилласан.				
	132	4.2.3.2. Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран зуслангийн замд тээврийн хэрэгслийн хурд хэмжих ажлыг зохион байгуулна.	100%	2,5	ЗЦХ, ХЭЗХ	100
	БИЕЛЭЛТ: Тээврийн цагдаагийн алба, Замын цагдаагийн газрын Замын хөдөлгөөнийг зохицуулах хэлтэстэй хамтран дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байнгын хурд хэмжүүрийг ажиллуулан Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 32 дугаар зүйлд зааснаар тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдсөн хурдыг 10-50 хувиар хэтрүүлсэн 209 иргэнийг 10.450.000 мянган төгрөгөөр торгож жолооч тус бүрийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараар хасаж шийдвэрлэсэн.					
	133	4.2.3.3. Баянбүрд дэх хяналтын цэгийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор камержуулах байнгын постыг өргөтгөх, шинэчлэх ажлыг зохион байгуулна.	70%	2.5	ЗЦХ, ХЭЗХ	100

		<p>БИЕЛЭЛТ: Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны төсөв батлах тухай 13 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад 30.0 сая төгрөгөөр Баянбүрдийн хяналтын постыг өргөтгөх, тээврийн хэрэгслийн хурд мэдээлэх самбар байрлуулах шийдвэр гарсан. Тус хяналтын цэгийн байрыг шинэчлэх ажлыг Чингэлтэй дүүргийн худалдан авах ажиллагааны алба хариуцан зохион байгуулж, ЧДХААА/202110096 дугаартай тендер зарлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Одоогоор тендерт оролцох иргэн аж ахуй нэгж саналаа ирүүлээгүй болно.</p> <p>Баянбүрдийн хяналтын постыг өргөтгөх ажил удааширсантай холбогдуулан замын цагдаагийн хэлтсээс дотоод нөөц бололцоондоо тулгуурлан урсгал засвар хийж, постыг байнгын ажиллагаанд оруулан, техник хэрэгслийг хэвийн үйл ажиллагаанд оруулсан. 3 болон 4 дүгээр улиралд төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлаар Баянбүрд дэх хяналтын цэгийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ажил арга хэмжээ зохион байгуулаагүй.</p>				
	134	<p>4.2.3.4. Дүүргийн нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын сургуулиудын ойролцоох явган зорчигчийн гарцын хажууд байрлах хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн “Анхаар хүүхэд” тэмдгийн загварыг өөрчлөх шөнийн цагт гэрэл асдаг, гэрэл ойлгогчтой болгох ажлыг зохион байгуулна.</p>	70%	2.5	ЗЦХ, ХЭЗХ	70
		<p>БИЕЛЭЛТ: Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Ерөнхий боловсролын 39, 49, 117 дугаар сургууль орчим тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй байршлуудын явган хүний зорчигчийн гарцын хажууд байрлах “Анхаар хүүхэд” тэмдгийг гэрэлтүүлэгтэй болгох, гэрэл ойлгогчтой болгох саналыг Чингэлтэй дүүргийн гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд хүргүүлсэн боловч Хэмнэлтийн хуулийн дагуу төсөв мөнгө шийдэгдээгүй байна.</p>				
4.2.4. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, орон байрны хулгай, мансууруулах бодистой холбоотой нуугдмал гэмт явдал илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	135	<p>4.2.4.1. Гэр бүлийн хүчирхийлэл, мансуурал бодистой тэмцэх тухай сургалт зохион байгуулах, нуугдмал гэмт хэргийг илрүүлэх талаар ерөнхий боловсролын сургуультай хамтран ажиллана.</p>	1700	5,0	ЦГ, ХЭЗХ	100
		<p>БИЕЛЭЛТ: Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх зорилгоор хариуцсан дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 24 Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн 950, сурагчдад “Ухаалаг утасны хор уршиг”, “Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх”, “Найз нөхдийн хандлага”, “Ахуйн хүрээний осол” сэдвээр, 6-12 дугаар ангийн 8523 сурагчдад “Хорт зуршил”, “Үе тэнгийн дээрэлхэлт”, “Халаасны хулгайн гэмт хэрэг”, “Тодорхой төрлийн гэмт хэрэг”, “Цахим орчны зөв хэрэглээ”, “Анзаар” аяны хүрээнд нийт 517 иргэнд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар урьдчилан сэргийлэх сургалт, 10-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 11 Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангиудад “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, “Тодорхой төрлийн гэмт хэрэг”, “Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, 5 дугаар сургуулийн 6-9 дүгээр ангийн 24 бүлгийн 120 сурагчдад “Үе тэнгийн дээрэлхэлт”, “Тодорхой төрлийн гэмт хэрэг”, “Халаасны хулгай”</p>				

		гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, 112 дугаар сургуулийн 6-12 дугаар ангийн 46 сурагчдад "Үе тэнгийн дээрэлхэлт" 24 дүгээр сургуулийн 8 дугаар ангийн 1 бүлийн 42 сурагч нийт 206 сурагчдад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгч ажилласан. Мөн "Цэцэрлэг" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 70, 43, "Бяцхан алаг үрс" 3 цэцэрлэгийн 16 бүлгийн 313 хүүхэд, багш ажилчдад "Гэрэлт дуу"-г сонсож хүүхдүүдтэй ярилцаж мэдээлэл өгсөн.				
136	4.2.4.2 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн иргэдэд "Хувийн хэрэг" нээж, хяналт тавина.	80%	10.0	ЦГ, ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	90	
	<p>БИЕЛЭЛТ: Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг нийт 131, үйлдэж болзошгүй 77 иргэнд хяналтын хувийн хэрэг нээж, хэсгийн байцаагч, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн асуудал хариуцсан байцаагч нар хяналт тавин ажиллаж байна. Дээрх этгээдүүдтэй сард 1-ээс доошгүй удаа уулзаж дахин энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх баталгаа авч ажиллаж байна. Тасгийн дарга, ахлахуудад гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг этгээдүүдийн мэдээллийг өгч давхар хяналт тавьж байна. Иргэдээс хяналтад байх хугацаанд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон иргэн байхгүй байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагчид хороодын хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор давтамжтай дуудлага мэдээлэл ирүүлдэг 20 айл өрхөөр орж уулзалт ярилцлага хийж, зөвлөгөө өгч тусламжийн хуудас гардуулан ажилласан.</p>					
137	4.2.4.3. Хоёр буюу түүнээс дээш удаагийн давтамжтай гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй иргэдийг хамтарсан багаар хэлэлцүүлж, дүгнэлт гарган, хяналтад авна.	80%	20.0	ЦГ, ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	90	
	<p>БИЕЛЭЛТ: Удаа дараа нэг хаяг дугаараас ирж буй давтамжтай хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 549 дуудлага мэдээллийн судалгааг гаргаж хороодын хамтарсан багт албан бичгээр хүргүүлж холбон зуучилж ажилласан.</p> <p>Дахин давтан хүчирхийлэл үйлдэж болзошгүй 79 иргэнд тавих хуваарийг баталж алба хаагчдад танилцуулан ажилласан. Аюулын зэргийн үнэлгээ "Өндөр" түвшинд байгаа мэдээллийн дагуу 14 хоногт 1 удаа Гэр бүлийн хүчирхийллийн ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтсийн мэргэжилтэн нарын хамтаар айл өрхөөр орж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан тусламжийн хуудсыг хохирогчдод өгч, зайлшгүй шаардлагатай хохирогчийг нэн даруй хамгаалалтад авч, түр хамгаалах байранд хүлээлгэн өгч, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилж, үр дүнг тооцож ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 55 иргэнийг дүүргийн Эрүүгийн хэргийн Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлж 7-30 хоногийн баривчилгаа, 105,000-450,000 мянган төгрөгийн торгох шийтгэл, 10-50 цагийн албадан сургалтад хамруулах шийтгэл оногдуулж, хүүхдийн эрх ашиг зөрчсөн 196 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар тус бүр 300 нэгжтэй тэнцэх төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулсан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хүүхдийн эрх ашиг зөрчсөн 73 иргэнийг "Судалгаа хяналтын сан"-гийн Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэгч гэх өнгөөр бүртгэж баяжилт хийж, аюулын зэргийн үнэлгээ өндөр гарсан 60 айл өрхийн мэдээллийг хороодын хамтарсан багт албан бичгээр хүргүүлэн холбон зуучилж ажилласан.</p>					
138	4.2.4.4 Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, нуугдмал гэмт хэргийг илрүүлэлтийг	80%	20.0	ЦГ, ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	90	

	нэмэгдүүлнэ.				
	<p>БИЕЛЭЛТ: Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, нуугдмал гэмт хэргийг илрүүлэх зорилгоор зохион байгуулсан “Хүүхэд хамгаалал” ерөнхий арга хэмжээ, “Илрүүлэлт” “Цэцэрлэг”, “Өдөр өнжүүлэх газар”, “Эзэнгүй объект, Мөрөөдлийн шүхэр” аян зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж эрсдэлт нөхцөлд байгаа болон, хараа хяналтгүй, хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдийг илрүүлэх зорилгоор 18 ТҮЦ, ус түгээх газрын 6 ажилтан, 32 хүнсний дэлгүүр, дэн буудал 21 зочид буудал 6, сауны газрын үйл ажиллагааг шалгаж 12 хөрш айлын эзэдтэй уулзаж эрсдэлт нөхцөлд байгаа мөн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаарх мэдээллийг мэдээлж байх тухай тусламжийн хуудас гардуулан өгч ажилласан.</p> <p>Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хариуцсан дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүдийн эмнэлэг, үр хөндөлтийн мэс ажилбар явуулдаг төр, хувийн хэвшлийн эмнэлгийн судалгааг гаргаж өгөх тухай 2022 оны 26л-1/2323 дугаартай албан бичиг хүргүүлж үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн 13 эмнэлгийн судалгааг гарган авч эмнэлгүүдэд насанд хүрээгүй иргэдэд үр хөндөлт хийхгүй байх тухай №08 дугаартай зөвлөмжийг хүргүүлж үр дүнг тооцсон. Эмийн сан, эм ханган нийлүүлэх үйл ажиллагаа явуулдаг 54 газарт үр зулбуулах эм бэлдмэл худалдан борлуулахгүй байх тухай №09 дугаартай зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>Оршин суугаа газраасаа удаа дараа алга болсон 38 хүүхдийн мэдээллийг 1-19 дүгээр хороодын хамтарсан багт албан бичгээр холбон зуучилсан. Тайлант хугацаанд Бэлгийн хүчирхийлэлд өртсөн 3 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээг тасралтгүй үзүүлэн хороодын Хамтарсан баг, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд албан бичгээр холбон зуучилж холбогдох байгууллагуудыг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.</p>				
139	4.2.4.5. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, илрүүлсэн зөрчлийн тоог өсгөнө.	80%	20.0	ЦГ, ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ	
	<p>БИЕЛЭЛТ: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан болон холбогдож болзошгүй 50 сэжигтэй этгээд, мөн ахуйн газ, будаг шингэлэгч үнэрлэж зөрчилд холбогдсон насанд хүрээгүй 15 хүүхдийн судалгааг гаргаж, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Хууль зүйн хороо болон хорооны хамтарсан багт мэдээллийг хүргүүлж урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ зохион байгуулах талаар албан бичиг хүргүүлж, 13 хүүхдийг дүүргийн эрүүл мэндийн төв, сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, дүүргийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс болон Хар тахимтай тэмцэх газартай хамтран сургалтад хамруулж, донтолтын зэргийн тогтоолгосон. “Сэрэмжлүүлье, Анхааруулъя” арга хэмжээний хүрээнд дүүргийн 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 52 эмийн сан, эмийн бөөний төвүүдэд 09 дугаартай зөвлөмжийг өгч, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг 97 аж ахуйн нэгж, “Газ, будаг шингэлэгч болон” худалдан борлуулдаг 17 дэлгүүрт “21 насанд хүрээгүй хүнд архи согтууруулах ундаа, тамхи, ахуйн хүрээний газ, будаг шингэлэгч, цавуу зэрэг бусад төрлийн бодис худалдан борлуулахгүй байх” чиглэлээр 2022 оны 26л-1/3615 дугаартай зөвлөмжийг хүргүүлсэн. Арга хэмжээний үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар тээвэрлэсэн, хэрэглэсэн гэмт хэргийн илрүүлэлт 2 нэгжээр буюу 13.3 хувиар өсөж, харин</p>				90

		мансуурсан үедээ үйлдсэн гэмт хэрэг 1 нэгж буюу 6.3 хувиар буурсан байна.			
	140	4.2.4.6. Хулгайн гэмт хэрэг, ялангуяа орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байрлуулсан камерын тоо, камерын хяналтаар илрүүлсэн хэргийн тоог өсгөнө.	80%	20.0	ЦГ, ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ
		<p>БИЕЛЭЛТ: Засаг дарга болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд камерын нөхцөл байдлыг удаа дараа танилцуулж, 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр дүүргийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын удирдлагуудтай уулзаж дүүргийн 16 дугаар хороонд байрлах шинээр ашиглалтад орсон “Нийтлэг үйлчилгээний газар”-ын барилгыг “Камерын нэгдсэн хяналтын төв”-ийн зориулалтаар ашиглах урьдчилсан тооцоолол гаргаж, 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 15 дугаар тогтоолоор 210.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Камерын нэгдсэн төв нь 25 дэлгэц бүхий 1000 камерыг хянах хүчин чадалтай бөгөөд одоогоор 280 камерыг холбож ашиглалтад оруулаад байна. Ажил, арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэргийн илрүүлэлт өмнөх онд 51.2 хувь байсан бол 2022 онд 56 хувь болж 4.8 өссөн эерэг үзүүлэлттэй байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн 1, 2, 3 дугаар хороонд 375 камер шинээр байрлуулж “Ногоон бүс” болгон ажилласан.</p>			100
	141	4.2.4.7. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан арга хэмжээний тоог өсгөнө.	80%	20.0	ЦГ, ХЭЗХ, ГХУСАЗЗТ, Төрийн болон ТББ
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 4 их дээд сургуулийн 700 оюутанд “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” сургалт, Ерөнхий боловсролын 24 сургуулийн 6-12 дугаар ангийн 176 бүлгийн 7424 сурагч, “Олонлог” сургуулийн 32 багш, ажилтан нарт “Тодорхой төрлийн гэмт хэргийн талаар ойлголт” сургалт үйл ажиллагааг зохион байгуулан нийт 7456 иргэнийг хамруулсан байна. “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр 7 хоног бүрийн “Баасан гариг”-т алба хаагчид явган эргүүлд үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан арга хэмжээг “Хамаг монгол” fm 95.1 сайтад 20 минутын яриа, “Монгол мэдээ”, “Mongol comment”, “hunnu.mn” сайтуудад сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэсэн бөгөөд Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн 3 төрлийн видео мэдээллийг дүүргийн 1-19 дүгээр хороодын смарт дэлгэц, Улсын Их дэлгүүр, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цаг уур орчны шинжилгээний хүрээлэн, MN tower, нийт 6 лед дэлгэцэд байршуулан иргэдэд сурталчилсан. Нийт 212 удаагийн сургалтад 7424 иргэн хамруулж 26 удаа эргүүл хяналт шалгалт хийн 3 удаагийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулан ажилласан.</p>			90
4.2.5. Дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, нөөц бүрдүүлэх, гамшгийн	142	4.2.5.1. Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээ хийлгэх, техник тоног төхөөрөмжийг сайжруулах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион	100%	70.0	ОБХ, ХЭЗХ
					90

эрсдэлийг бууруулна.		байгуулна.				
		<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/176, А/177 дугаар захирамж болон Засгийн газрын өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг бууруулж шар түвшинд шилжүүлсэн болон Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төрийн хяналт шалгалтыг 3 жилийн хугацаатайгаар түр зогсоох шийдвэрийн дагуу төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан хяналт шалгалтыг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс хойш явуулаагүй бөгөөд 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг зочид буудалд 13, дэн буудал 10, амралтын газар 5, нийт 28 аж ахуйн нэгж, байгууллагад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, бүртгэл судалгааг шинэчлэн гаргаж, 202214017 дугаартай шаардлагыг хүргүүлсэн. Шалгалтын явцад гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд-1, оргодол этгээд 1 тус тус олж тогтоон холбогдох газар хэлтэст хүлээлгэн өгсөн. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулагдаж буй “Намайг алгас” аяны хүрээнд нийт 24 зочид буудалд 05 дугаартай зөвлөмж хүргүүлсэн.</p>				
4.3. ГАДААД ХАРИЛЦАА						
4.3.1. Дэлхийн улс орнуудын нийслэл, дүүрэг болон хотуудтай хамтын ажиллагаа тогтоох, аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Гадаад бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана.	143	4.3.1.1. Гадаад бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулан хэрэгжилтийг жил бүр тайлагнан ажиллана.	50%	150.0	ТЗУХ	50
		<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Нийслэлийн Чингэлтэй дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын баримт бичиг батлах тухай” 29 дүгээр тогтоолын хүрээнд 2022 онд Япон Улс, БНСУ, БНТУ, БНСВУ-тай төрийн албан хаагчдыг мэргэшүүлж, туршлага судлах болон соёл урлаг, спортын чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлж ажиллалаа.</p>				
	144	4.3.1.2. Харилцаа, хамтын ажиллагаатай гадаадын улс, хот, дүүргийн удирдлагатай хийх дүүргийн Засаг даргын албан уулзалт, айлчлал, томилолтын ажлыг тогтмол зохион байгуулж хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, уулзалтын тэмдэглэлийг хөтөлж хэрэгжилтийг хангана.	50%	150.0	ТЗУХ	100
		<p>БИЕЛЭЛТ: Япон Улсын Шизуока мужийн Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичигийн урилгаар дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 08 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд, Засаг даргын орлогч Д.Отгонбаатар тэргүүтэй төлөөлөгчид Яйзү хотод 2022 оны 12 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд тус тус айлчлахад бэлтгэл ажлыг ханган ажиллав. Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичи тэргүүтэй зочид төлөөлөгчид 2022 оны 08 дугаар сарын 16-19, мөн 10 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд Засаг даргын орлогч Шимояма Коожи тэргүүтэй зочид төлөөлөгчид 2022 оны 07 дугаар сарын 01-06-ны өдрүүдэд Чингэлтэй дүүрэгт тус тус айлчилсан ба зочид төлөөлөгчдийг хүлээн авах бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулж ажиллалаа.</p>				

	Дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэлийн Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичитэй 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдөр хийсэн албан уулзалт, 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Яйзү хотын Засаг даргын орлогч Шимояма Коожитой хийсэн албан уулзалт, 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр “Дүүргийн 37 болон 50 дугаар сургуульд шүдний үзлэг хийх тогтолцоог нэвтрүүлэх төсөл”-ийн хүрээнд Чингэлтэй дүүрэгт ажилласан Японы Эрүүл хотуудыг дэмжигч ашгийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн албан уулзалт, төслийн ээлжит цахим хурлыг 2022 онд нийт 7 удаа зохион байгуулж, уулзалт болон хурлын тэмдэглэлийг хөтөлж хэрэгжилтийг ханган ажилласан.				
145	4.3.1.3. Монголын үндэсний урлагийн тоглолт, спортын арга хэмжээгээр дамжуулан Монгол Улсыг гадаад улсад сурталчлах ажлыг дүүргийн Боловсролын хэлтэс, Биеийн тамир, спортын хороо, Соёлын төвтэй хамтран зохион байгуулна.	50%	150.0	ТЗУХ	90
	<p>БИЕЛЭЛТ: Чингэлтэй дүүргийн 30 жилийн ойн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдсан “Хүчит бөхийн барилдаан”-ыг үзэж сонирхохоор тус дүүрэгт хүрэлцэн ирсэн гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, бэлтгэл ажлыг хангаж, Япон улсын Шизуока мужийн Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичи тэргүүтэй төлөөлөгчид болон АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэд тэргүүн Фэрэнс нарыг хүлээн авсан.</p> <p>Турк улсын Косаели хотод 2022 оны 12 дугаар сарын 11-19-ний өдрүүдэд Олон улсын хамтарсан бэлтгэл болон хүүхдийн Жудо бөхийн тэмцээн зохион байгуулагдсан. Энэхүү тэмцээнд нийт 18 орны баг тамирчид өрсөлдсөнөөс Мон-Алтиус Цагаанбаатар академийн баг тамирчид амжилттай оролцож 1 алт, 5 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж 10 тамирчин шагналт байранд шалгарлаа.</p>				
146	4.3.1.4. Гадаадын харилцаа, хамтын ажиллагаатай хот, дүүрэгтэй хамтарсан аливаа урлаг, спортын нөхөрсөг тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулах	50%	150.0	ТЗУХ	100
	<p>БИЕЛЭЛТ: Чингэлтэй дүүрэг, Япон Улсын Яйзү хот хоорондын спортын хамтын ажиллагааны хүрээнд Яйзү хотын чөлөөт бөх, жүдогийн өсвөрийн шигшээ багийн тамирчид, Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх чөлөөт бөх, жүдогийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын дундах хамтарсан бэлтгэл, нөхөрсөг тэмцээнийг Яйзү хотын Засаг даргын Тамгын газартай хамтран 2022 оны 12 дугаар сарын 07-12-ны өдрүүдэд зохион байгуулсан ба Яйзү хотын аварга шалгаруулах өсвөрийн чөлөөт бөхийн тэмцээнд 3 тамирчин оролцсоноос О.Ариунбаатар 2 дугаар байр, С.Энх-Ирээдүй 3 дугаар байранд тус тус шалгарч, амжилттай оролцсон.</p>				
147	4.3.1.5. Дүүргийн Ерөнхий Боловсролын сургуулиудын хичээл, сурлага, урлаг спортоор манлайлдаг тэргүүний сурагчдыг “Сурагч солилцоо”-ны хөтөлбөрт хамруулж гадаадын хамтын ажиллагаатай хот, дүүргүүдийн сургуулиудад туршлага судлуулах	50%	150.0	ТЗУХ	90

	<p>БИЕЛЭЛТ: Чингэлтэй дүүрэг, Япон Улсын Яйзү хот хоорондын боловсролын хамтын ажиллагааны хүрээнд тус дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Япон улсыг хэн сайн мэдэх вэ?” сэдэвт гар зураг, эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулсан ба сурагчдаас ирүүлсэн нийт 125 бүтээлээс 6-12 нас, 13-17 насны ангиллаар шилдэг байруудыг шалгаруулсан. Ангилал бүрээс 1 дүгээр байранд шалгарсан 4 сурагчийг 2023 оны 03 дугаар сард Яйзү хотод аялуулж, сурагч солилцооны хөтөлбөрт хамруулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>				
148	<p>4.3.1.6. Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргийн ижил түвшний төрийн байгууллын албан хаагчдыг богино хугацаатай харилцан солилцох хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.</p>	50%	150.0	ТЗУХ	90
	<p>БИЕЛЭЛТ: Төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилтын хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Боловсролын хэлтсийн 1 албан хаагчийг Япон Улсын Яйзү хотод 2023 оны 02 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд ажилтан солилцооны хөтөлбөрт хамруулах бэлтгэл ажлыг хангаж, виз мэдүүлэхэд шаардагдах бичиг баримтуудыг бүрдүүлэн ажиллаж байна.</p>				
149	<p>4.3.1.7. Дүүргийн төрийн албан хаагчдыг хариуцсан ажил үүргийн хүрээнд гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагдах, туршлага судлах уулзалт, семинарт хамрагдахад бүхий л талаар дэмжиж ажиллана.</p>	50%	150.0	ТЗУХ	100
	<p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хотын хөгжлийг дэмжих Шинэ тосгон холбооноос 2022 оны 03 дугаар сарын 12-19-ний өдрүүдэд зохион байгуулсан Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул, Анталая, Денизли хотуудын хог хаягдал, ногоон байгууламж, хот тохижилтын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах сургалтад тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Х.Энхбатыг хамруулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар “Санхүүчдийн сан” ТББ-аас 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулсан Бүгд Найрамдах Турк Улсын Анталая хотын Акдениз Их сургууль дахь олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, төсөв, санхүүгийн менежментийн сургалтад Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Оюуныг хамруулсан.</p> <p>Японы Эрүүл хотуудыг дэмжигч ашгийн бус байгууллага болон Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай 2022-2025 онд хамтран хэрэгжүүлж буй дүүргийн Ерөнхий боловсролын 37, 50 дугаар сургуульд шүдний үзлэг хийх тогтолцоог нэвтрүүлэх төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч Ажлын хэсгийн гишүүдийг 2022 оны 06 дугаар сарын 27-ноос 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд Япон Улсын Токио хотод Японы сургуулиудад хийгддэг сурагчдын шүдний үзлэгтэй танилцаж, үзлэгийг хэрхэн хийх талаар туршлага судлах сургалтад хамруулсан.</p> <p>Япон Улсын Токио хотод 2022 оны 08 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Хог хаягдал, Ногоон байгууламж тохижилтын байгууллагуудын туршлага судлах сургалтад тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Б.Саруул-Од, Агаар, орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн Б.Эрдэнэбаяр нарыг хамруулсан.</p>				

	<p>Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуанжу хотод 2022 оны 10 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Creative training” сургалтад дүүргийн 11 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Пендик дүүрэгт дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл тэргүүтэй 23 албан хаагч 2022 оны 11 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд зочилж, тус дүүргийн хог хаягдлын менежменттэй танилцаж, туршлага судалсан.</p> <p>Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хо Ши Мин хотод 2022 оны 12 дугаар сарын 22-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, туршлага судлах сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газрын 6 албан хаагчийг хамруулсан.</p>				
150	<p>4.3.1.8. Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдийг гадаадын хамтын ажиллагаатай хот, дүүргийн аж ахуй нэгжүүдтэй хамтын ажиллагаа тогтоох тал дээр дэмжиж ажиллах, тэднийг олон улсын шинж чанартай үзэсгэлэн худалдаанд оролцоход хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж бүх талаар дэмжиж ажиллана.</p>	50%	150.0	ТЗУХ	100
	<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд Япон Улсын Шизуока мужийн Яйзү хотод хийсэн айлчлалын үеэр дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Яйзү хоттой цаашид худалдаа, аж үйлдвэрийн чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцсон бөгөөд тус хотын Ойгава худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч Сакакибара Шёожи 2022 оны 08 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд Чингэлтэй дүүрэгт зочилж, дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвтэй танилцаж, тус төвийн захиралтай санал солилцсон.</p>				
151	<p>4.3.1.9. Гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагуудтай бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлж дүүргийн нийт ард иргэдийн эрх ашгийн төлөө хамтарсан үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.</p>	50%	150.0	ТЗУХ	100
	<p>БИЕЛЭЛТ: Орбис Олон улсын байгууллага болон Эрүүл хотуудыг чадавхжуулах төвтэй хамтран “Чихрийн шижин болон чихрийн шижингийн шалтгаант ретинопатийн тусламж үйлчилгээний загвар бий болгох” төслийн нэгжийн мэргэжилтнүүд болон гол хамтрагч нарт нийгмийн маркетингийн талаар танилцуулж, цаашдын төлөвлөгөөний талаар санал солилцох зорилгоор “Харилцаа холбооны төлөвлөгөө боловсруулах нь” сэдэвт семинарыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, семинарт Чингэлтэй дүүрэг, Дархан-Уул, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүдийг оролцуулсан бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газрын 3 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Дүүргийн нийт хүн амын дундах шүдний өвчлөлийг бууруулах зорилгоор Японы Эрүүл хотуудыг дэмжигч ашгийн бус байгууллага, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран</p>				

		2022-2025 онд хамтран хэрэгжүүлж буй тус дүүргийн 37, 50 дугаар сургуульд шүдний үзлэг хийх тогтолцоог нэвтрүүлэх төслийн хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 12-16-ны өдрүүдэд болон 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд тус сургуулиудын сурагчдад Япон Улсын стандартын дагуу амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хийсэн бөгөөд Япон эрүүл хотуудыг дэмжигч ашгийн бус байгууллагын зөвлөх Инагаки Томиказү, зөвлөх эмч Фүжино Мурашигэ, Хасэгава Масарү, Мидорикава Шизүо нар 2022 оны 09 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд Чингэлтэй дүүрэгт зочилж, Ерөнхий боловсролын 37, 50 дугаар сургуулиудад хийгдсэн сурагчдын шүдний үзлэгтэй танилцаж, заавар зөвлөгөө өгсөн.				
	152	4.3.1.10. Дүүргийн Ерөнхий Боловсролын сургуулиудыг цахим сургууль болгох чиглэлд Олон Улсын Байгууллагуудтай нягт хамтарч ажиллана.	50%	150.0	ТЗУХ	90
		БИЕЛЭЛТ: Дүүргийн Ерөнхий боловсролын 17, 72 дугаар сургуулиудад Оросын шинжлэх ухаан, соёлын төв /РЦНК/-тэй хамтран 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр орос хэлний төвүүдийг байгуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Боловсролын хэлтэс тус байгууллагатай Хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан. Орос хэлний төв байгуулах ёслолын үйл ажиллагааны үеэр Оросын шинжлэх ухаан, соёлын төвийн захирал Амгалан Базархандаев Ринчинович тус дүүргийн 17 дугаар сургуулийг ЗХУ-ын 3 удаагийн баатар, маршал Семён Михайлович Будённыйн, 72 дугаар сургуулийг Оросын сансрын нисгэгч, ЗХУ-ын хошой баатар, БНМАУ-ын баатар, хошууч генерал Владимир Александрович Жанибековын нэрэмжит болгох тухай мэдэгдсэн.				
	153	4.3.1.11. Гадаадын харилцаа, хамтын ажиллагаатай хот, дүүрэгтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, АНУ, БНХАУ, Унгар зэрэг улсын хот, дүүргүүдтэй шинээр хамтын ажиллагаа тогтооно.	50%	150.0	ТЗУХ	70
		БИЕЛЭЛТ: Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх зорилгоор 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдөр тус дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл, Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичи нар цаашид илүү олон салбарт хамтран ажиллахаар Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Сариер дүүрэгтэй найрсаг харилцаа, хамтын ажиллагаа тогтоож, ирээдүйд олон салбарт хамтран ажиллах эрмэлзлээ илэрхийлж, тус дүүргийн Засаг дарга Шукру Генчид 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр албан захидал илгээсэн.				
4.4. ТӨРИЙН БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ						
4.4.1. Орон нутгийн хамгаалалтын хуулийн хэрэгжилтийг дүүргийн нутаг дэвсгэрт хангаж, бүх шатны байгууллага, нэгжийн хүлээх үүрэг, ажлын уялдааг хангаж ажиллана.	154	4.4.1.1. Орон нутгийн хамгаалалтын хуулийн хэрэгжилтийг дүүргийн нутаг дэвсгэрт хангаж, бүх шатны байгууллага, нэгжийн хүлээх үүрэг, ажлын уялдааг хангаж ажиллана.	100%	10.0	ЦШ	100
		БИЕЛЭЛТ: Орон нутгийн цэргийн отрядын хүн техникийг 2021 оны цэргийн бүртгэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас авсан авто техникийн 2022 оны бүртгэлийн судалгааг авч оногдуулан				

		бүртгэсэн. Зарим тодотголыг нэмэлтээр хийж, 2022 оны Зэвсэгт хүчний Жанжин штабын Ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан Стратегийн команд штабын сургуулиар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын оногдуулан бүртгэсэн. Орон нутгийн Цэргийн Отряд, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний чанар байдлын судалгааг гарган үүрэг гүйцэтгэх мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг Зэвсэгт хүчний 084 дүгээр анги дээр 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж явуулсан.				
4.4.2. Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг үе шаттай зохион байгуулна.	155	4.4.2.1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг иргэд, байгууллага аж ахуйн нэгжид сурталчилж, хяналт тавина.	100%	3.0	ЦШ	90
		БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын 2022 оны А/37 дугаар захирамж болон удирдамжийн дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Сангийн яам, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын 24 дүгээр сургууль, Олонлог эгзэ сургууль, Соёмбо принтинг ХХК нийт 6 байгууллага, аж ахуйн нэгжийн 170 ажилтан албан хаагчдад Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд шалган туслах ажлыг зохион байгуулж, 147 цэргийн үүрэгтнийг тус шалгалтад хамруулж, цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөр орлуулан хаах болзол хангасан 18 иргэнд хуулийн дагуу тогтоож 6 иргэнээр 4,014,619 төгрөгийн мөнгөн төлбөрийг Нийслэлийн төрийн санд төвлөрүүлж ажилласан. Цэрэг татлага, тоо бүртгэлээс завсардсан иргэдэд хуулиа биелүүлж, үүргээ ухамсарлах, Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах талаар яриа, таниулга хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтад хамрагдаагүй, болон цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоолгосон иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавьж байгууллагын удирдлагатай харилцан ажиллагааг ханган ажиллаж байна.				
	156	4.4.2.2. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, дайнд оролцсон үе үеийн ахмад дайчдад хүндэтгэл үзүүлнэ.	100%	37.0	ЦШ	100
		БИЕЛЭЛТ: Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тэмдэглэх тухай Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/305 дугаар дүүргийн Засаг даргын А/98 дугаар захирамж, ЗДТГ-ын даргын А/45 дугаар тушаалаар Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөт 17 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа. Мөн 1945 оны чөлөөлөх дайнд оролцсон дүүргийн 8 дугаар хороонд оршин суудаг ахмад дайчин С.Ванчигдоо, Баруун хилийн тулгаралтад тулалдаж явсан 6 дугаар хороонд оршин суудаг ахмад дайчин Б.Логи нарт Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101, Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэндийг хүргэж, 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль, Батлан хамгаалах яамны гарын бэлгийг гардуулан өглөө.				
4.4.3. Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлт, удирдлагын нэгдмэл байдлыг ханган ажиллана.	157	4.4.3.1. Дайчилгааны төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилтийг ханган сургалтуудыг чанаржуулна.	100%	38.0	ЦШ	100
		БИЕЛЭЛТ: Дүүргийн батлан хамгаалах товчооны томилгоот бие бүрэлдэхүүн болон хороодын дайчилгааны татан нийлүүлэх төлөвлөгөө, техник оруулалтын журмын дагуу тодотгосон. Мөн 2022 оны цэргийн бүртгэлээр Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Цэргийн албаны тухай хуулийн 8 дугаар бүлгийн 33				

	<p>дугаар зүйл, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны мн/123 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын н/01, дүүргийн Засаг даргын н/02 дугаар захирамжийн дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн I зэргийн бэлтгэл үүрэгтнийг мэдэгдэх хуудсаар дуудаж Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн байрлалд 2022 оны 05 дугаар сарын 23-наас 05 дугаар сарын 28-ны өдрүүдэд сургалтад хамруулсан.</p> <p>Зэвсэгт хүчний 124 дүгээр ангид 1 дүгээр зэргийн 10 бэлтгэл үүрэгтнийг 09 дүгээр сарын 19-ний өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдрүүдэд цэргийн бэлтгэл сургалтад хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хамруулсан.</p> <p>Бэлтгэл офицерын сургалтад хамрагдах 4 цэргийн бэлтгэл үүрэгтний Үндэсний Батлан хамгаалахын их сургууль дээр 2022 оны 09 дүгээр сарын 12-18-ны хооронд нэгдүгээр шатны сургалтад хамруулсан.</p> <p>Цэргийн албаны сургалтад хамрагдсан Цэргийн үүрэгтнүүдийг нэгтгэл анги, салбарт оногдуулан бүртгэсэн. Дүүргээс шилжин явсан болон ирж байгаа цэргийн бэлтгэл үүрэгтний шилжилт хөдөлгөөнийг бүртгэн ажиллаж байна.</p>					
158	<p>4.4.3.2. Цэргийн бүртгэлийг чанаржуулан жил бүрийн 1, 2 дугаар ээлжийн цэрэг халалт, татлага, ажлын байр, сургалт дамжаанд зуучилна.</p> <p>БИЕЛЭЛТ: Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/980, дүүргийн Засаг даргын А/513 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын 05-наас өдрөөс 01 дүгээр сарын 21-ний өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг E-Mongolia цахим портал, Засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны Засаг даргын ажлын байранд зохион байгуулан 2022 оны Цэргийн бүртгэл 96,2 хувийн хамрагдалтай явагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/512, дүүргийн Засаг даргын А/143 дугаар захирамжийг тус тус үндэслэн 2022 оны 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд 2022 оны 1 дүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг зохион байгуулж явуулсан.</p> <p>Цэрэг татлагын бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө гаргаж, цэрэг татлагын товчооны даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд нийт 32 ажил төлөвлөснөөс гүйцэтгэл 100 хувь биелүүлж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас өгсөн хяналтын тоон даалгаврыг бүрэн биелүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/303, дүүргийн Засаг даргын А/97 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн 7 их, дээд, сургуулийн 15 оюутныг сонгон шалгаруулж оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтад хамруулж цэргийн тангараг өргүүлсэн.</p> <p>Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөр орлуулан хаах болзол хангасан иргэдийн нэрийн жагсаалтыг гаргаж 180 иргэнд мөнгөн төлбөр тогтоож 180 иргэнээр 181.500,000 мянган төгрөгийг Нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн.</p> <p>Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144, 2019 оны 441 дүгээр тогтоол, 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг оношилгоо, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” хөтөлбөрийн төлөвлөгөөтэй уялдуулан дүүргийн Засаг даргын захирамж, болзолт уралдааны удирдамж гарган явцын дүнг дүгнэн ажилласан.</p>	100%	82.0	ЦШ	90	
159	<p>4.4.3.3. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана ажиллана</p>	100%	3.0	ЦШ	100	

		<p>БИЕЛЭЛТ: Компьютер, техник хэрэгслүүдэд алдаа гарах, гэмтэл учрах, гаднын халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын хэмжээнд, мэдээллийн технологи, сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран дотоод хяналт шалгалтыг хийсэн.</p> <p>Маш нууц, нууц, албан хэрэг, данс бүртгэлийн ангилал болон хээрийн ангиллын төлөвлөгөөг батлуулан Төрийн болон албаны нууцын тухай хууль, Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/06 дугаар тушаалаар төрийн болон албаны нууцын 2, 3 дугаар түвшний нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнуудаар нууцын баталгаа гаргуулж баталгаажуулсан.</p> <p>Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудын 2022 оны 09 дүгээр сарын 01-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан штабын хэсэгчилсэн болон нэгдсэн дадлагын үед төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p>				
4.4.4. Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх, цэргийн алба хаах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.	160	<p>4.4.4.1. Дүүргийн Засаг даргын нэрэмжит “Дөл” цэрэг-спортын цогцолбор тэмцээнийг зохион байгуулна.</p> <p>БИЕЛЭЛТ: Дүүргийн Засаг даргын нэрэмжит “Дөл”-2022 тэмцээнийг 3 үе шаттай зохион байгуулж явуулсан. “Дөл”-2022 тэмцээний нэгдүгээр шатанд дүүргийн Ерөнхий боловсролын 13 сургуулийн 1690 гаруй сурагчид оролцож, 2022 оны 3 дугаар сарын 25-наас 04 дүгээр сарын 12-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Хоёрдугаар шатанд тус сургуулиудаас шалгарсан шилдэг 170 сурагч 2022 оны 4 дүгээр сарын 15, 16-ны өдөр Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн материаллаг баазыг түшиглэн хурд хүч авхаалж самбаа сорин өрсөлдөж тэргүүн байрт шалгарсан 24 дүгээр сургуулийн Хар сүлд тасаг, дэд байрт шалгарсан 23 дугаар сургуулийн Элит-23 тасаг, гутгаар байрт 39 дүгээр сургуулийн Шонхор тасаг тус тус шалгарсан. Тэмцээний гуравдугаар шатны шалгаруулалтад дүүргийн Ерөнхий боловсролын 23, 24, 37 дугаар сургуулиудаас сонгон шалгарсан шилдэг сурагчид Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн байрлалд бэлтгэл сургуулилалтыг зохион байгуулж 2022 оны 08 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд 14 төрлийн дасгал нормативыг дүүргийн баг тамирчид амжилттай гүйцэтгэж нийлбэр дүнгээр улсын хэмжээнд Дэд байрт шалгарсан.</p>	100%	45.0	ЦШ	100
	161	<p>4.4.4.2. Хугацаат цэргийн албанд татагдсан амьжиргааны түвшин доогуур дайчдын ар гэрт халамж : Төлөвлөгөөний дагуу 3, 4-р улиралд зохион байгуулж явуулна үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>БИЕЛЭЛТ: Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн дагуу хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдын ар гэрт халамж үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - 5 айл өрхөд сайжруулсан шахмал түлшний тусламжид /1 тн/; - 55 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан; - 9 хугацаат цэргийн албан хаагчийн ар гэрийн төлөөллийг ажилд оруулахад дэмжлэг үзүүлсэн; - 22 хугацаат цэргийн албан хаагчийн ар гэрт эд материалын тусламж, дэмжлэг тус тус үзүүлсэн; <p>Цэргийн алба хааж халагдаж ирсэн 16 иргэнийг мэргэжил олгох сургалтад хамруулж, 13 иргэнийг байнгын ажлын байранд зуучлан, 22 иргэнд эд материалын тусламж, 1 иргэнийг Их, дээд сургуульд оруулахад зуучилж, 13 иргэнд ажлын байр болон мэргэжил олгох сургалт, дамжааны талаар зөвлөгөө өгч ажилласан.</p>	100%	15.0	ЦШ	100

	162	4.4.4.3. I үе шат хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.	100%	5.0	ЦШ	90
		БИЕЛЭЛТ: Дүүргийн 30 жилийн ой, Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсэн 20 жилийн ойн хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 37, 149 дүгээр сургуульд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сэдэвт хүндэтгэлийн буланг байгуулж, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер дэд хурандаа Б.Цэдэн, төлөвлөлт, сургалтын офицер, хошууч Н.Лхамжав нар сурагчдад энхийг сахиулах ажиллагаа болон Бүгд найрамдах Өмнөд Судан Улсын талаар танилцуулга хийсэн.				
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
5.1. НОГООН ХӨГЖИЛ						
5.1.1. Агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилго бүхий “Ногоон дүүрэг 2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	163	5.1.1.1. Агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилго бүхий “Ногоон дүүрэг 2024” арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана.	50%	Батлагдсан төсвийн хүрээнд	ТНААХ	90
		БИЕЛЭЛТ: “Ногоон дүүрэг 2024” арга хэмжээний хөтөлбөрийг Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ногоон хөгжил, газрын харилцааны хорооны хурлаар биелэлтийг танилцуулж, хэрэгжилт, явц, үр дүнг хэлэлцэн “ Хангалтай ” гэж дүгнүүлсэн. “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл”-ийг дүүргийн 7-19 дүгээр хороонд зохион байгуулан “Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан” буюу https://www.envpol.mne.gov.mn/ цахим системд нийт ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадлын 21095 зуух, усан халаалтын 15-100 кВт хүртэл хүчин чадлын 307 зуух, 100-4200 кВт хүртэл хүчин чадлын 40 зуухны мэдээллийг оруулсан. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмыг шинэчлэн батлахтай холбогдуулан дүүргийн 7-20 дугаар хорооны айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын халаалтын системийн эх үүсвэрт тооллого, бүртгэл хийхэд цахилгаан халаалтын системтэй 1783 айл өрх, 250 аж ахуйн нэгж байгууллага, бусад эх үүсвэртэй 45 айл өрх, хийн системээр 7, газрын гүнээр 1 аж ахуйн нэгж байгууллага тус тус халаалтын системийг шийдсэн байна. Чингэлтэй дүүрэг нь 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 8 агуулах, 4 саравчинд 13062,5 тонн сайжруулсан шахмал түлшний нөөцтэй бөгөөд дүүргийн хэмжээнд сайжруулсан шахмал түлш борлуулах нийт 92 цэг ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/288 дугаартай захирамжаар “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах” ажлын хэсэг байгуулагдсан. “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх” нэгдсэн өдөрлөгийг Чингэлтэй дүүргийн Онцгой комисс, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, “Таван толгой түлш” ХХК-тай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион				

		байгуулсан. Тус өдөрлөгийн арга хэмжээнд Нийслэлийн нутгын захиргааны 11 байгууллага, дүүргийн 7-24 дүгээр хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч, олон нийтийн байцаагч, нийтийн эргүүл, иргэд, оролцож, зөв галлагаа, угаартсан үед авах арга хэмжээний талаар мэдээ мэдээлэл өгч гарын авлага тараан ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62, 2022 оны 223 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/341 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 7-20 болон 24 дүгээр хорооны Ерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах ангийн 592 сурагчдад Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх” сургалтыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, “Таван толгой түлш” ХХК-тай хамтран зохион байгуулсан.				
5.1.2. Дүүргийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, цэцэрлэгт хүрээлэн, ойжуулалт, ногоон байгууламжийг бүтээн байгуулна.	164	5.1.2.1. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	10% аас доошгүй нэмэгдүүлнэ.	1300.0	ТНААХ, ТҮК	90
		БИЕЛЭЛТ: Дүүргийн хэмжээнд нийт 14 төрлийн (хайлаас, бургас, нарс, гацуур, улиас, агч, шар хуайс, монос, голт бор, балгана, гүйлс, буйлс, шинэс, чацаргана) буюу нийт 48360 модыг 4500 албан хаагч, ажилчид тарьж суулгасан. Үүнд: Хаврын мод тарих аяны хүрээнд Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр Улсын төсвийн хөрөнгөөр Тахилтын аманд 4 тэрбум төгрөгийн төсөвтэй тохижилтын ажил гүйцэтгэхээр зураг төсвийг “Сивил дизайн” ХХК хийж, “Жавхлан хүслэн” ХХК гүйцэтгэгчээр ажиллаж байна. Аяны хүрээнд дүүргийн 19 дүгээр хороо, “Хайрхан хөгжлийн төв” ОНӨТҮГ 13263, дүүргийн 16 дугаар хороо, “Хоймор хайрхан амралт” ОНӨТҮГ 10106, “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” УТҮГ 2000, дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Ж.Самбуугийн гудамж, 1 дүгээр хороо, Жуулчны гудамж 15000, дүүргийн 293 дугаар цэцэрлэгийн хашаанд 100, нийт 6 байршилд төрийн байгууллага 96, хувийн хэвшлийн 6 байгууллагын ажилтан албан хаагчид нийт 40469 мод тарьж суулгасан. Дүүргийн 5 дугаар хороо, Тусгаар тогтнолын талбайд “Тохижилт үйлчилгээ” ХХК 4000 ширхэг нэг наст цэцгийн мандлыг байгуулж 6320м ² талбайд нөхөн сэргээлт болон шинээр зүлэгжүүлэлтийг ажлыг хийж гүйцэтгэсэн. Хаврын тарьсан модны ургалтын явцад хяналт тавихад 80 хувийн ургалттай байна. Намрын мод тарих аяны хүрээнд Нийслэлийн Байгаль орчны газар, дүүргийн Засаг даргын тамгын газар, Хороод, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, “Эрдэнэс таван толгой” ХХК-ийн 500 албан хаагч нар хамтран 2022 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд нийт 7481 мод тарьж суулгасан. Мөн Сууц өмчлөгчдийн холбоод өөрсдийн эзэмшлийн талбайд нийт 410 модыг тарьсан.				
	165	5.1.2.2. Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.	10% аас доошгүй нэмэгдүүлнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	ТНААХ, ТҮК	90
		БИЕЛЭЛТ: Ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр Тахилтын аманд 4 тэрбумаар тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Сивил дизайн” ХХК хийж гүйцэтгэн тендер зарлан “Жавхлан хүслэн” ХХК шалгаран газар шорооны ажлыг эхлүүлсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3 дугаар хороонд 200м ² явган зам, 135м ² зүлэг, 1 сүүдрэвч, 7 дугаар хороонд жишиг 3*3 сагсан бөмбөгийн стандарт талбай тус тус хийж гүйцэтгээд байна. Дүүргийн 8 дугаар хороонд 240 м ² явган замыг “Монгол туургатны зам” ХХК хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороонд сагсны талбай, хүүхдийн тоглоомын талбайг “Би Жи Роял” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн				

		өгсөн. Орон сууц болон гэр хорооллын дунд 6 байршилд хүүхдийн тоглоомын талбайг засварлах ажлын хүрээнд Түвшин тумбааш ХХК зураг төсвийг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 144 гарааш буулгаж 7 байршилд тохижилтын ажил хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 17 дугаар хорооны Зүрх ууланд явган аяллын маршрут бүхий тохижилтын ажлын зураг, олон булагтайн цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсвийг хийж гүйцэтгэж байна. Дүүргийн 14 дүгээр хороонд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин "Чингисийн отог" ХХК 1800м ² байгалийн чулуун зам, явган зам 700м ² , хашаа шинэчлэх ажил 500м хийж жишиг гудамж бий болгосон. Улс, нийслэл дүүргийн төсвийн хөрөнгөөр дүүргийн хэмжээнд 15 бичил цэцэрлэг байгуулаад байна.				
5.1.3. Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилал, боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлж, өндөр хөгжилтэй орнуудын хогны менежментээс туршлага судлан хэрэгжүүлнэ.	166	5.1.3.1. Швейцарын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах, худалдан авах цогц менежмент төслийг хэрэгжүүлнэ.	50%	Батлагдсан төсвийн хүрээнд	ТНААХ, ТҮК, Найши трейд	90
	<p>БИЕЛЭЛТ: Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежмент (УБАХХЦТМ) төсөл нь 2019 оны 4 дүгээр сараас эхлэн Чингэлтэй дүүрэгт хэрэгжсэн. Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн хог хаягдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, загвар дүүргүүд дэх хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежментийн үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэх, хог хаягдлын менежментийн санхүүгийн тогтвортой байдал, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран хийж хэрэгжүүлсэн.</p> <p>УБАХХЦТМ төсөл нь Загвар төслийн төлөвлөгөөг дүүргийн 7, 12 дугаар хороонд хэрэгжүүлж байгаа бөгөөд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах зориулалттай нийт 500 айлын хашаанд хогийн сав байршуулан үүсмэл хог хаягдал байнга төвлөрдөг цэгүүдэд нарны эрчим хүчээр ажилладаг зөөврийн зориулалттай камерыг нийт 16 байршилд суурилуулаад байна. Дүүргийн 2 хорооны оршин суугч иргэдийн хог ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох, дахин боловсруулах боломжтой дахиврыг иргэдээс худалдан авах, иргэд хог хаягдлын талаар мэдлэг олгох сургалт, сурталчилгаа явуулах зорилгоор "Recycle shop" цэгийг төсөл хэрэгжиж байгаа 7, 12 дугаар хороонд тус бүр байгуулаад байна.</p>					
	167	5.1.3.2. "Хог биш баялаг" ТББ-ын "Хогоо мөнгө болгоё" сургалт, "Дахивар нөөцийн цэг" бий болгох төслүүдийг дүүргийн нийт хороодод хэрэгжүүлнэ.	1	Батлагдсан төсвийн хүрээнд	ТНААХ, Хороод	100
	<p>БИЕЛЭЛТ: Дахивар нөөц худалдан авах ХОГ БИШ БАЯЛАГ төвийн засвар, бэлтгэл ажил бүрэн хангагдаж Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас гарсан дахивар түүхий эдийг худалдан авч Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийг шинэчлэн байгуулж үйл ажиллагаа нь тогтмол хэвийн явагдаж байна.</p> <p>Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг хүнээр тооцож, холбогдох аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлахаар болсонтой холбогдуулан "Хог хаягдлын менежментийн санхүүгийн зохицуулалт" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулан ажиллалаа</p> <p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэр үйлчилгээ, гэр хорооллын</p>					

		хөгжлийн хорооноос санаачилж, ИТХ-ын Зөвлөлөөс дэмжин баталсан хог хаягдлыг ангилан ялгаж, байгаль орчинд учрах нөлөөллийг бууруулах зорилго бүхий "Чингэлтэйн хог баялаг болно" төсөл хэрэгжүүлж эхлэн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус төслийг "Хог биш баялаг" ТББ-тай хамтран "Чингэлтэйн хог баялаг болно" сэдэвт сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн ажлыг дүүргийн 1-24 дүгээр хороодын Иргэний танхимаар дамжуулан нийт 24 удаа зохион байгуулан ажилласан.				
5.1.4. Дүүргийн ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, усны алдагдлыг бууруулна.	168	5.1.4.1. УСУГ-ын харьяа ус түгээх байрнуудын хэвийн үйл ажиллагааг хангуулна.	Баталгаат ус хангамжийн эх үүсвэрийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	-	УСУГ, ТНААХ, ТГУХ	100
		БИЕЛЭЛТ: Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Ус сувгийн удирдах газрын харьяа 132 ус түгээх байрны үйл ажиллагаанд хяналт тавихад доголдол үүсэлгүй хуваарийн дагуу ажилласан. Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар дүүргийн 12 дугаар хорооны Булгийн 20 дугаар гудамжинд 2019 онд баригдсан ус түгээх байрыг УСУГ-т хүлээлгэн өгч, ус түгээх байранд /969 дүгээр ус түгээх байр/ дугаар олгож 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн байнгын ашиглалтад оруулсан. Мөн дүүргийн 12, 16, 17, 18, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт 5 гүний худгийн арчлалт, хамгаалалт, ашиглалтыг хариуцан ажиллах талаар Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-т 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 3/2261 тоот албан бичгээр хүргүүлсэн.				
5.1.5. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах ажлыг холбогдох байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.	169	5.1.5.1. Авто үйлчилгээний байгууллагуудад "Саарал ус ашиглах технологи"-ийг нэвтрүүлнэ	Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 1 авто угаалгын газар саарал ус ашиглах технологийг нэвтрүүлнэ.	-	ХХҮХ	90
		БИЕЛЭЛТ: Дүүргийн 4 дүгээр хороо, Бага тойруу Г4 тоотод байрлах Эн Эс Ти Эн ХХК-ийн "Эко" автомашин угаалгын газар нь усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах зорилгоор АНУ-ын Coleman Hanna car wash systems компанийн хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах автомат төхөөрөмжийг 2014 онд суурилуулан "Саарал ус ашиглах технологийг үйл ажиллагаандаа 2015 оноос эхлэн нэвтрүүлэн ажиллаж байна. БОАЖЯ тус компанитай хамтран авто машин угаалгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 30 иргэн, аж ахуйн нэгжид "Саарал ус дахин ашиглах технологи"-ийг нэвтрүүлэх үзүүлэх сургалтыг зохион байгуулан ажилласан.				
5.1.6. Ундны усны эх үүсвэрийн гүний худаг, тоолуургүй айл өрх, аж ахуйн нэгжийн судалгааг нарийвчлан гаргаж усны бодит хэрэглээг тооцох бэлтгэл ажлыг хангана.	170	5.1.6.1. Усны тоолуур суурилуулсан өрх нэмэгдсэн байна.	10%	-	ТНААХ, ХХҮХ, СӨХ, ОСНААУГ	100
		БИЕЛЭЛТ: Дүүргийн 1-6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх цэвэр усны шугамд тоолуур суурилуулаагүй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг 2022 оны 01 дүгээр сард шинэчлэн гаргахад 2489 айл өрх, аж ахуйн нэгж байгууллага цэвэр усны шугамд тоолуур суурилуулаагүй бөгөөд айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 248 айл өрхөд 711 тоолуур, 9 аж ахуйн нэгж байгууллагад 18 тоолуур, нийт 729 цэвэр усны тоолуур шинээр суурилуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажилласан.				
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						

6.1. ИРГЭДИЙН ТАВ ТУХТАЙ ОРЧИН

<p>6.1.1. Чингэлтэй Хайрханыг чиглэсэн аяллын маршрут чиглэлийг гаргаж иргэд ая тухтай орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>171</p>	<p>6.1.1.1. Чингэлтэй хайрхны бүсэд соёл, амралтын хүрээлэн байгуулах хэтийн зорилгоор хайрхныг чиглэсэн аяллын маршрут чиглэл гаргаж иргэд ая тухтай орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>30%</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<p>ТГУХ, НХХ</p>	<p>90</p>	
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн нутаг дэвсгэрт соёл, аялал жуулчлалын арга хэмжээг тогтмол зохион байгуулах, гудамж хороог тохижуулах, шинэ аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг судалж, төлөвлөгөө гарган танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/425 дугаар захирамжаар байгуулж, төлөвлөгөөний төсөлд дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэр, Зүрх уулын чиглэлд аялал жуулчлалын таатай нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Чингэлтэйн эцсийн автобусны буудлаас Зүрх уулын “Уулын фитнес” хүртэлх авто зам ажлын зураг төсвийг “Классик роуд” ХХК хийж гүйцэтгэн 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр магадлалаар баталгаажуулан ажилласан.</p>					
<p>6.1.2. Орон сууц, гэр хорооллын дунд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, бичил цэцэрлэг, явган болон дугуйн зам барьж, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлнэ.</p>	<p>172</p>	<p>6.1.2.1. Орон сууц, гэр хорооллын дунд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, бичил цэцэрлэг, явган болон дугуйн зам барьж, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлнэ.</p>	<p>1</p>	<p>205.0</p>	<p>ТНААХ, НХХ</p>	<p>100</p>	
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн хэмжээнд 65 бичил цэцэрлэг болон тоглоомын талбай байгаа ба ашиглалт, хамгаалалтыг Чингэлтэй дүүргийн Тохижилт Үйлчилгээ ХХК хариуцан ажиллаж сар бүр үзлэг шалгалтыг хамтран зохион байгуулж сэргээн засварлах ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэхээр Улсын төсвийн хөрөнгөөр Тахилтын аманд 4 тэрбумаар тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Сивил дизайн” ХХК хийж гүйцэтгэн тендер зарлан гүйцэтгэгчээр Жавхлан хүслэн ХХК шалгаран газар шорооны ажлыг эхлүүлсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3 дугаар хороонд 200м² явган зам, 135м² зүлэг, 1 сүүдрэвч, 7 дугаар хороонд жишиг 3*3 сагсан бөмбөгийн стандарт талбайг тус тус хийж гүйцэтгээд байна. Дүүргийн 8 дугаар хороонд 240 м² явган замыг “Монгол туургатны зам” ХХК хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороонд сагсны талбай, хүүхдийн тоглоомын талбайг “Би Жи Роял” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Орон сууц болон гэр хорооллын дунд 6 байршилд хүүхдийн тоглоомын талбайг засварлах ажлын хүрээнд Түвшин тумбааш ХХК зураг төсвийг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 13 дугаар хороо 17 дугаар сургуулийн гадна 3*3 сагсан бөмбөгийн талбайг шинэчлэх засварын ажил хийгдэж дууссан. Дүүргийн хэмжээнд 2022 онд 15 бичил цэцэрлэг байгуулаад байна.</p>					
<p>6.1.3. Орон сууцны хороодын дунд “Хайрхан хөгжил төв - IV”-ийг шинээр барьж</p>	<p>173</p>	<p>6.1.3.1. Хайрхан хөгжлийн төв 4 спорт цогцолборын барилгыг ашиглалтад оруулна.</p>	<p>100%</p>	<p>-</p>	<p>БТСХ, НХХ</p>	<p>30</p>	

байгуулна.		БИЕЛЭЛТ: Дүүргийн 1-6 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Иргэд, хүүхэд, залуучууд, ахмад настанд зориулсан Хөгжлийн төвийн зураг төсвийн ажлыг дүүргийн төсөвт суулгаж, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр Эйч Энд би констракшн консалтинг ХХК шалгарч, 59.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ЧДХААА ДТХ ЗҮ-21/08 дугаартай гэрээг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр байгуулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт Хөгжлийн төвийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр 32 гараашийг буулгаж газар чөлөөлөх ажил шүүхийн шатанд маргаан хэлэлцэгдэж байна.				
6.1.4. Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангах үүднээс нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг саравч бүхий тохилог орчинтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	174	6.1.4.1. Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангах үүднээс нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг саравч бүхий тохилог орчинтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	5	900.0	ТНААХ	100
6.1.5. Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, автозамын дэд бүтцийг сайжруулна.	175	6.1.5.1. Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, авто замын дэд бүтцийг сайжруулна.	2.5	3450.0	ТНААХ	100
		БИЕЛЭЛТ: Тайлант хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэл, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөв, дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр нийт 3240 м (3,24 км) авто зам шинээр тавигдаж авто замын дэд бүтцийг сайжруулан ажилласан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 11, 13, 14, 15, 17, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт "Гудамжны тохижилт, шинэчлэл", "Жишиг гудамж", "Хорооны доторх авто зам", "Хорооллын доторх авто зам" төсөл арга хэмжээнүүд хэрэгжиж 1256 у/м авто зам шинээр тавигдсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт "138 дугаар бага сургууль, 220 дугаар цэцэрлэг явах авто зам" төсөл арга хэмжээ хэрэгжиж 210 у/м авто зам шинээр тавигдсан. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 10, 11, 12, 14, 15, 16, 17, 18, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт "Гудамж сайжруулах" төсөл арга хэмжээний хүрээнд 1391 у/м авто зам шинээр тавигдсан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт "17 дугаар хорооны Сурагчийн 24-р гудамж авто зам, чулуун зам тавих" төсөл арга хэмжээ хэрэгжиж 150 у/м авто зам шинээр тавигдсан. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 233 у/м авто зам шинээр тавигдсан. Мөн Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлийн Замын хөгжлийн газар, Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-аас				

		6820 у/м авто замын засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэсэн. Дүүргийн нутаг дэвсгэр дэх гол болон туслах авто замуудын 5200м2 нүхэн эвдрэлийг засварлах, дүүргийн 24 дүгээр хороо, Жигжид зуслангийн замд 3000м2 асфальтан хучилтай авто замын ажлыг "Квадровэй" ХХК хийж гүйцэтгэсэн.			
6.1.6. Эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг цахилгаанаар хангах ажлыг үе шаттай судалж, хэрэгжүүлнэ.	176	6.1.6.1. Гэр хорооллын 7-19 дүгээр хороо, Байшин хорооллын 1-6 дугаар хорооны эрчим хүч хэрэглэгчдийн хүчдэлийн уналтыг сайжруулах ажлыг үе шаттай нэмэгдүүлнэ.	150 өрх	100.0	ТНААХ, УБЗАА
		<p>БИЕЛЭЛТ: Дүүргийн 2 дугаар хорооны ҮХ-12 дугаар байрны дахин төлөвлөлттэй холбоотойгоор "Мон-Тед констракшн" ХХК цахилгаан дамжуулах ХТП-118 дэд өртөө /ХТП-118 дэд өртөөг 1960 онд ашиглалтад оруулсан, ашиглалтын хугацаа дууссан/-ний барилга, тоноглолыг бүрэн шинэчлэн барих ажлын хүрээнд 630 кВА цахилгаан дамжуулах тэжээлийг 800 кВА болгон өргөтгөн шинэчилж 103 аж ахуйн нэгж байгууллага, 661 айл өрх, цахилгаан эрчим хүчний хүчдэлийн уналтыг бууруулсан.</p> <p>Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв нь төлөвлөгөөт урсгал засварын ажлын хүрээнд дүүргийн 17, 18, 19 дүгээр хорооны 3500 айл өрхүүдийн тоолуурын нэгдсэн 645 хайрцгийн ашиглалт, битүүмжлэл сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 115 байршил буюу 25 фидерийн 62 дэд өртөөний 115 тоолуурын нэгдсэн хайрцагт өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэж хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний найдвартай хэрэглээг хангах нөхцөл тодорхой хэмжээнд бүрдсэн. Мөн хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчний хангамжид шинээр холбох нөхцөл бүрдүүлсэн. Цахилгаан эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийн судалгааг 7-19 дүгээр хороодоос авч нэгтгэн шинэчилсэн. Тус судалгаагаар эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй 580 айл өрхийн мэдээллийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д 2/2286 тоот албан бичгээр хургүүлсэн. Дүүргийн 17, 18 дугаар хороодын иргэдийн хүсэлтийн дагуу айл өрхүүдийн цахилгаан эрчим хүчний уналтыг бууруулах зорилгоор УБЦТС ТӨХК-ийн Зүүн түгээх төвд 3/1283 тоот албан бичиг хургүүлэн ажилласан.</p>			100

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.НАРАНЗУЛ

НЭГТГЭСЭН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

З.ЗУЛГЭРЭЛ

